

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 08 дугаар сарын 20-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-63
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6-63

-
- 1. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ./* 6-43
 - 2. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./* 43-63

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 08 дугаар сарын 20-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 22 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Л.Мөнхбаатар;
Тасалсан: Э.Бат-Амгалан, Х.Баттулга, Б.Пүрэвдорж.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар хэлэлцэх асуудлын 3 дугаарт байгаа “Хүний эрхийн дэд хорооны дарга сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх асуудлаас хасах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэхээр тогтов.

Нэг. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Зам, тээврийн яамны Төрийн захиргааны газрын дарга Б.Болор-Эрдэнэ, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх Ц.Эрдэнэбат, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Уранчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Нандингэрэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ш.Батцэнгэл, референт Ц.Отгонбаатар нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Ц.Сандаг-Очир, С.Эрдэнэболд, Г.Уянгахишиг, Б.Бат-Эрдэнэ, Д.Ганбат, М.Нарантуяа-Нара нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Зам, тээврийн яамны Төрийн захиргааны газрын дарга Б.Болор-Эрдэнэ, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх Ц.Эрдэнэбат, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Уранчимэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нарагийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.4-т өөрчлөлт оруулах:

“авлигаас олсон орлогыг хураан авч, тухайн орлогыг Хүүхэд хамгаалах сан, Хүүхдийн Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэн зарцуулах” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, П.Сайнзориг нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 10
Бүгд: 16
37.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дэмжсэнээр тооцож, 43.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Дээрх саналтай холбогдуулан Байнгын хорооны дарга Д.Цогтбаатарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 14
Бүгд: 16
12.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3. Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтад “олон улсын ур чадварын үзүүлэлт” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Д.Ганбат нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4. Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай 4.2.1.8 дахь дэд заалт нэмэх:

“4.2.1.8. Авлигатай тэмцэх газрын салбарыг 21 аймагт байгуулах”

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 13
Бүгд: 16
18.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Хүний эрхийн Үндэсний комиссын дарга Д.Сүнжид, мөн комиссын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Д.Ёндонжамц, Улсын дээд

шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, мөн шүүхийн Сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг, Ерөнхий нягтлан бодогч А.Эрдэнэцэцэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, мөн зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Наранбилэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Ц.Давхарбаяр, мөн хорооны Ажлын албаны дарга Л.Мөнхзориг, Авлигатай тэмцэх газрын дэд дарга Г.Азжаргал, мөн газрын Ерөнхий нягтлан бодогч Т.Цэрмаа, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор С.Гансэлэм, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн дарга Г.Төгөлдөр, мөн комиссын Ажлын албаны дарга Л.Очирсүрэн, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Х.Лхагвасүрэн, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чойжилсүрэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга бөгөөд Хорих ял эдлүүлэх албаны дарга А.Намсаманд, мөн газрын Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Нямгомбо, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, Гадаадын иргэн, харьяатын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ аудитын хэлтсийн дарга З.Өнөрсайхан, Хууль зүйн туслалцааны төвийн захирал Л.Уянга, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын Аудитын менежер Ю.Энхтуяа, Л.Мөнхцацрал, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, мөн хэлтсийн ахлах шинжээч Д.Отгонжаргал, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн мэргэжилтэн С.Гэлэгжунай, Төсвийн орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Төгөлдөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ш.Батцэнгэл, референт Ц.Отгонбаатар нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, Ц.Сандаг-Очир, Дав.Цогтбаатар, Д.Ганбат, М.Нарантуяа-Нара нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Х.Лхагвасүрэн, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Хүний эрхийн Үндэсний комиссын дарга Д.Сүнжид, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Авлигатай тэмцэх газрын дэд дарга Г.Азжаргал, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор С.Гансэлэм, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн дарга Г.Төгөлдөр, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, Ц.Сандаг-Очир, Х.Баасанжаргал нар үг хэлэв.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Дам.Цогтбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XI.2.3.1.“Зэвсэгт хүчний тоног төхөөрөмж” /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2024-2024, төсөвт өртөг 40,576,3 сая төгрөг, санхүүжих дүн 40.576.3 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4.811.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн урсгал зардлыг нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Дам.Цогтбаатар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 48 минут минут үргэлжилж, 22 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 77.2 хувийн ирцтэйгээр 13 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 08 дугаар сарын 20-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим,
09 цаг 22 минут

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Дам.Цогтбаатар: Гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг эрье. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Ирсэн гишүүдээс Дамдины Цогтбаатар, Хүрэлбаатарын Баасанжаргал, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Мөнхтөрийн Нарантуяа, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахушиг, Даваагийн Цогтбаатар, Баттөмөрийн Энхбаяр, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн гишүүдтэйгээр ирц бүрдсэн байна. Ирц 54,5 хувьтай байна. Ингээд ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн даргын дэргэдэх зөвлөлөөр батлагдсан хэлэлцэх асуудал бол 3 асуудал байгаа.

1 дэх нь “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл/Засгийн газар 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/Санал, дүгнэлт юмнуудаа бол бид нар хэлэлцээд явчихсан байгаа.

2 дугаар асуудал бол Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт

оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хууль байгаа.

3 дахь асуудал нь бол “Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны даргыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа.

Тэгээд энд ийм 3 асуудал байж байгаа. Тэгээд хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүд байна уу. Нара гишүүн тэгвэл юугаа дарчих уу. Нара гишүүний микрофоныг өгье.

М.Нарантуяа-Нара: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Тэгэхээр “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг цаг үеэ олсон, яг өнөөгийн нөхцөл нийгмийн нөхцөл байдалд тулгамдаж байгаа асуудлыг цогцоор нь шийдэх гэж хичээсэн, тал бүрээс нь харж судалж боловсруулаад өмнөх туршилагуудыг нэлээн сайн багтааж өгсөн байдалд нь бол бүхэлд нь ер нь дэмжиж байгаа.

Тэгээд тэр дундаасаа 4 дүгээр бүлэгт тусгасан хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хүрээнд авлигатай тэмцэх “5ш” ажиллагаа буюу нөгөө шүүр, шувуу, шилжүүлэн авах ажиллагаа, шилэн ажиллагаа гээд ийм юмнууд байгаа шүү дээ.

Дам.Цогтбаатар: Нара гишүүн ээ. Бид нар асуудлаа хэлэлцэж эхлээгүй. Хэлэлцэх асуудлаа л ярьж байна шүү дээ. Өөрөө агуулга руу ороод явчих гээд байх шиг байна. Арай болоогүй байна.

М.Нарантуяа-Нара: За тэгвэл би дараагийнх дээр нь ярих юм байна.

Дам.Цогтбаатар: Тэгэхээр хэлэлцэх асуудлаар тэгвэл өөр санал хэлэх гишүүн байхгүй байсан. Би харин нэг хэлэлцэх асуудлын талаар горимын санал гаргахгүй бол болохгүй байна.

Энэ 3 дахь асуудал Хүний эрхийн дэд хорооны асуудал дээр бол нөгөө бүлгүүд эцэслэн саналаа оруулж ирээгүй байгаа учраас энэ удаагийн хуралдааны хэлэлцэх асуудлаас энэ 3 дахь асуудлыг хасаж, түр хойш хойшлуулах саналтай байна. Энэ дээр санал хурааа. Тэгээд энийг ингээд хойшлуулъя гэсэн томъёоллоор санал хураамаар байна. 91,7 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд хэлэлцэх 1 дүгээр асуудал.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудлын материалууд бол та бүгд танилцсан, тараагдсан байж байгаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Сонор, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч Отгонжаргал, Сангийн яамны төсвийн нэгтгэлийн хэлтсийн мэргэжилтэн Гэлэгжунай, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн Төгөлдөр гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ирсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлахтай холбогдсон ирсэн энэ ажлын хэсгийн гишүүдийг уншаад танилцуулчихъя. Оюунсайханы Алтангэрэл Хууль зүй, дотоод хэргийн сайд. Манай байнгын хорооны гишүүн байгаа. Дагвадоржийн Ганхуяг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ханджавын Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн

бичгийн дарга, Лханаажавын Мөнхтүшиг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Чимэдицэрэнгийн Цэвэгдорж Спорт, соёл, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сандагийн Магнайсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нансалын Тавинбэх Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга. Энэ Төрийн нарийн бичгийн дарга нар чинь бүгд ирчихсэн байгаа юу. Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Эрдэнэбулган, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Даваасамбуугийн Эрдэнэбаяр Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Зэнээмэдэрийн Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын дарга, Доржпаламын Гантулга Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын дарга, Баасанжавын Болор-Эрдэнэ Зам, тээврийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Мэндбаяр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уурхай бодлогын газрын дарга, Тогоогийн Гантогтох Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Бодлого төсөөллийн хэлтсийн дарга, Дугаржавын Амгалан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Цэвээндоржийн Эрдэнэбат Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх, Пэрэнлэй Мөнхбат Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын зөвлөх, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн

яамны Татварын бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч бөгөөд Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийн гишүүд оролцож байна. Ингээд албан тушаалтнуудыг танилцууллаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Ингээд “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Асуулт асуух гишүүд байна уу. Сайнзориг гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Баярлалаа. Бүгдэд нь бас өглөөний мэнд хүргэе. Улсын Их Хурлын тогтоолын хавсралт руугаа л би орох гээд байна л даа. 1 дүгээр зүйл маань угаасаа бас яг энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах асуудал явагдаж байгаа. Би 4 дүгээр бүлэг дээр тухайлан 2, 3 асуулт асуучихъя. 4.1.1, 4.1.3 буюу жагсаал цуглаан хийх зөвшөөрөл олгодог тогтолцоог бүрмөсөн хална гээд биччихжээ. Манай жагсаал цуглаан хийхдээ зөвшөөрөл олгодог тогтолцоо Монгол Улсад байхгүй. Ийм агуулгыг хаанаасаа олж бичээд, олон нийтийг ингээд төөрөгдүүлэх асуудал яриад байна. Харин жагсаал цуглааныг хийх асуудлыг бол бүртгэлжүүлэх асуудал бол байгаа. Бүртгүүлж байж жагсаал цуглааныг хийх асуудал байгаа. Бүртгэл болон зөвшөөрөл өгөх 2 асуудал чинь тэс ондоо асуудал шүү. Тэгээд ингээд нэг ийм

жоохон тийм агуулгын хувьд иргэд, олон нийтийг төөрөгдүүлээд, анхнаасаа нэг ийм зөвшөөрөл олгодог байсан юм шиг ийм юм яриад байна. Тэгэхээр би энэ асуудлыг бол яах вэ, агуулгын хувьд жагсаал цуглаан хийх журмын асуудлыг бол сайжруулахыг бол бүрэн дэмжиж байна. Би өөрөө бас Хууль зүй, дотоод хэргийн яаманд ажиллаж байхдаа Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг өөрөө яг гардаж бичсэн байдаг юм.

Би Алтангэрэл сайд байгаа дээр бас нэг зүйлийг бас хэлээд авъя гэж бодож байна. Ер нь энэ жагсаал цуглаан хийх асуудал бол ерөнхийдөө олон нийтийн газар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний нэг л тодорхой хэлбэрүүд байгаа. Тэгэхээр өнөөдөр олон нийтийн газар дээр үзэл бодлоо илэрхийлэхэд жагсаал хийж болно, цуглаан хийж болно, заримдаа ингээд ганцаараа одоо нэг тэ хаяг, ийм уриа лоозон бариад зогсоход хүртэл энэ жагсаал уу, цуглаан уу гэдэг маргаан гардаг. Өлсгөлөнгийн хэлбэрүүд байгаа.

2 дугаарт яах вэ, нөгөө багаж хэрэгслээ тавьчихдаг. Трактороо оруулж ирээд тавьдаг, эсвэл ажил хөдөлмөр, энэ өөрөө цуглаан уу, жагсаал уу гээд ингээд явахаар энэ жагсаал цуглаан гэдэг агуулгадаа бас энэ зарим үзэл бодлоо илэрхийлэх энэ хэлбэрүүд маань ерөөсөө багтаж өгдөггүй юм аа. Бас энэ зохицуулалтад оруулахад хэцүү байдаг. Тэгэхээр энийг бусад оронд бол олон нийтийн газар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай хууль гээд хийчихдэг тал бий. Эндээ бас энэ асуудлаа ингээд багтаадаг. Монгол Улсын Үндсэн хуулиар ч гэсэн жагсаал цуглаан хийх журмын асуудлыг зүгээр хуулиар тогтооно гэсэн болохоос тухайлан жагсаал цуглаан хийх журмын тухай гэж нэртэй хууль гаргана гэж ерөөсөө байхгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр олон нийтийн газар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай гэдэг байдлаар хийх, эргээд энэ бүртгэлжүүлэх асуудлыг улс төрийн албан тушаалтан

буюу шат шатын Засаг дарга бүртгээж авч байгааг болиод хууль сахиулах байгууллагадаа мэдэгдээд жагсаал цуглаанаа хийх энэ эрх зүйн орчин руу орох, мөн өдрийн цагаар энэ жагсаал цуглаан хийх соёлд шилжих гэдэг юм уу ийм зүйлүүдийг уг нь багтаасан нэлээн бас яах вэ, 2, 3 жил энэ судалгааг нь хийсэн ийм хуулийн төсөл бол Хууль зүй, дотоод хэргийн яам дээр бэлэн байх учиртай. Тэгэхээр энэ хуулийн төслийг бас оруулж ирэх бололцоо нь байгаа юу. Энийг бас энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээрээ бас эргээд нэг.../минут дуусав/

Дам.Цогтбаатар: Яах вэ гүйцээх үү. Тэгье. Алтангэрэл сайд хариулах уу.

О.Алтангэрэл: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Үнэхээр жагсаал цуглаан бол олон төрөл байгаа. Бид нар жагсаал гэдэг нэрийн дор ойлгох зүйлүүд ч олон байгаа. Цуглаанаа яаж ялгах юм. Суулт руу шилжээд ирвэл яах юм. Хэн нь гэр бариад, хэн нь майхан бариад, хэн нь хөөгдөх юм гээд. Үгүй ээ, үнэн л дээ. Одоо хууль дээр жишигээр зөвшөөрөл олгодог, зөвшөөрөл аваад явдаг гэдэг юм байхгүй. Аль нэг дүүргийн Тамгын газарт хандаад таны жагсаал цуглааныг бүртгээж авлаа гэдэг бичиг өгөнгүүт жагсаал цуглаан хийж байгаа. Бүртгэхгүй гэдэг нь олон байгаа. Өнгөрсөн жил гэхэд 200 гаруй хүсэлт ирсэн юм байна лээ. Тэгээд бид нар яах вэ, хууль дээрээ ингээд зөвшөөрөл олгоно гэж бичээгүй ч гэсэн нидэр дээрээ энэ зөвшөөрөлгүй гээд цагдаа нар нь албадан тараагаад, асуудал хэлээд байгаа учраас энэ тогтолцоо маань зөвшөөрөл олгодог тогтолцоо байна гэж томъёолоод л оруулчихсан нь энэ юм байгаа юм.

Ерөнхийдөө жагсаал цуглаантай холбоотой асуудлыг саяын агуулгаар нь Сайнзориг гишүүн маань дэмжиж байгаа юм байна. Тэгэхээр энэ нэр томъёог бол өөрчилж болно. Тэгэхдээ бид нар бодит амьдрал дээрээ яг гарцаа

байхгүй зөвшөөрөл авч л ер нь жагсааж байна гэдгээ бодох ёстой байх.

Хууль зүйн яам дээр бол урьд нэлээн явуулчихсан төсөл байна лээ. Тэгээд манай Сайнзориг гишүүн урьд урьдын сайдууд аль аль нь анхаарал тавьж ингээж явуулж байсан юм байна лээ. Дахиад ажлын хэсгийг нь шинэчлээд, иргэний нийгмийн байгууллагуудаас төлөөллийг нь оруулаад ингээд энэ үйл ажиллагаа эхэлсэн. Тэгээд хэлж байгаа нэр томъёоны асуудлыг тусгахад анхааръя.

Дам.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье. Тодруулъя.

П.Сайнзориг: Алтангэрэл сайдад бас баярлалаа. Бас жагсаал цуглаан, хэвлэлийн эрх чөлөөний хууль гээд бас Хууль зүй, дотоод хэргийн яам дээр бас боловсруулж байсан энэ хуулиудыг нэлээн түлхэж урагшлуулна гэдэг дээр би бас байр сууриа илэрхийлж байгаад нь бас баяртай байгаа. Ер нь зүгээр хүний эрх чөлөөний бүлэг дээр бид хэд бас яг тодорхой практик зүйл хувьд бас их яримаар байна. Өнөөдөр буруу рультэй машин буюу энэ орон нутгийн зам дээр гүйцэд түрүүлэх гэж байгаад автын осолд орж байгаа хэдэн хүний амь эрсэдэж байж энэ асуудлыг нэгмөсөн I талтайгаар шийдэх юм бэ. Энэ асуудлыг бас энэ Засгийн газрын холбогдох хүмүүс бодитой шийдмээр байна. Энэ машиныхаа импортын асуудалд тавих стандарт, олон улсын гэрээгээ бас мөрддөг болмоор байна.

2 дугаарт энэ орон сууцуудыг улсын комисст хүлээж авч байгаа асуудлыг зургийн компанид нь нэгмөсөн хариуцуулмаар байна. Энэ зургийн компани чанар муутай барилгыг ашиглалтад оруулах асуудлыг нэгмөсөн өөрөө яг хар толгойгоороо хариуцмаар байна. Тэгээд энэ чанар муутай барилга ашиглалтад оруулах гэмт хэрэг байдаг. Нэг ч хүн шалгагддаггүй. Битүү чанар муутай барилга. Хүний өмчийн эрх

ерөөсөө энэ цаана нь асар ихээр зөрчигддөг. Урд талдаа цэцэрлэгт хүрээлэнтэй гэж барьчихаад тэр дээрээ барилга барьчихдаг энэ ч.../минут дуусав/

Дам.Цогтбаатар: Ингээд тодруулаад санал хэлчхээж байна. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье. Гишүүд ээ, 1 юм хэлмээр байна. Одоо ингээд хэдүүлээ дэгийн журмаа барина шүү. Хууль зүйн байнгын хороо дэгийн журмаа барихгүй, мэдээж би гишүүдийнхээ эрхийг хүндэтгэнэ. Гэхдээ 1 удаа Сандаг-Очир гишүүнд өгье. Асуулт асуух боломж байхад тэр үедээ л асууна шүү. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Энэ мөн л 4 дүгээр бүлгээс асуух юм.

4.1.5. Парламентын засаглал ба эрх мэдлийн хяналт тэнцэл гээд. Энэ дээр энэ улс төрийн намуудын хатуу гишүүнчлэлээс татгалзаж, санхүүжилтийг ил тод болгоно гэж. Энэ ер нь ямар түвшинд яригдсан юм бэ. Улс төрийн намуудын хатуу гишүүнчлэлээс түдгэлзүүлэх асуудлыг ганц 1 сайд нар оруулж ирээд хийчихдэг асуудал биш гэж би хувьдаа ойлгож байна. Энэ чинь олон 100 мянган гишүүнтэй улс төрийн намууд байгаа шүү дээ. Энэ чинь гишүүдээсээ асууж байж ингэж байж хийдэг ажил шүү. Тэгээд өнөөдөр бас хатуу гишүүнчлэлээс татгалзах эрх зүйн орчин хэр бүрдсэн юм. Энэ дээр Хууль зүйн сайд ямар бодол, байр суурьтай байгаа юм. Яг энийг цаашидаа ямар арга барилаар хэрэгжүүлнэ гэж үзэж байгаа юм бэ 1-д.

2-т шүүх засаглал.

4.1.6.4 дээр шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагааг олон улсын сайн жишигт хүргэнэ гэж. Ингээд л үе үеийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хараад байхад яваад л байгаа. Яг амьдрал дээрээ шүүхийн шийдвэр хэрэгжихгүй байна. Эрүү дээр, Иргэн

дээр. Иргэн дотроо эд хөрөнгийн маргаан, гэр бүлийн маргаан, газрын маргаан үгүй ээ, юу хэрэгжихгүй байна. Шүүхийн шийдвэр л хэрэгжихгүй байна шүү дээ. Тэгээд ингээд нэг ганц өгүүлбэр тавьчихсан. Олон улсын сайн жишиг гээд. Олон улсын сайн жишиг нь ямар сайн жишиг хэрэгжүүлэх гэж байгаа юм тэгвэл. Одоо 2 чихээ авахаас өөр өгөх хүнгүй хүнийг яах юм. Ер нь яг шүүхийн шийдвэрийг яаж биелүүлэх юм. Тэгээд цаана нь ард иргэд хохироод байдаг. Шүүхийн шийдвэр гараад байдаг. Ингээд үндсэндээ шүүхийн шийдвэр гараад, хэрэгждэггүй. Ард иргэд яах вэ гэхээр ерөөсөө шүүх засаглалд итгэх итгэл алдардаг. Тэгээд нөгөө хохироосон нөхөр сайхан гадуур яваад байдаг. Хүний эд хөрөнгийг, гэр бүлийн асуудал, газартай холбоотой асуудал, амь нас, эрүүл мэндтэй холбоотой хохироочоод ямар ч хариуцлага хүлээхгүй яваад байгаа энэ асуудал дээр та бүхэн шүүх засаглалын хүрээнд ямар тодорхой арга хэмжээ авч энэ байдлыг таслан зогсоох юм бэ. Энэ дээр одоо Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга байж байх шиг байна. Хууль зүйн сайд байж байх шиг байна. Энэ дээр хариулт өгөөч.

Дам.Цогтбаатар: Алтангэрэл сайд хариулах уу.

О.Алтангэрэл: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэл нэн ялангуяа иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой асуудал сүүлийн 20 жилийн турш манай системийн хамгийн тулгамдсан асуудал байж ирж байна. Та их зөв асуудал хөндөж байна. Эрүүгийн хэргийн шийдвэр гүйцэтгэл бол ямар ч асуудалгүй. Хорих ял эдлүүлэх үйл ажиллагаа 100 хувь биелээд явж байгаа. Хорихоос бусад төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хэрэгжээд явж байгаа. Хамгийн их асуудалтай байгаа нь иргэн. Сүүлийн үед захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэлийн асуудал. Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэл дээр жишигээр ажлалтны эргүүлэн томилох

шийдвэрийг биелүүлдэггүй асуудал хавтгай байна. Хэн бэ гэхээр нөгөө субъект. Монголын төр, албан тушаалтнууд. Ажилд эргүүлэн томилох шийдвэр биелдэггүй. Үүнийг жишээлбэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага асуудлыг тавиад шийдүүлье гэхээр Хууль зүйн яамтай холбоотой шүүхийн шийдвэр байх жишээтэй. Хууль зүйн яамтай холбоотой гарчихсан шүүхийн шийдвэр хэрэгжихгүй өчнөөн удчихсан байх жишээтэй. Тэгээд Хууль зүйн яам нь болохоор яаж ч чаддаггүй. Энэтэй адилхан Засгийн газар, бусад байгууллагатай холбоотой гээд ингээд тоочоод байвал асуудал их байна.

Тэгээд би их сайн санадаг юм 2004 оны үед санаж байна. Нямдорж сайд нэг сонинд ярилцлага өгч байсан юм. Шийдвэр гүйцэтгэл гэж хэцүү газар байна гээд 20 жилийн өмнө. Сайд дээр ирдэг өргөдөл, гомдлын дийлэнх хувийг эзэлж байна гээд өнөөдөр яг байдал хэвээрээ байна. Би яг өөрөө судалгааны ажил хийж байх явцдаа 1997, 1998 онуудад Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос шийдвэр гүйцэтгэх байгууллагын тухайн үеийн шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын үйл ажиллагаанд хийсэн шалгалтын материал үзэж байсан юм. Яг таны хөндөж байгаа асуудлыг 1997 онд яриад сууж байсан юм байна лээ. Тэгэхээр бид бол энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг зайлшгүй ярина. Ярихдаа хоёрхон төрлийн юм яриад байдаг. Шийдвэр гүйцэтгэгчийг урамшуулалтай болгохоор юм биелэх гээд байгаа юм шиг. Урамшууллыг өгнө, өгөхгүй гэдэг дээр тойрч яриад байдаг. Энийгээ больё. Сайн судалъя гэсэн юм. Судлах судлахдаа бид нар ижил төстэй эрх зүйн системтэй орнууд тухайлбал Германаас авъя. Тэгээд ер нь энэ шүүхийн шийдвэр зайлшгүй биелэгддэг больё. Нэн ялангуяа хүүхдийн тэтгэлэгтэй холбоотой гээд. Ер нь энэ шүүхийн шийдвэрийн төрөл болгоноор процессыг нэлээн хуульчлаад сайжруулъя гэж байгаа юм. Тэгэхээр бид бол энэ дээр

ахиц гаргана. Гаргахаас өөр аргагүй гэсэн ийм итгэлтэйгээр энд тавьсан юм. Тэгэхээр бол энэ Засгийн газрын үед Монгол Улсын иргэний болоод захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэлд бол ахиц гарна гэж бид бүрэн итгэлтэй байгаа учраас зорилт болгоод тавьсан гэдгээ хэлье.

Улс төрийн намын хатуу гишүүнчлэлийн хувьд бол энэ намын мөрийн хөтөлбөрт байгаа. Тэгээд зорилт болгоод тавьчихсан. Бид нар энэ намууд маань Улс төрийн намын тухай хуультай зохицуулаад дүрмээ өөрчлөх ёстой. Тэгээд эндээ зохицоод цаашаагаа зорилт болгоно гээд намын мөрийн хөтөлбөрөөс оруулсан гэдэг шалтгаанаа хэлье.

Дам.Цогтбаатар: Ингээд 1 дүгээр зүйлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа.

Би энэ дээр харин бас Алтангэрэл сайдын ярьсантай холбогдуулаад 1 зүйл нээрээ хэлчихмээр байгаа юм. Жагсаал цуглаантай холбогдсон зөвшөөрлийн тухай асуудал. Хууль дээр зөвшөөрөл гэж байхгүй боловч бодит хэрэгжүүлэлт дээрээ зөвшөөрлийн эффе́кттэйгээр хэрэгжээд байгаа хуулийг бол үг нь байхгүй ч энэ зөвшөөрлийн тогтолцоотой байна л гэсэн үг шүү дээ. Одоо энэ Алтангэрэл сайдын саяын хэлж байгаа хэдэн удаа бүртгэлгүй буцаачихсан байна гэнэ ээ. 200 удаа буцаана гэдэг чинь, 200 удаа зөвшөөрөөгүй байна шүү дээ яг бодит амьдрал дээрээ. Тэгэхээр үг байхгүй гэдэг хуулийн агуулга өөрөөр практик дээрээ хэрэгжээд яваад байгаа бол энэ зөвшөөрлийн л систем гэсэн үг. Тэгэхлээр энэ харин Засгийн газраас оруулж ирж байгаа энийг нь өөрчилнө. Тэр бичсэн үгэндээ тааруулж үйл ажиллагааг нь өөрчилнө гэж оруулж ирж байгааг бол маш зөв гэж үзэж байна шүү. Тийм учраас энэ дээрээ бол би бас өөрийн байр сууриа хэлье гэж бодлоо.

Ингээд ажлын хэсгээс 1 дүгээр зүйл дээр бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал байхгүй.

Тогтоолын төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Сайнзориг гишүүнээр таслалаа. Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

Энэнээс өмнө би нэг зүйл хэлье. Одоо ингээд хэдүүлээ яг ... Эрдэнэболд гишүүний юуг түр зогсоож байгаарай. ... Одоо яг дэгийнхээ дагуу асуулт асуух бүртгүүлээд л ахиад хойноос хоцорч орж ирчхээд би үг хэлмээр байна гэж ингэж нэмэхгүй шүү. Яг энэ дэгээ хэдүүлээ бариад явна гээд гишүүддээ хэлмээр байгаа юм. Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэболд: Асуулт, үг нь нэг юм байна шүү Ганбаа дарга аа. Хууль зүйн сайд аа, нэг ийм юм байгаад байна. Одоо ингээд барууны орнуудад ихэвчлэн нэг ийм туршилага байгаад байдаг. Өргөн нийтийн телевизээр бүр ингээд жилд бүр төсвийг нь тавьж байгаад, баримтат кинонууд их гардаг. Тэр нь болохоор хүний эрхийг хангах чиглэлийн боловсролыг түгээсэн, 2 дугаарт нь элдэв төрлийн экстремистүүд мөн нацизмын хор хохирлыг таниулсан 20 дугаар зууны 1, 2 дугаар дайнаас өгсүүлээд, ер нь тухайн Европт болсон хүнд нөхцөл байдал тэр гамшигийн хор уршигийг, дайны хор уршигийг ингээд гаргасан ийм кэйсүүд яваад байдаг. Манай Монголд болохоор яаж байна гэхлээрээ Алтангэрэл сайд аа, нөгөө хүмүүс хүний эрх, эх оронч үзэл, үндэсний үзэл, үндсэрхэг үзэл, шовинизм гээд ингээд бүгдийг нь боловсролын хувьд сайн ялгахгүйгээс болоод маш их тийм ийм экстремист үйл явдлууд болдог. Тэгээд үүнээс үүдээд жишээлбэл юу гэдэг юм жагсаал цуглаан хийх нэрийдлээр түүнээс халхавчилсан маш олон төрлийн өдөөн хатгасан улс орны тусгаар тогтнолтой холбоотой зүйлүүд ч болох тийм нөхцөл байдлууд үүсчхээд байдаг. Тэгэхээр энэ дээр юу гэж хэлэх гээд

байна гэхээр, ер нь Хууль зүй, дотоод хэргийн яам яг энэ соён гэгээрүүлэх боловсрол руу чиглэсэн энэ төсвүүд орж ирж байна шүү дээ. Энэ тодорхой хэмжээний юмнууд байгаа юу. Мэдээж энд бол хууль сахиулах, хууль хэрэгжүүлэх байгууллагын ингээд харж байхад тэр аймгийн Цагдаагийн газрын төсөв, энэ хууль сахиулах болон хэрэгжүүлэх байгууллагуудын ингээд жилийн төсвүүд орж ирж байгаа. Энэ дээр энэ хууль хэрэгжих орчин нөхцөл, хууль хэрэгжих орчин нөхцөлийг сайжруулах, олон нийтэд мэдээлэл түгээх энэ чиглэлүүд хэрэгтэй байгаад байна. Ингээд харж байхад бол Экологийн цагдаагийн алба л фэйсбүүк дээр идэвхтэй ажиллаад байдаг. Хааяа нэг Авлигатай тэмцэх газрын юмнууд гарч байдаг. Бусад чиглэлээр юмнууд байхгүй. Иргэд мэдэхгүйгээсээ болж маш их хохирдог байдал үүсчхээд байгаа.

Дээрээс нь болох юм бол өсвөр насны хүүхдүүдийн дунд энэ хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ жилээс жилд нэмэгдээд байдаг гээд байдаг. Хаалттай сэдэв байгаад байдаг. Тэгээд гэх мэт сэдвүүд дээр яг энэ соён гэгээрүүлэх чиглэл, сургалт судалгааны чиглэл, ялангуяа энэ арилжааны телевизүүд чинь асар их өндөр зардалтай байдаг. Энэ дээр жишээлбэл ямар төсвүүд байх вэ. Ямар контентууд байх вэ. Хэрэг гарсны дараа ингээд хорьдог, цагддаг гэхээсээ илүүтэйгээр гаргах орчин нөхцөлийг нь багасгах чиглэлээр ямар төсөв хөтөлбөрүүд байх вэ. Энэ дээр ер нь өмнөхөөсөө ямар ахицтай зүйл байх вэ гэдэг асуулт.

Дам.Цогтбаатар: Алтангэрэл гишүүний микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Эрдэнэболд гишүүнд баярлалаа. Их сайн асуулт байна миний хувьд. Ер нь Монгол Улс энэ хууль тогтоомжийнхоо сурталчилгааны чиглэлээр их тааруухан анхаарч ирж үү дээ гэж боддог. 4 жил тутамд яг ингээд бид нар Засгийн газрын үйл ажиллагааны

мөрийн хөтөлбөр баталдаг. Хууль зүй, дотоод хэргийн яам маань өөрийнхөө стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлахдаа дандаа хууль тогтоомжийн сурталчилгаа гэж ордог. Тэгээд энэ асуудлыг үзэхээр Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль зүйн туслалцааны төв дээр 3 орон тоо, Хууль зүйн үндэсний хүрээлэн дээр 5 орон тоо, тэгээд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл дээр 4 орон тоо, ер нь бол хууль тогтоомжийн сурталчилгаа гэсэн нэрийн доор өөр ажил хийгээд ингээд байж байдаг. Монгол Улсын Засгийн газар хууль тогтоомжоо баталчхаад, сурталчилгаанд нь бас тааруухан анхаарч ирсэн юм болов уу гэж ингэж бодож байгаа.

Өнөөдөр хорих байгууллагад ял эдэлж байгаа залуучуудын дунд үзэхээр анх удаагийн гэмт хэрэгтэй, анх удаагаа ял шийтгэгдсэн 70 орчим залуучуудын яах вэ, өөрсдийнх нь асуулгаар л даа. 70 орчим хувь нь 63 хувь нь энэ нь гэмт хэрэг гэж мэдээгүй гэдэг ийм зүйл хариулж байгаа юм. Насанд хүрээгүй этгээдтэй бэлгийн харьцаанд ордог, бусдынхаа гар утсыг, гар утас болон эд хөрөнгийг авдаг. Зодоон хийж биед нь гэмтэл учруулдаг энэ үйлдлүүдээ бол яг ингээд шоронд орчихно гэж бид нар бодоогүй гэдэг байдлаар хариулж байна гэдэг бол бид нар энэ хууль тогтоомжийн сурталчилгаа энэ жишээ бол ганцхан Эрүүгийн хуультай холбоотой асуудал. Гэтэл нийгмийн харилцааг зохицуулж байгаа асар олон хууль байна. Хууль тогтоомжийн талаар мэдлэггүй байна. Жишээлбэл, Хөвсгөл аймагт гарсан бараг 40, 50 тэрбумаар хохирол нь тоологдож байгаа Бэлтэс мөрөн гэдэг энэ хэрэг одоо шүүхийн шатанд явж байна. Тэгэхээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас энэ асуудалд анхаарах хэрэгтэй гэж үзээд, орон тоогоо нэмэлгүйгээр дотроо бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийгээд, хууль тогтоомжийн сургалт сурталчилгааны газар гэж газар шинээр яамандаа хийгээд, 4 хүнтэй газар

байгуулаад тэгээд энэ асуудалд анхаарахаар байгаа. Энэ жилийн төсөв дотор бол үүнтэй холбоотой ямар нэг мөнгө байхгүй. Тэгэхдээ бид нар 2025 оныхоо төсөвт яг хууль тогтоомжийн сургалт сурталчилгааны чиглэлээр тэгэхдээ дан ганц Хууль зүйн яам хийхгүйгээр бусад байгууллагуудтай хамтарч энэ асуудлыг хийнэ гэдэг байдлаар оруулж ирэх төлөвлөгөөтэй байгаа.

Дам.Цогтбаатар: Болсон уу. Нэмж болно. Эрдэнэболд гишүүний микрофоныг нэмж өгье.

С.Эрдэнэболд: Баярлалаа. Хууль зүйн сайдад. Гол нь болохоор ингээд орон тоо гаргаад ажил хийх гэж байгаа нь бол болж байна. Гэхдээ энэ дээр бол Хууль зүйн байнгын хорооны бас даргадаа бас хандаж хэлэхэд, ер нь яг та өөрөө мэдэж байгаа шүү дээ. Ийм контентуудыг ингээд бүр ингээд хийж байдаг шүү дээ. Одоо Нетфлекс орж байгаа кинонуудын зарим тэр нацизмын хор хохирлын холбогдолтой кинонууд зарим нь Европын Холбооны санхүүжилт эд нараар ингээд хийгдээд байдаг. Яагаад гэхээр бол энэ хор хохирлыг нь л тайлбарлах, таниулах зорилготой яваад байдаг. Манайд болохоор яг энэ чиглэлийн контентууд бол аягүй ховор байгаад байдаг учраас Хууль зүй, дотоод хэргийн яамны төсөвтөө тэнд ажилтан, албан хаагчид ажиллуулах судлахаас гадна олон нийт рүү чиглэсэн энэ контент гэдэг зүйлийг төлөвлөж, тооцож, оруулж ирээд явахгүй бол өнөөдөр манайх үндэсний асар их доройтолд орчихсон, маш их популизмтай, маш их улс төржилттэй. Ерөөсөө хүний эрх, эрх чөлөөнийхөө үнэ цэнийг мэдрэхгүй, мэдэхгүй. Нэг бол аягүй хүний эрх ярьж туйлираад, нөгөө талд нь аягүй их тийм үндсэрхэг үзэл ярьж туйлираад, голын баланс алдагдчихаад байгаа учраас энэ дээр олон нийт, залуучуудыг соён гэгээрүүлэх, мэдээлэлжүүлэх контентын төсвийг тусад нь оруулж ирээд, мэргэжлийн

хүмүүстэй яриарай л гэдгийг л хэлэх гээд байгаа юм. Баярлалаа.

Дам.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Баярлалаа. Би зүгээр ярианы эхэнд Цогтбаатар дарга аа, та бас тайлбаруудаа ийм алагчлалгүй өгөх нь зөв байх. Бүртгэл, зөвшөөрөл 2 өөр. Тэгэхээр үүний цаана ингэж агуулгаар орж ирэх нь зөв ч гэдэг юм уу ийм зүйл байж болохгүй ээ. Хууль зүйн үр дагавар одоо байгаа хуулийн тухай алагчлалгүй бид нар мөрдүүлж, тэрийг л ярих ёстой. Тэгэхээр үүний цаана ийм юм байжээ гэдэг бол энэ чинь өөрөө эргээд энэ яриа баримт болгон дараа нь Олон улсын байгууллага дээр баримт болж очиж байдаг. Тэгэхээр би бол энэ дээрээ бас Байнгын хорооны даргын хувьд та бас хариуцлагатай байгаач ээ. Магадгүй үүний цаана зөвшөөрлийн тийм эффektүүд бол байгаа гэдэгтэй би бол хүлээн зөвшөөрч байна. Тэгэхдээ үг, үсэггүй энийг тийм байна, энэ агуулгаар бид ойлгоод явах ёстой гэж ерөөсөө ярьж болохгүй байх гэж би 1 дүгээрт бодож байгаа юм.

2 дугаарт түрүүн нөгөө бид хэд энэ иргэдийн өмчийн эрхийг хамгаалах асуудал дээрээ бас анхаармаар байна. Ялангуяа нөгөө бизнесийн байгууллагатай хэрэглэгч гэрээ байгуулж, үл хөдлөх хөрөнгө авч байгаа, зуучлал буюу тэр дундаа эрүүл мэндийн үйлчилгээ авах зуучлал хийж байгаа, сургалтын гэрээнүүд буюу энэ зүйлүүдийн буюу хэрэглэгчийн гэрээний асуудлаас болж хохирч байгаа иргэдийн эрхийг хамгаалах асуудлыг дурдаж, тухайлан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт орох ёстой юм. Энэ үл хөдлөх хөрөнгүүд чинь жишээ нь урдаа цэцэрлэгтэй байна, саадтай байна, эндээ ингэж авто зогсоолтой байна гэххээд, байраа борлуулсныхаа дараа шууд тэр дээрээ төрийн байгууллагуудтай хуйвалдаад, буцаагаад дахиад 1 юм уу, 2 блок барилга

барьчихаж байгаа байхгүй юу. Энэ бол худалдах өмнө нь тэр борлуулсан барилгын асуудал бол бүгд залилан.

Манай бүх барилгын компаниуд ийм байдлаар залилан хийж байгаа. Тэгэхээр энэ асуудлуудыг анхаараач ээ.

2 дугаарт энэ барилгуудыг улсын комисст авах энэ асуудлыг зургийн авторт нь бүрэн хариуцуулаад, бүрэн хариуцдаг даатгалын системтэйгээ уядаг. Эргээд энэ чанар муутай барилгыг ашиглалтад оруулсан энэ ял хариуцлага хүлээсэн хүн нэг ширхэг ч Монголд байхгүй байгаа. Үүнийг хүртэл бид нар жоохон бодолцож, энэ барилгын компаниудыг хариуцлагатай болгох талаас нь анхаарч, энэ зүйлүүд рүү явахгүй бол иргэд насаараа төлж байгаа энэ ипотекийн асуудал дээрээ хохироод байна.

2 дугаарт би тодоос тод санаж байгаа юм. Энхбаяр гишүүн дуусаагүй барилгыг улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ гаргаж дараагийн хөрөнгө татах хэрэгсэл болгохоос бас түдгэлзсэн юм. Тухайн үедээ яах вэ, барилгын компаниудын үйл ажиллагаа доголдох, хөрөнгө оруулалтаа татаж чадахгүй гэж байгаа боловч нөгөө талдаа яг энэ асуудлаас болж юу вэ гэхээрээ практик дээр 1 байрыг 2-3 этгээдэд зарж, ерөөсөө энэ жижиг барилгын компаниуд хооронд нь ерөөсөө асуудлуудыг иргэдийг шүүхээр яв гэдэг заваан юмаар хандаж байгаа зүйл бий. Тэгэхээр магадгүй яг орон сууцын зориулалттай барилгуудыг бол тодорхой хувийг нь борлуулалтыг хязгаарлах эсвэл магадгүй тэр үйлчилгээ, худалдааны бизнесийн, арилжааны зориулалтыг нь бол тэр яг явдаг зарчмаар явж болох юм. Үүний цаана санхүүгийн чадавхгүй маш олон компаниуд барилга барих нь нэрээр иргэдээс мөнгө татаж, өнөөдрийн дуусаагүй маргаанууд шүүх дээр явж байгаа. Тэгэхээр бид хэд энэ дээрээ энэ бол гэрээний харилцаа юм гээд бас орхигдуулж болохгүй байгаа юм. Энгийг

бас Хууль зүй, дотоод хэргийн яам бол анхаарах зайлиггүй шаардлага байгаа.

Дам.Цогтбаатар: Сайнзориг гишүүн ээ, 1 дүгээрт би танаар хууль заалгахгүй ээ.

2 дугаарт Их Хурлын гишүүний хувьд нэг их бие биедээ хариуцлага сануулаад байх шаардлагагүй. Би ярьж байгаа үгнийхээ үг, агуулга болгоныг мэдэж ярьж байгаа. Мэдэхгүй юмаа би ярьдаггүй. Мэдэхгүй гээд шууд хэлчихнэ. Би мэдэхгүй байхаас ичдэггүй. Яагаад гэвэл би бүх юмыг мэдэх албагүй ч үгүй.

Зөвшөөрөл, юу 2-ын хооронд гэвэл хэлбэр төдий тэр бүртгэл 2-ын хооронд бол маш том ялгаа байгаа боловч хэрэглээ дээрээ том зөрүү чинь гардаг юм. Улс төрийн шинжлэх ухаанд тэр контент анализис гэдэг ухагдахуун яаж орж ирсэн юм гэвэл яг сая энэ Эрдэнэболд гишүүн ярьж байна л даа. Нацизмын тухай. 1 нөхөр энэ чинь бүр яг шүүхийн кэйс байгаа байхгүй юу. Өөрөө мэдэгдэл гаргаад байсан тэрийгээ ямар ч нацист шинж чанаргүй гээд байсан. Шүүх дээр очоод тэр контент анализис хийгээд харахад тийм биш юм шиг боловч цаад агуулгаараа энэ чинь нацист сурталчилгаа байна гээд хариуцлага хүлээлгээд тэр хэвлэлийн байгууллага байсан даа юмыг нь хааж байсан байхгүй юу. Тэгэхээр зүгээр үгний хэлбэрээр биш цаад агуулгаар нь шийддэг. Тэгвэл би энэ дээр бүр яг энийг нь тодорхой хэлчихье. Яагаад би энийг хэлж байна гэхээр би өөрөө сохор биш, дүлий биш, энэ талбай дээр чинь жагсаахгүй гээд зүгээр бүртгэхгүй гэдэг маягаар зөвшөөрөхгүй, жагсаахгүй байгаад байсан нь үнэн шүү дээ. Би тэнэг биш. Тэрийг чинь би хараад байсан байхгүй юу. Тэгээд энэ чинь буруу шүү дээ. Энэ шинэ сайд орж ирээд энэ дээр яах аргагүй энэ техникийн энэ заалтыг цаад хууль гаргаж байсан хүмүүс уг нь бол зөвшөөрлийн тогтолцоо биш бүртгэлийн гэж гаргаж байсан байж болно. Хэрэгжүүлэхдээ ингээд яваад байгаа бол цаад амьдрал дээрээ

хуулийг чинь тайлбарлахдаа ингээд яваад байна гээд засъя гээд холбогдох яам нь, Засгийн газар нь оруулаад ирж байгааг л би зөв гэж байна шүү дээ. 220 хэдэн удаа буцаагаад, тэр нь бодит байдал дээрээ зөвшөөрөл биш байхаас илүү ямар нотолгоо шаардаад байгаа юм. Би тийм учраас л бодит амьдрал дээр ийм байгаад байгаа. Энийг ингээд бүр тодотгоод газар дээрээ хууль тогтоогчийн цаад үзэл санааг хэрэгжүүлэхдээ тэгвэл өөрөөр хэрэгжүүлээд байгаа бол хэрэгжүүлж байгаа хүмүүст нь тэгвэл бас тус бол л доо. Энэ чинь тийм санаагүй юмаа гээд хуулиа тодотгоод өг л дөө. Энийг л би зөв гэж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр бол өөрийнхөө байр суурийг хэлэхэд ийм байна.

Энэ юу 2 дугаар асуудлаар ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга. Тогтоолын тэр Алтангэрэл сайдын түрүүн энэ хууль танилцуулах дээр бас нэг юуг хэлчихмээр байна. Эрдэнэболд гишүүн та 2-ын ярьж байгаа юман дээр. Хуулийг танилцуулахгүй болохоор иргэд мэдэхгүй байна гээд. Та нар энэ хуулийг танилцуулах бүр өдөр болгоны сурталчилгаа хийгээд хүмүүс сонсохгүй юмаа сонсдоггүй, бүгдээрээ хууль мэддэг болно гэж байдаг. Тийм учраас *legas ignorantia non excusat* гэдэг зарчим хүн төрөлхтний түүхэнд 2000 жил хэрэгжээд ирж байгаа юм. Өөрөөр хэлбэл хуулийг танилцаж мэддэг байх нь иргэн болгоны үүрэг байхгүй юу. Хууль мэдэхгүй байх нь хууль зөрчихийн зөвтгөл биш. Тэгэхээр иргэн болгон өөрийгөө хуультай танилцуулж мэдэж байх нь иргэний үүрэг. Мэдээжийн хэрэг төрийн хэмжээ өнцгөөс бол энд танилцуулна. Тэгэхдээ ямар ч мөнгө тавиад бүгдээрээ мэддэг болохгүй шүү. Энийгээ бас ний нуугүй иргэддээ ч гэсэн иргэн өөрөө үүрэг хуулиа мэдэж байх үүргийг үүрээд явж байгаа гэдгийг нь бас сануулж хэлж байх ёстой гэж бодож байна.

Ажлын хэсгийн энэ бэлтгэсэн зөрүүтэй санал 2 дугаар зүйл дээр байхгүй байгаа.

Тогтоолын төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү. Байхгүй байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал байхгүй байгаа. Дарсан юм уу тээ. Тэгвэл Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: 3 дээр бол ерөнхийдөө нөгөө бүсчилсэн хөгжлийн зорилт, үзэл баримтлал дээр энэ хөтөлбөртөө нийцүүлээд өөрчлөлтүүд оруулах тийм зохицуулалтууд орсон байна л даа. Тэгээд яах вэ, энийг бол яг тухайлан нэг бүрчлэн бол харж бас амжсангүй. Ямар ч байсан эхний ээлжид 3.1 дээр Хангайн бүсийн зохицуулалт байгаа. Үүнд, хуучин хэллэгээрээ нэр томъёогоороо бол Орхоны хөндий Хангайн нурууны байгалийн онцлогт тулгуурлан аялал жуулчлал, боловсруулах үйлдвэрлэлийг дагнан хөгжүүлсэн гэж байсан юм. Тэгэнгүүт одоо өөрчилж байгаа нь болохоороо нөгөө Орхоны хөндий Хангайн нурууны байгалийн онцлогт тулгуурлан аялал жуулчлал гэдэг хэсгийг хасчихсан байна л даа. Яг үг, үсгийн хувьд. Тэгэхээр яг энийг ингэж үг үсгийг нь хасах шаардлага байгаа юм болов уу. Өөрөө хангайн бүс яг үндсэндээ аялал жуулчлал тал руугаа бол нэлээн давуу байдал үүсдэг учраас энэ толгой хэсэгтээ энэ аялал жуулчлал гэдэг үгээ авч үлдвэл яадаг юм бэ. Заавал ингэж өөрчлөх шалтгаан нь юу байгаа юм бол гэдэг санал байна.

Дам.Цогтбаатар: Аялал, жуулчлалын яам Одонтуяа гишүүн хариулах уу. 2 дугаар микрофон өгье.

Д.Эрдэнэбаяр: Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Эрдэнэбаяр асуултад хариулъя. Хангайн бүсийн хувьд бол нийслэлийн баримжаатай Шинэ Хархорин хотын

бүтээн байгуулалт явж байгаа. Тэгээд үүнтэй холбоотой бас хуулийн төслүүд явж байгаа. Шинэ хот маань бол өөрөө соёлын үйлдвэрлэлийн чиглэлээр аялал жуулчлалтайгаа хосолсон ийм нэлээн томоохон бүтээн байгуулалтууд, хот төлөвлөлтийн асуудлууд, шилжилт хөдөлгөөний асуудлууд, эдийн засгийн коридорын асуудлууд гээд орж байгаа учраас энэ хэсэгтээ бол 4 жилийн төлөвлөлт дээр хот байгуулалт гэдэг асуудлаа илүү тэргүүлэх чиглэл болгоё гэдэг ийм зүйлийг бол ажлын хэсэг дээр санал яригдаж байгаад, тэгээд энэ чиглэлээр орсон. Гэхдээ бол бүсүүдийн хөгжлийн төлөвлөлт буюу 10 жилийн бодлогын ажлууд бол бас эхэлж байгаа. Техник, эдийн засгийн урьдчилсан судалгаанууд хийж эхэлнэ. Тэгээд нарийвчилсан төлөвлөгөө дээр бол мэдээж аялал жуулчлалын асуудлаа аваад явахаар төлөвлөж байгаа. Жишээлбэл, Өгий нуур орчимд бол нүүдэлчдийн соёлын төв, аялал жуулчлалын томоохон тусгай бүс, чөлөөт бүсийн төлөвлөлтүүдийг бол үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаад явж байгаа. Мөн энэ уламжлалт мал аж ахуйтай холбоотой орон нутгийн үйлдвэр, үйлчилгээ, тээвэр логистикийн цогцолборуудыг шинэ хоршоо хөдөлгөөн болон бусад гарсан цагаан алт, хүнсний хувьсгал зэрэг хөтөлбөрүүдтэй уялдуулж хэрэгжүүлэх ийм шаардлагууд бол дунд хугацаанд байгаа учраас уламжлалт мал аж ахуй гэдэг дээр илүү фокус өгөөд явъя.

Тэгэхдээ бол энэ тэргүүлэх чиглэлийг бол урт хугацаанд заавал мөрдөөд байхаас илүү одоо олон улсын жишигээр бол богино богино хугацаанд тухайн Засгийн газрынхаа дунд хугацааны зорилттой холбогдуулаад солиод байх боломжтой ийм олон улсын туршилага байдаг. Тэгэхээр энэ чиглэлээр бол ажлын хэсгээс өгсөн үүрэг чиглэлийн дагуу бол оруулаад явж байгаа.

Дам.Цогтбаатар: Тодруулах уу. Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Ерөнхийдөө нөгөө санааг нь бол ойлгож байгаа. Задаргаа дээрээ 3.1 дээрээ задраад явж байгаа. Тэр дотроо бол аялал жуулчлал гэдэг үгээ аваад явж байгаа боловч өөрөө нөгөө өгөх ойлголт буюу яг ингээд аялал жуулчлал гэдгийг үндсэн чиглэлээсээ, яг гол тэргүүлэх чиглэлээсээ хасаад явж байгаа юм шиг ийм ойлголт орчхоод байгаа учраас энэ хуучин үг, үсгээ аваад үлдэх санал оруулчихъя. Тийм саналтай байна.

Дам.Цогтбаатар: За байз тэгэхээр 2 дугаар микрофон хариул даа.

Д.Эрдэнэбаяр: Зарчмын зөрүүтэй санал гаргаад, тэгээд дэмжигдээд явбал тусгаад явах боломжтой байгаа.

Дам.Цогтбаатар: Уянгахишиг гишүүн ээ, 2 зарчмын зөрүүтэй санал одоо орж ирнэ. Тэгээд санал хураалгана. Тэгвэл та өөрийнхийгөө бичээд зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураагаад явуулахад оруулчих тэгэх үү.

Ингээд 3 дугаар асуудлаар ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал байхгүй. Миний ойлгож байгаагаар 1, 4 дээр байна гэсэн. Одоо Уянгахишигийн санал орж ирэх нь байна шүү дээ. Тэгэхдээ энэ чинь ажлын хэсгийн саналыг яриад байгаа байхгүй юу. Та нарын орж ирэх санал биш. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал одоохондоо өгөөгүй. Одоо гишүүдийн саналыг би хураалгана шүү дээ. Түрүүн тэр юуг нь би орхиод явчихсан юм байна. Алтангэрэл сайд тэрийг нь хариулаад протоколд оруулчих. Ойлголоо.

О.Алтангэрэл: Сайнзориг гишүүний хэлсэн хэрэглэгчийн гэрээ, өргөн утгаар нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой энэ зүйлүүд дээр бол бодол санаа нэг байна. Сайнзориг гишүүний хэлсэнтэй 100 хувь санал нэгдэж байна. Амьдрал дээр бид нар одоо яг энэ хувийн эрх зүйгээ жоохон боловсронгуй болгохгүй бол эрүүгийн эрх

зүй нь авдаггүй, тоодоггүй. Наадах чинь гэрээтэй юм байна, иргэний маргаан байна гээд байдаг. Гэтэл яг үнэндээ бол эрүүгийн хууль тогтоомжоор хамгаалдаг, зохицуулдгаас хамаагүй илүү хохирол иргэдэд учраад байдаг. Яаж шийдвэрлэгдэх нь мэдэгддэггүй. Он дамнасан ийм хэргүүд их байна. Тэгээд хэн нэгэн буруутай субъектийг хайж олж шийтгэх нь бол шүүхийн шийдвэр гаргах нь шүүхийн хувьд амархан байгаад байдаг. Гэтэл бодит амьдрал дээр хэрэглэгчийн эрх ашиг хамгаалагддаггүй байдал их байгаа. Тэгээд энэ асуудал дээр бас яг Сайнзориг гишүүний хэлсэн агуулгаар бид энэ асуудлыг ойлгож байгаа. Цаашидаа ч гэсэн яг энэ агуулгаар ажиллаад хамтраад явна гэдгээ хэлье.

Дам.Цогтбаатар: Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье. Бат-Эрдэнэ гишүүн түрүүн үг хэлье гэж кноп дараад, кноп нь ажиллаагүй юм байна лээ. Тэгээд тусгайлан хурч ирж асуулт асуух гишүүдийн нэрст нөхөж бүртгэж өгөөч ээ гэсэн. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. 3 дээр манай энэ хойд бүсийг байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн аж үйлдвэрийн дэд бүс болгоно гээд биччихсэн байгаа байхгүй юу. Гол нь энэ хойд бүс чинь Хөвсгөл, Булган, Орхон аймаг. Хөвсгөл аймаг гэхэд жишээлбэл мал аж ахуйн тоогоороо хамгийн их байдаг. Монгол Улсын хамгийн их малтай аймаг. Тэгээд манай аялал жуулчлал бол өөрөө байгаль орчин, нүүдэл соёл ахуйд тулгуурласан аялал жуулчлал шүү дээ. Тэгээд энэ хөдөө аж ахуй гээд нэмж өгөх боломж байдаг юм болов уу. Яагаад энийг хасчихсан юм бол гэдгийг 1 дүгээрт.

2 дугаарт энэ дээр хэд хэдэн санал бас байгаа юм. Жишээлэх юм бол хойд бүс байгалийн аялал жуулчлалын 1.3.3 дээр аялал жуулчлалын төрөлжсөн аж үйлдвэрийн дэд бүс гэдэг дээр Ханх, Мөрөн, Улиастай, Бургастайн боомтоор гарч байгаа босоо техникийн зам

хасагдчихсан байх юм. Зүгээр Бага-Илэнх нь орчихсон. Босоо тэнхлэгийн Бага-Илэнх боомт Хутаг-Өндөр чиглэлийн 137 км зам барина гээд орчихсон. Гэтэл энэ чинь Ханх Монт боомтын цаад талд Оросын Холбооны Улсын эдийн засгийн коридор байж байгаа. Явсаар байгаад урагшаа босоо тэнхлэгийн зам чинь Бургастайгаар гарч байхад тэнд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын шинэ эдийн засгийн коридор байж байгаа. Тэгээд энэ 2 улсын эдийн засгийн коридорыг холбосон замаа барина гээд Монгол Ардын намын мөрийн хөтөлбөрт жишээлбэл орчихсон байсан. Тэгээд энэ зам 2024-2028 онд баригдахгүй болж байгаа юм уу гэдгийг бас гайхаад байна. Энийг асуух гэж байна.

3 дугаарт, Хүний хөгжлийн бодлого дээр эхчүүд, эмэгтэйчүүд гээд 2.1.1.9.цалинтай эцэг, эх нийгмийн хамгааллын бодлогыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгоно. 2.1.1.10 дээр эхчүүдэд зориулсан төрөлжсөн нийгмийн цогц үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлтэй хамтран хэрэгжүүлнэ гээд. Тэгээд эмэгтэйчүүд гэдэг дээр юу ч байхгүй. Тэгээд эмэгтэй хүн гэдгийг зөвхөн эх гэж ойлгож байгаа юм уу. Эх хүн л эмэгтэй хүн юм уу. Энэ эмэгтэйчүүд рүү чиглэсэн хөгжлийн бодлоготой холбоотой зүйлүүдийг оруулж өгөхгүй юм уу гэдгийг би асуух гээд байгаа юм. Яагаад энэ дээр ороогүй юм бол гэдгийг гайхаад байна.

Тэгээд ер нь болбол яах вэ, зүгээр хүний хөгжлийн бодлогын хүрээнд гээд үндсэн томъёолол нь болохоороо хэрэгжүүлэх томъёолол нь болохоороо дижитал шилжилт, технологийн өөрчлөлт шинэчлэлийн сорилтыг даван туулах чадвартай монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал зан заншил эх оронч хүмүүжлийг олгох боловсролын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гээд тавьчихсан байгаа байхгүй юу. Та хэд ер нь яг хөдөө явдаг байлгүй дээ. Энэ хүний хөгжил гэдэг зүйл чинь өөрөө яг хаана гагцхиад байгаа гэдгээ анзаарч байгаа

юу. Тэгээд энэ ингээд цаасан дээр ийм томъёоллын байдалтай, зүгээр нэг ийм уриалга, лоозонгийн байдалтай баахан юм биччихсэн. Энэ хүний хөгжил чинь ухамсар ямар түвшиндээ явж байгааг мэдэж байгаа юу. Энэ гэмт хэрэгтэй холбоотой асуудлууд хүний ухамсар, төлөвшилтэй холбоотой асуудлууд, гэр бүл салалтын асуудлууд маш олон асуудлууд байгаа шүү дээ. Тэгээд энэ ухамсар, төлөвшил, сэтгэхүйтэй холбоотой асуудлыг хүний хөгжлийн бодлогын хүрээнд оруулж ирэхгүй юм уу гэдэг ийм.../минут дуусав/

Дам.Цогтбаатар: 2 дугаар микрофон.

Д.Эрдэнэбаяр: Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Эрдэнэбаяр. Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн зүгээс бүс болгон дээр 2 тэргүүлэх чиглэл тогтоох ийм зарчмын асуудлыг бол ярьж тогтсон. Тэгээд яг таны ярьж байгаа мал аж ахуйн асуудлыг бол нийтлэг учраас энэ тэргүүлэх чиглэл дээр бол оруулахгүйгээр бүх аймаг, орон нутагт хэрэгжүүлээд явах боломжтой юм. Энэ агуулгаар бол 69 орон нутгийн үйлдвэр үйлчилгээний цогцолборыг 330 сумын дунд байгуулаад явъя гэдгээр бүс болгон дээр энэ томъёолол бол орсон байгаа. Өөрөөр хэлбэл тээвэр логистикийн төв, орон нутгийн үйлдвэр, үйлчилгээ, худалдааны цогцолборууд байгуулах хувийн хэвшлийг газар зохион байгуулалт болон дэд бүтцээр хөрөнгө, санхүү, маркетинг менежментийн дэмжлэгтэйгээр байгуулъя гэдэг нийтлэг зорилтыг оруулчихсан. Засгийн газраас цаашид бол бүс болгон татварын ялгаатай бодлого хэрэгжүүлэх, газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн хувьд тэргүүлэх чиглэлтэйгээ нийцсэн ийм ерөнхий төлөвлөлтүүдийг хийх бодлого барьж байгаа учраас олон тэргүүлэх чиглэл орох нь өөрөө бүсийн үйл ажиллагааг цааш нь ойлгомжгүй байдалд оруулах юм. Тийм учраас 2

дээрээ тогтёо гэдгээр ингээд шийдээд, хамгийн их олон улсад гарч болохоор ийм тэргүүлэх чиглэлүүдийг бол үлдээгээд явсан байгаа.

Дам.Цогтбаатар: Хариулт хангалттай юу Бат-Эрдэнэ гишүүн ээ. Ахиад хүний хөгжлийн бодлоготой холбогдсон 2 зүйл дээр нь хариулт хэн өгөх вэ. Ажлын хэсгээс. Босоо тэнхлэг, тэгээд бонд 2 байсан уу. Босоо тэнхлэгийн зам дээр хариулт Болор-Эрдэнэ дарга өгөх үү. 4 дүгээр микрофон.

Б.Болор-Эрдэнэ: Асуултад хариулъя. Бургастай чиглэлийн авто замын ТЭЗҮ, зураг төслийн төсөв Эдийн засгийн хөгжлийн сайдын багц дээр энэ жил суусан. Зураг төсөв хийгдэх ёстой. Зураг төсөв хийгдээд гараад ирэхээр ирэх 4 жилийн Засгийн газрын мөрийн хөтөлбөрт оруулахаар бид саналаа хүргүүлсэн. Урьдчилсан байдлаар Бургастай чиглэлийн авто замыг Азийн хөгжлийн банкны бүс нутгийн авто зам хөгжүүлэх төслийн 4 дүгээр нэвсгийн хүрээнд оруулахаар Азийн хөгжлийн банктэй зээлийн хүрээнд хэрэгжүүлэхээр ярилцаад явж байгаа. Удахгүй шийдвэрүүд нь оны сүүлээр гарна. Ханх чиглэлийн авто замыг бол бид нар аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд саналаа бол хүргүүлсэн байгаа. Саналаа тус яамны зүгээс бол Ханх чиглэлийн авто замыг барих саналыг бол хүргүүлсэн байгаа.

Дам.Цогтбаатар: Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Б.Бат-Эрдэнэ: Болор-Эрдэнэ дарга аа, бид нар ингэж байгаа шүү дээ. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай хэлэлцэж байгаа шүү дээ. Тэгээд энэ үйл ажиллагааны хөтөлбөр дотор орохгүй бол наадах чинь орохгүй шүү дээ. Энэ үйл ажиллагааны хөтөлбөр дотор орохгүй бол төсөв чинь тавигдахгүй шүү дээ. Та хэдийн одоо яриад явж байгаа

зүйлийг олон жил ярьж байгаа. Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдахгүйгээр төсөвт тавигдахгүй наад юмнууд чинь ердөөсөө явахгүй. Тэгсэн мөртөө хойд бүсийг аялал жуулчлалын гээд маш том хэмжээнд зарлачихсан байдаг. Байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн аж үйлдвэрийн дэд бүс гээд зарлачихсан. Сая үндсэн Эдийн засаг, хөгжлийн яамнаас ийм үндсэн бодлого барьж байгаа гэж хэлсэн шүү дээ. Тэгээд аялал жуулчлалын бүс чинь өөрөө замгүй явах юм уу. Тэгээд замгүй юм бол энийг аялал жуулчлалын бүс гэж зарлах ямар шаардлага байгаа юм. Тэгээд Азийн хөгжлийн банк байна уу, Эдийн засаг, хөгжлийн яаман дээр явж байгаа тэр тодорхой ТЭЗҮ-тэй холбоотой асуудлууд байна уу. Тэгвэл тэгээд энийгээ та нар өөрсдөө явуулчихсан гээд хаях биш, энийгээ оруул л даа. Тэгээд энэ чинь өөрөө орохгүй бол тэгээд л хаягдаад л явна шүү дээ дараа нь. Тэгээд та нарын тэр Азийн хөгжлийн банкны санхүүжилт байна уу, юу байна уу. Дараа нь мянган тайлбар тавиад наад үйл ажиллагааны хөтөлбөрт ороогүй юм чинь энэ чинь цаашидаа явахгүй шүү дээ. Тэгээд энэ дээр нэмээд хэлээд өгөөч. Эдийн засаг, хөгжлийн яамнаас хүн байгаа юм болов уу.

Дараагийнх нь тэр нөгөө хүний хөгжлийн бодлого дээрээ бас хариулт авмаар байгаа юм.

Эмэгтэй хүний нөгөө давхар ухамсар, төлөвшил, сэтгэхүйтэй холбоотой асуудлуудаа ер нь оруулахгүй юм уу.

Дам.Цогтбаатар: Болор-Эрдэнэ дарга 4 дүгээр микрофон.

Б.Болор-Эрдэнэ: Бид нар Ханх чиглэлийн авто замын ТЭЗҮ, зураг төслийг хийлгэж өгөөч гэж олон жил саналаа бол хүргүүлдэг. Тэгээд боомтын сэргэлтийн хүрээнд боомт чиглэсэн замуудаа бид нар түрүүнд үзэж байна. Цөөхөн мөнгөтэй жилд Эдийн засаг,

хөгжлийн сайдын багц дээр 40 тэрбум төгрөг тавигддаг. Багтахгүй байна гэдэг шалтгаанаар урьд жилүүдэд бол дандаа хасагдаж явсан. Зураг, төсөвгүй учраас төсөвт суудаггүй. Тэгээд энэ дээр Эдийн засаг, хөгжлийн яамыг бас хариулт өгөх болов уу гэж бодож байна. Саналуудыг бид нар удаа дараа хүргэдэг. ТЭЗҮ, зураг төсөлгүй зам улсын төсөвт суудаггүй ийм л зовлонтой явж ирсэн. Тэгээд бид нар саналаа бол удаа дараа хүргүүлсэн. Энэ дээр Эдийн засаг, хөгжлийн яам бас хариулт өгөх байх гэж бодож байна.

Дам.Цогтбаатар: Эдийн засаг, хөгжлийн яамнаас хүн байна уу. Түрүүн тэр эмэгтэйчүүдийн асуудлаар. Ухамсар төлөвшилтийн асуудал гэж байсан байх. Байх ёстой л доо. Эсвэл төрийн нарийн нь байх ёстой. Энэ Засгийн газар чинь уг нь мөрийн хөтөлбөрөө батлуулж гаргах гээд байгаа юм байгаа биз дээ. Асуултад хариулт заавал өгөх ёстой. Тэгэхлээр энд оролцох тэр Эдийн засаг, хөгжлийн яамны хүнээ авчир. Хурлаа би үргэлжлүүлж байя. Би дараа нь тусгайлан цаг гаргаж өгье. Түүнээс би одоо хурлыг завсарлуулаад хүнийг нь иртэл гээд явж болж байна. Гэхдээ би тэгмээргүй байна. Дараа дараагийн зөндөө олон Байнгын хорооны хурал байгаа учраас би бусад Байнгын хороогоо хүндэтгэж байна. Тэгэхээр одоо таны хариултыг хүн нь ирэхээр дараа би цаг гаргаж өгч байгаад хариулуулъя, тэгэх үү. Тийм. Зөв шүү дээ. Та наад саналаа хэлэх эрхтэй байхгүй юу. Та бол эрхтэй. Эд нар ирж суух үүрэгтэй байхгүй юу. Энэ 2-ын хооронд чинь аягүй том ялгаа байгаа. Үүрэгтэй хүмүүс нь үүргээ биелүүлэхгүй, эрхтэй хүмүүс нь асуудлаа тавьж байна шүү дээ. Оруулах шаардлага тавих.

Зөв зөв. Тэмүүжин гишүүний хэлж байгаа ч бас яг зөв шүү. Гэхдээ Байнгын хороо дээр гишүүн асуухад холбогдох яамных нь хүн байх ёстой. Тэр хүнээ авчир. Тэгж байгаад би түрүүн хэлсэн шүү дээ. Таны асуултад хариулах тэр

хариултынх нь боломжийг гаргаж өгье. Одоо бид нар хурлаа үргэлжлүүлээд явъя.

Ингээд 3 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал байхгүй байгаа. 4 дүгээр зүйл рүү орё.

Тогтоолын төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Нар гишүүнээр тасаллаа. Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Ингээд Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Уг нь одоо маш чухал баримт бичиг бид нар хэлэлцэж байх шиг байх юм. Энэ 2024-2028 оны ер нь Улсын Их Хурал дээр чухал, чухал биш гэж байхгүй л дээ. Бүгдээрээ л чухал л даа. Тэгээд 2024-2028 оны 4 жилийн Засгийн газрын ажлын мөрийн хөтөлбөрийн тухай бид нар ярьж байна. Тэгээд байх ёстой хүмүүсийг нь байлгамаар байна. 1 дүгээрт энийг би зориуд анхааруулж хэлмээр байна.

Нөгөө талаар нэгэнт Хууль зүйн байнгын хороо дээр ярьж байна. Үгүй ээ, энэ одоо 2024 он эхэлчихсэн явж байна л даа. Үгүй ээ, өнгөрсөн жилүүдэд баахан камер энэ тэр тавилаа, барилаа энээ тэрээ гээд л яриад байсан. Тэр камерууд нь одоо ажилладаг юм уу, ажилладаггүй юм уу. Бас л 4 жилийн хугацаанд энэ хөтөлбөр үргэлжилж байгаа юу, үгүй юу. Одоо бас нэг ийм байна. Тэгээд хууль ёс хэрэгжихгүй болохоор ард түмэн өөрсдөө хууль ёсыг тогтоогоод явдаг л даа. Тэгээд орон нутагт харж байхад бол хэдэн хүмүүс яваад тэр шонхор шувууг нь барих ёстой юм уу, барихгүй ч ёстой юм уу. Тэр хууль ёсыг нь тогтоогоод яваад байх шиг байна. Ийм байх ёстой юм уу. Ямар байх ёстой юм. Би тэгээд энэ аялал жуулчлал гэж бид нар яриад байна. Тэгээд хүмүүсийн тэр аюулгүй байдал бол 1 дүгээрт байх ёстой л доо. Гадна, дотнын ирж байгаа жуулчид. Одоо энэ Улаанбаатар хот чинь бараг л үхлийн хөндий болчихлоо.

Зуны хэдхэн сард бас энэ Улаанбаатар хотод байгаа хүмүүс бас хөдөө орон нутагт явж байна. Монгол Улсын иргэд хаа ч явах эрхтэй л дээ. Хөдөө, орон нутгийнхан маань бас хууль ёсыг сахиулаасай гэж бодож байна. Тэгээд аль нь зөв юм бэ. Хууль ёсоо сахиулж чадаж байгаа юм уу. Хэн нь сахиулах ёстой юм. Тэгээд энэ хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг яг ажиллуулдаг юм уу, ажиллуулдаггүй юм уу. Би энэ цагдаа нарыг бас нэг талдаа ойлгоод байгаа. Тэгээд олон нийт иргэд чинь хэлээд байна шүү дээ. Та нар тэр авлигачтайгаа, тэр хулгайчтайгаа тэмцэж чадахгүй байхад бид нартай юу яриад байгаа юм бэ гэж. Зөв шүү дээ. Иймэрхүү асуудлууд байна. Энэ аюулгүй байдал талаасаа энэ мөрийн хөтөлбөр энэ юм чинь яаж тусгаад байгаа юм. Энийг хангаж ажиллуулж чадаж байгаа юм уу гэсэн ийм асуудал байна.

Дам.Цогтбаатар: Хэддүгээр микрофон хариулах вэ. Ажлын хэсэг. Аль яамнаас асууж байна Ганбат гишүүн ээ. Алтангэрэл сайд хариулъя.

О.Алтангэрэл: Хууль сахиулах үйл ажиллагаа тасралтгүй явагдаж байгаа. Сая энэ шонхор шувуутай холбоотой нэлээн том асуудал дэгдсэн. Цаана нь их олон асуудал байдаг юм байна лээ. Энэ шонхор шувууг барьж байгаатай холбоотойгоор олборлоно гэж нэрлээд байх шиг байна. Барьж байгаатай холбоотойгоор хяналт нь хаанаа хэрэгжих юм. Тэгээд хариуцлагын тогтолцоо нь хаанаа байх юм гээд ийм олон асуудлууд байдаг юм байна лээ. Тэгээд энэ дээр нь иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулаад бид нар бас тодорхой арга хэмжээ авч байна. Одоогийн байдлаар цагдаагийн байгууллага дээр зөрчлийн 2, гэмт хэргийн шинжтэй 2 ийм өргөдөл гомдол хянагдаж байна. Яг энэ Арабуудаас, явж байсан гаднын иргэдээс ч гаргасан өргөдөл, гомдол байна. Монгол иргэдээс гаргасан өргөдөл, гомдлууд ч байна. Энэ үйл ажиллагаа тасралтгүй явагдаж

байгаа. Тэгээд ер нь бол энэ авлига, хээл хахуультай тэмцэх, дээд түвшиндээ энэ асуудлуудтай тэмцэх ёстой гэдэг асуудал орон нутагт ч гэсэн энэ асуудлын талаар ийм хүчтэй шаардлага, дуу хоолой байгаа гэдэг дээр Ганбат гишүүнтэй санал нэг байна.

Дам.Цогтбаатар: Нарантуяа гишүүний микрофоныг өгье.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр Засгийн газрын мөрийн хөтөлбөр цаг үе, үйл явдал нэлээн бас их чамбай авцалдуулж ингэж хийсэн харагдаад байгаа. Тэгсэн мөртөө төслийг нь харахаар ялангуяа энэ хүүхэд хамгааллын асуудал дээр маш сайн, нэлээн дэлгэрэнгүй юмнуудыг оруулчихсан мөртөө төсөл дээр төсөв дээр болохоор тэр чигээрээ барилга байгууламжид бараг 90 хувь нь бүх төсөв ингээд явчихсан. Тэгээд энэ хүүхдийн эрх, хүүхдийн эрүүл мэндийг хангах тухай ийм асуудлыг барилга байгуулалтаар хамгаалах гээд байгаа юм уу. Барилга, байгууламж барьснаар хүүхдийн эрх, хүүхдийн эрүүл мэнд хамгаалагдах уу. Энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөр, төсөл 2-ын уялдааг хэрхэн яаж хангаж ажиллах гээд байгаа юм бэ.

Дараагийн асуудал нь хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хүрээнд авлигатай тэмцэх “5ш” ажиллагааг үргэлжлүүлнэ гэхсэн байгаа. Энэ авлигатай тэмцэх “5ш” ажиллагааны хүрээнд өнгөрсөн хугацаанд хөрөнгө буцаан шилжүүлэх ажиллагаагаар 2,1 их наяд төгрөг Монгол Улсад буцаан орж ирсэн байдаг. Буцаагаад ороод ирсэн байдаг. Тэгээд энэ мөнгө хаашаа ордог вэ. Хулгайчаас аваад дараагийн хулгайч руу шилждэг байх юм бол энэ чинь одоо өчнөөн зардал чирэгдэл болгож, төсөв зарцуулж ирсэн ажиллагаа нь ямар үр дүнтэй байх юм бэ.

Дээрээс нь энд Засгийн газрын тусгай сангуудын санхүүжилт, сонгон шалгаруулалтыг цахимжуулж, ил тод,

шударга болгоно гэгчихсэн байгаа. Ер нь бол нийгмийн асуудал бол зөвхөн цахимаар хэрэгжээд болчихгүй зөндөө олон асуудлууд байна. Тэгээд энэ сангууд дээр жишээлбэл хүүхдийн сан бол тэр чигээрээ хулгайн сан болоод алга болсон. Таг алга болсон. Энийг хэнээс асуух ёстой юм. Одоо энийг ярьдаг ч хүн алга. Ер нь энэ парламент дотор хүүхдийн эрх, хүүхдийн эрүүл мэнд, хүүхдийн асуудлаар ярьдаг хүн маш ховор байна. Тийм учраас би бүр яг энэ дээр асуумаар санагдаж байна. Хүүхдийн эрх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах тухай ажлыг яаж, ямар төсвөөр хийх гээд байгаа юм. Хэрвээ бид нар энд Засгийн газрын мөрийн хөтөлбөр гээд ийм гоё юм оруулаад ирчихсэн байдаг. Энийгээ өөрөө дандаа хүүхдийн асуудал бол төсөв хүрэлцэхгүй гээд л хасагддаг. Төсөв хүрэлцэхгүй байгаа учраас төсөвт суутгагдаагүй ч гэдэг юм уу ийм байдлаар ингээд л хасагдчихдаг. Тэгээд бодитоор хэрэгждэг юм байхгүй. Тэгэхээр энд нөгөө хүүхдийн зөндөө олон юмнуудыг ингээд хамгаална, ингэнэ гэгчихсэн байгаа мөртөө энд хүүхэд хамгааллын асуудлыг яг тодорхой ерөөсөө оруулаагүй. Эрүүл мэндийн асуудлуудыг бас оруулаагүй байгаа. Эрүүл мэндийн даатгалын сан гэхээр энэ томчуудад л үйлчилдэг ийм юм болчихсон. Тэгэхээр би бүр хүүхдийн эрүүл мэндийн сан гэдэг ийм тусгай зүйл заалтыг би зарчмын зөрүүтэй санал дээр оруулах гээд ингээд бас бэлдээд байж байна. Тэгэхээр энэ ямар ч л байсан эхний асуудал бол энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөр, энэ төсвийн уялдаа 2 чинь хаана, яаж хангагдах юм бэ.

2 дугаар асуулт нь тэр “5ш” ажиллагаанаас орж ирээд байгаа их наяд төгрөг чинь хаана, юунд зарцуулагдаад байна. Энийг энэ хүүхдийн сан руу шилжүүлэх, хүүхдийн санд төвлөрүүлэх, энэ орж ирж байгаа энэ их наяд төгрөгүүдийн дийлэнх хэсгийг хүүхдийн гэсэн одоо тодотголтой зүйл рүү тэгэхдээ энэ хүүхдийн сан биш шүү. Ор тас алга болчихсон. Хулгайн замаар

алга болчихсон байгаа Хүүхдийн сангийн тухай асуудлыг би яриагүй байгаа. Тэгээд энэ асуудал дээр холбогдох яам, агентлагийн хүмүүс.../минут дуусав/

Дам.Цогтбаатар: Энэ бол Алтангэрэл сайдаас өөр хүн хариулахааргүй юм байна. Алтангэрэл сайд хариулах уу.

О.Алтангэрэл: Тэр нөгөө “5ш”-ийн хөрөнгө гэдэг хэсэг нь үү. Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар хариулья. 8 дугаар микрофон.

Н.Мягмар: Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар. Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулья.

Яг энэ “5ш” ажиллагааны хүрээнд орж ирж байгаа гэмт хэргийн улмаас хууль бусаар олсон орлогыг хураах энэ орлого бол өнөөдрийн хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хуулиар бол төрийн сангаар дамжиж, улсын төсөвт бол орж ирж байгаа. Мэдээж улсын төсөвт орж ирсэн орлогыг бол батлагдсан төсвийнх нь хүрээнд нь зарцуулагдах эрхийг Сангийн яамнаас нээж ингэж явж байгаа. Энэ маань бол өөрөөр хэлэх юм бол том тогоо руу буюу ингээд ороод яг хууль бусаар олсон орлогын зарцуулалтын ил тод байдлыг хангах хүрээнд бол энэ удаагийн 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөл дээр бол 4.2.1.4 дээр авлигаас олсон орлогыг хураан авч, тухайн орлогыг гэмт хэргийн хохирлыг барагдуулах, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, зарцуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэсэн Монгол Ардын намын мөрийн хөтөлбөрт туссан агуулгаар ингээд орж ирсэн явж байгаа. Хэрвээ энэ үйл ажиллагааны хөтөлбөрт энэ агуулгаараа туссаад батлагдах юм бол Засгийн газраас энэ хууль, эрх зүйн орчныг нь улам тодорхой болгож, энэ зар зарцуулалтыг нь хэрхэн тодорхой болгож, ард түмэнд нээлттэй болгох тэр эрх зүйн орчныг нь боловсруулж

Улсын Их Хурлаар батлуулах ийм боломж бүрдэнэ гэж ингэж бодож байна. Бусад асуудалтай нь бол холбогдох ажлын хэсгийн гишүүд хариулах байх.

Дам.Цогтбаатар: Бусад асуудал гэхээр чинь өөр аль яамнаас Нарантуяа гишүүн ээ. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хэддүгээр микрофон бэ. 4 дүгээр микрофон.

Л.Мөнхзул: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Мөнхзул. Эдийн засгийн байнгын хорооны хурал давхцаад, асуултууд бас гараад байсан учраас хоцорч ирсэнд бас уучлалт хүсье.

Нарантуяа гишүүний асуултад хариулахад Гэр бүл, нийгмийн хамгааллын гэр бүлийн яам гэж Монгол Улс анх удаа байгуулсан. Хүүхэд болон ер нь гэр бүлийн гишүүдийг тус тусад нь авч үзэхгүйгээр гэр бүлийн гишүүний 1 хэсэг гэдэг утгаараа Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд асуудлууд туссан байгаа. Тухайлах юм бол энэ хүүхэдтэй холбогдолтой асуудлаар өмнөх Засгийн газрын үед Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, ер нь хүүхдийн хамгаалал, хүүхэд хамгааллын сайжруулах, хүүхдийн эрхийг дээдлэх чиглэлээр нэлээд ийм олон заалтууд орсон. Энэ 2025 оноос эхлээд төсөвт бас нэлээд үр дагавар үүсэж байгаа. Сум, хороонд хүүхэд хариуцсан, яг хүүхдийн эрх ашиг хамгааллыг хариуцсан ийм ажилтан байдаггүй. Тэгэхээр энэ хуулийн дагуу бол нэмэлтээр ингэж оруулж ирсэн. 2025 оны 1 сарын 1-ээс харин 2025 оны төсөвт холбогдох зардалд тусгах шаардлагатай байгаа учраас бас тус Байнгын хорооны гишүүд энэ асуудал дээр анхаарч, 2025 оны төсөв дээр дэмжиж өгөх байх гэж найдаж байна. Ер нь бол сум, хороо болгонд Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын нийгмийн ажилтантай болно. Одоо нийгмийн ажилтан байхгүй. Хамтарсан багийн

нарийн бичиг нь үндсэн үйл ажиллагаа явуулдаг. Энэ орон тооны бус гишүүд нь ямарваа нэгэн нэмэгдэл урамшуулал, цалингүй явдгаас ажлын ачаалал ихтэй, мөн үр дүнг тооцоход хэцүү гэсэн ийм одоо цалгардал дунд нь хүүхдийн эрх ашиг хохирох асуудлууд гардаг учраас энэ чиглэлээр үйл ажиллагааны хөтөлбөрт туссан байж байгаа. Түүнчлэн бас хүүхдийн зөвхөн хамгааллын асуудлаас гадна хүүхдийн хөгжил оролцооны асуудлыг 2.1.1.17-нд ер нь эрүүл мэнд, боловсрол, хөгжил хамгааллын үйлчилгээг ийм цогц байдлаар хүргэх асуудлууд мөн туссан байгаа. Цаашид үйл ажиллагааны хөтөлбөр маань ажлын төлөвлөгөө болж.../минут дуусав/

Дам.Цогтбаатар: 4 дүгээр микрофоныг гүйцээгээд өгье. Гүйцээгээд хариулъя.

Л.Мөнхзул: Цаашид үйл ажиллагааны хөтөлбөрийн дараа ажлын төлөвлөгөө дээр илүү дэлгэрэнгүй нарийн асуудлуудыг оруулахаар төлөвлөсөн. Нөгөө талаасаа 2.1.16-д бас хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлье. Хүүхэд хамгааллын асуудал нь ганцхан нэг яамных биш энэ салбар дундын асуудал байдаг. Бүр өрх гэрээс авхуулаад ийм учраас хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоогоо ер нь сайжруулж явъя гэдэг ийм үндсэн гол зорилт дэвшүүлсэн. Энэ зорилтоо хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө арга хэмжээ тус бүр дээр шаардагдах зардлын төсөв нь ингээд батлагдаад явах байх гэж найдаж байна.

Дам.Цогтбаатар: Нара гишүүнд микрофон өгье. Нэмж асууя.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр хүүхэд хөгжил, гэр бүл хамгааллын ерөнхий газарт гэхэд энэ оны байдлаар 71 тэрбум төгрөгийг төсөвлөсөн байгаа. Би тэгээд энэ дээр нэг эргэлзээд байгаа юм нь энэ нийт 4 жилийн хугацаанд энэ тэр чигтээ барилга байгууламж, засвар

үйлчилгээний ийм төсвүүд ороод ирчихсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ барилга доторх үйлчилгээний чанар хүртээмж, үр дүнг яаж хэмжих юм бэ. Яг нөгөө дахиад барилга байгууламжаараа ингээд хүүхдийн эрхийг хамгаалаад, болзошгүй эрсдэлээс сэргийлээд, тэгээд яг газар дээрээ болохоор зэрэг ийм ч юмны төсөв нь байхгүй. Ийм ч гардаж аль ажиллах салбар дундын нөгөө баг, сум, хороодын бензин тосноос авхуулаад ийм зардлууд яригдаад эхэлдэг байхгүй юу. Бодит амьдрал дээр. Тэгээд л ийм юмнаас болоод л яг энэ дээр болохоор их олон тэрбумын зардлууд ороод ирдэг. Бид нар эндээс батлаад явуулдаг. Тэгсэн мөртөө бодит амьдрал дээр хэрэгжихдээ ерөөсөө үүний төсөв нь байхгүй. Үүний энэ зардал нь байхгүй. Шийдэж өгөөгүй. Тийм учраас хоцорсон, тийм учраас амь эрсэдсэн гээд сууж байдаг. Өнгөрсөн хугацаанд дандаа тийм байсан. Тэгээд одоо яг энэ уялдаа холбоог яаж хангаж ажиллах гээд байгаа вэ гэдэгт би бүр үнэхээр эргэлзээд байна. Битүү барилга байгууламж, засвар үйлчилгээ, авто замын юмнууд ингээд ороод ирчихсэн байгаа байхгүй юу. Би энэ дээр бол маш их эргэлзээтэй байна. Энийг яаж хангаж ажиллах юм болоо гэдэг дээр их эргэлзэж байна.

Дам.Цогтбаатар: 4 дүгээр микрофон өгье.

Л.Мөнхзул: 2024 оны төсөв дээр хүүхэд хамгааллын хөгжил, оролцоо, урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын нөхөн сэргээх нийт зардлуудад 14 тэрбумд тусгасан. Энэ нь 2023 оны үзүүлэлттэй харьцуулахад нэлээд нэмэгдсэн. Яг хүүхэд хамгаалал дээрээ хүчирхийлэлд өртсөн, эсвэл зайлиггүй хамгаалал шаардлагатай эрх нь зөрчигдсөн хүүхдүүдэд хамгаалах байранд авах, тодорхой хоол тэжээлийн болон бусад дэмжлэг үзүүлэх гэх мэт яг хүүхдэд ноогдож байгаа зардалд 2023 онд 8 тэрбумыг зарцуулдаг байсан. Энэ дээрээс Сангийн яамтай бол хамтарсан

ажлын хэсэг гараад энэ зардал үнэхээр хүрэлцээгүй байна гээд Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн дэмжлэгтэйгээрээ энэ зардал дээр бас нэлээд ажлын хэсэг ажиллаад, 2024 онд бол 14 тэрбум болж өсгөсөн. Гэхдээ энэ бол 2024 оны эхний хагас жилийн үнэ тарифын өсөлтийг шингээсэн зардал байсан. 2025 онд тус яамнаас энэ хүүхэд хамгааллын 14 тэрбум төгрөгийн зардал дээр Нара гишүүний хэлсэнчлэн тэр хамтарсан багийн гишүүдэд ажиллах цагийн хөлс огт байдаггүй. Тэр цагийн хөлс, бензин тосны зардал, хүүхэд хамгаалалд зайлиггүй шаардлагатай хүүхдийг одоо авчраад нөгөө хүүхэд өлчихсөн байдаг. Наад захын хоол ундаар хангах гэх мэт зардлуудын төсвийг тусгаад, 2025 онд бол манайх 28 тэрбум төгрөг нэмэгдэхээр төсвийн төсөлд саналаа Сангийн яаманд хүргүүлсэн байгаа. Энэ дотор бол гол асуудал нь бас тэр сум, хорооны нийгмийн ажилтнуудын шинээр бий болгох төрийн үйлчилгээний ажилтан захиргааны биш ийм албан хаагчдын бас зардлууд орсон байгаа. Тэгэхээр энэ төсвүүд маань батлагдах юм бол салбар дундын уялдаагаа хангаж ажиллахаар л зорьж ажиллана гэж бодож байна.

Дам.Цогтбаатар: Эрүүл мэндийн яамнаас хүн байна уу. Би бол үнэхээр либерал хандаж байна шүү. Эрүүл мэндийн яамныхаа хүнийг авчир ажлын хэсгээ. Гэхдээ би хурлаа цаашаа үргэлжлүүлээд явж байя. Түрүүн Бат-Эрдэнэ гишүүний асуусан асуултын хариулт, Нара гишүүний эрүүл мэндийн чиглэлээр асууж байгаа асуулт 2 дээр хариултыг нь тусдаа би цаг гаргаж өгөөд, хариулах боломж гаргая. Хүүхдийн сангийн холбоотой асуултад ахиад 4 дүгээр микрофон уу. 4 дүгээр микрофон өгье.

Л.Мөнхзул: Яг энэ 2024 оны төсвөөр Хүүхдийн төлөө санд нийт 18 тэрбум төгрөг хуримтлагдсан байна. Хүүхдийн төлөө сангаас төдийлөн хөрөнгө зарцуулагдахгүй байгаад байгаа

юм билээ. Үндсэн шалтгаан нь юу вэ гэхээр Хүүхдийн төлөө сангийн эрх зүйн зохицуулалт нь Засгийн газрын тусгай сангийн тухай хууль дээр оруулчихсан. Энэ хууль дээрээс зарцуулах зардлын нөгөө хязгаарлалт нь бас хязгаарлагдмал байдлаар орчихсон. Зөвхөн хүүхдийн хөгжлийн төлөө хөрөнгө оруулалтын саналыг төрийн бус байгууллага болон аж ахуйн нэгжүүд гаргасан тохиолдолд сонгон шалгаруулж ингэж оруулахаар тусгагдсан. Энэ асуудлаар бол өнгөрсөн хугацаанд яамны мэдээллийг аваад үзэхэд бол бас төдийлөн төслийн санал орж ирээгүй ийм асуудал байгаа юм байна лээ. Тийм учраас бид нар энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр Хүүхдийн төлөө санг бол арай өөр байдлаар зарцуулъя. Зарцуулалтыг нь боломжийг нь нэмье. Жилдээ бол дор хаяж тэр нөгөө дугаарын азтай дугаар борлуулснаас дор хаяж 5 тэрбум төгрөгийн орлого орохоор байна лээ. Ингээд үзэхээр дор хаяж орлого маань жил болгон 5 тэрбумаар нэмэгдэх учраас эхний ээлжид хүүхдийн эрүүл мэнд, сайн сайхны төлөө, ялангуяа урт хугацаагаар өвдсөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн чиглэлээр хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр зарцуулах нь зүйтэй юм гэсэн ажлын хэсгийн дүгнэлт гарсан. Энэ асуудлыг бас 2025 оныхоо төсөвтөө тусгах мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ийм шаардлага байгаа.

Дам.Цогтбаатар: Нара гишүүнд микрофон өгье. Тодруулъя.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр бүхэл бүтэн 18 тэрбум төгрөг цуглачихсан энэ хүүхдийн сангийн мөнгийг өнөө маргаашигүй амь насанд дээсэн дөрөөн дээр байгаа хүүхдүүдэд яагаад зориулаад, өнөөдөр хүүхдүүдийнхээ амийг аварч болдоггүй юм бэ. 2025 оноос бид нар энийг ингээд ингэж шийднэ. Урт хугацааны юм шийднэ гээд ингээд байж байна. Яг өнөө маргааши амь насанд дээсэн дөрөөн дээр

байгаа хүний нутагт оччихсон Монгол түмнээсээ хандив гуйгаад байж байгаа өчнөөн хүүхдүүдийн асуудал байж байхад яагаад эндээс шийдэж болохгүй байгаа юм. Шийдэж болох уу нэн даруй.

Дам.Цогтбаатар: 4 дүгээр микрофон өгье. Гэхдээ энд ажлын хэсгийнхээ гишүүдтэй зүгээр аятайхан бас эмоци гаргаж уурлаж битгий тэгээрэй. Эд нар бас ажлаа хийгээд л явж байгаа хүмүүс байгаа.

Л.Мөнхзул: Засгийн газрын өмнөх ажлын хэсгээс гаргасан судалгаагаар Хүүхдийн төлөө сан маш богино хугацаанд ковидын үед байгуулагдсан. Тухайн үедээ эрх зүйн зохицуулалт нь бас нарийвчлан зохицуулагдаж чадаагүй. Тухайн сангаас гарах зардал нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу нэлээд ийм хязгаарлагдмал учраас манай яамнаас мөнгөө гаргаж чадахгүй ийм бэрхшээлтэй асуудлууд гараад Засгийн газраас журмаа батлуулаад ийм хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн юм байна лээ. Ингээд журмаа бол манайхаас боловсруулаад, холбогдох яамнуудаас санал авах гээд хүргүүлсэн.

Тэгээд ганицхан журмаар зохицуулагдах боломжгүй. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах ёстой гэсэн ийм шаардлага байгаад байгаа. Тэгээд төсвийн тухай хуулийн тодотголыг юм уу эсвэл ингээд дагуулаад өргөн барих асуудлыг бид нар бас Сангийн яаманд хүсэлт тавиад Гэр бүлийн яам маань дөнгөж байгуулагдаад 1 сар болж байгаа. Ингээд эрчимтэйгээр бас ажлын хэсэг байгуулаад ажиллаж байгаа. Тэгээд саналыг бас хүлээж авч байна. Ер нь бол энэ хэрэгцээтэй хэсэгтээ зарцуулагдахгүй ингээд л 3 жил болсон асуудал байгаа байна лээ.

Дам.Цогтбаатар: Бат-Эрдэнэ шинэ микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа ашгүй Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас түрүүнийхээ асуултыг авчихмаар байна. Энэ нөгөө хүний хөгжлийн бодлого дээр эхчүүд, эмэгтэйчүүд гээд 2.1.1.9, 2.1.1.10 гээд орчихсон. Эхчүүдэд зориулсан төрөлжсөн нийгмийн цогц үйлчилгээ төр, хувийн хэвшлийн түншилэлтэй хамтран хэрэгжүүлнэ л гэдэг ганцхан заалттай. Танай яам эмэгтэйчүүдийн асуудлыг эхчүүд гэдгээр төлөөлүүлж үзэж байгаа юу. Эх биш хүн эмэгтэй хүн биш үү. Энд эмэгтэйчүүдийн бодлогыг яагаад ингэж орхигдуулж оруулсан юм бэ.

2 дугаарт танай яамны харьяа эцэг, эхгүй өнчин өсөж байгаа, хагас өнчин өсөж байгаа, дээрээс нь эцэг, эх байхаасаа татгалзсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн Хараацай гээд ганцхан зуслан байдаг л даа. Өнөр бүлийн. Тэрийгээ та нар яагаад хаячихсан юм. Тэнд сэтгэл санааны асар өндөр гэмтэлтэй хүүхдүүд өсөж байгаа шүү дээ. Тэгж байхад та нар өөрсдөө энэ дэмжих боломжтой юмыг нь ядаж тэр байр савыг нь очиж үзээд, тэр хооллож байгаа төмөр тавагт хооллож төмөр аяганд цай ууж байгаа. Та хэд өөрсдөө өдөржингөө төмөр тавагт цай уугаад, хоол идээд үзээрэй. Тэгээд хүүхэд хамгааллын бодлого гээд ингээд энэ дээр гэр бүл, хүүхэд гээд ингээд заалтууд оруулчихсан хүний хөгжлийн бодлого дээр. Яг бодит нөхцөл байдал дээрээ эрх зүйн орчинд өөрчлөлт оруулна л гээд л яваад байдаг болохоос биш яг бодит амьдрал дээр наад хүүхдүүд чинь ямар түвшинд байгаа гэдгээ та нар 1 дүгээрт мэдэж байгаа юм уу. Энэ дээр би харцулт авмаар байна.

2 дугаарт эдийн засгийн бодлого дээр татварын ялгамжтай бодлого бид нар уг нь оруулна гэж ярьсан. Ялангуяа энэ бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд бид нарын энэ бүсийн төрөлжсөн хөгжил гэдэг хэсэг дээр хангайн бүс, баруун бүс, хойд бүс, говийн бүс, төвийн бүс, зүүн бүс гээд

оруулчихсан. Энийг эдийн засгийн үр өгөөжийг сайжруулах, эдийн засгийн хөшүүргийг хийхийн тулд татварын ялгамжтай бодлогоор л бид нар дэмжье гэдэг ийм зүйл орсон юм шүү дээ. Аж ахуйн нэгжүүд чинь татвартай бол яг ний нуугүй хэлэхэд бас л их хэцүү байгаа. Тэгээд энэ татварын ялгамжтай бодлого гэдгийг зүгээр уучлаарай би бол хайгаад олсонгүй. Аль хэсэг дээр яг ямар заалт дээр байсан юм бол гэдгийг би асуумаар байна.

3 дугаарт Байгаль орчин, аялал жуулчлалын асуудлаар тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлж ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нийт газар нутгийн 8,8 хувьд хүргэнэ гээд би одоо буруу санаагүй бол уг нь сайдаар нь ажиллаж байсан. 9,1 хувь гэж байсан санагдаад байх юм. Тэгээд уг нь 9,1 чинь нэмэгдэх ёстой байтал бүр 8,8 болоод ингээд буцаад буугаад ороод ирчихсэн байх юм. Энэ ямар учиртай юм бэ. Энийг надад тайлбарлаж өгөөч ээ.

Сүүлийнх нь бол энэ авлигын асуудал. Авлигатай, авлигагүй засаглалтай холбоотой асуудал байна л даа. Яг ний нуугүй хэлэхэд байна шүү дээ. Энэ дээд түвшиндээ л бид нар яриад байдаг бүх ил тод байдлыг бид нар дээд түвшиндээ яриад байдаг. Төрийн өндөр албан тушаалтны зарлага орлогын албан татвар төлөлт хяналтын тогтолцоог бүрдүүлнэ л гээд л яриад л байдаг... /минут дуусав/

Дам.Цогтбаатар: Шууд авчих уу тодруулах цагаа. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгчихье.

Б.Бат-Эрдэнэ: Гэтэл яг ний нуугүй хэлэхэд энэ авлигын асуудал чинь дунд, доод шатандаа бүүр арай хэтэрчихжээ. Бүр арай хэтэрхий байна. Болдог бол энэ Авлигатай тэмцэх газрын бүх салбарыг бүх аймагт байгуулмаар байна. Бид нар энэ авлигагүй засаглалыг хийх юм бол Авлигатай тэмцэх газрынхаа төсвийг хангалттай сайн нэмж өгөөд, бүх орон

нутагт байгуулаад энэ авлигатай тэмцэх ажлыг маш сайн хиймээр байна шүү дээ. 2022-2024 оны хооронд 2,7 их наяд төгрөгийн авлигаас учирсан гэмт хэргийн хохирлыг буцаан барагдуулсан. Ийм их хэмжээний мөнгө. Гэтэл бид нар өнөөдөр эргээд харахаар авлигатай тэмцэх ажил нь өөрөө орон нутагт хөл нь хүрч чадахгүй байна л даа. Тэгэхээр энийг энэ 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бүр тусгайлан оруулж өгөөч. Энэ урьдчилан сэргийлэх ажлуудыг, энэ гэмт хэрэгтэй тэмцэх бодлогуудыг, энэ газрын наймаатай холбоотой асуудлуудыг, энэ тендертэй холбоотой асуудлуудыг бүгдээрээ орон нутагт байна шүү дээ. Бүр битүү байна. Тэгээд энэ Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг өргөжүүлж өгөөч. Энэ дээр бол 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дотор бол бүр Авлигатай тэмцэх газрын энэ салбаруудыг орон нутагт, бүр 21 аймагт бүр тусгайлан байгуулж өгөөд энэ Авлигатай тэмцэх газрын төсвийг бол бүр хангалттай хэмжээнд нэмж өгмөөр байна. Ингэж байж бид нар Авлигатай тэмцэх газрын авлигатай тэмцэх ажлыг хийнэ. 2 дугаарт бид нар авлигагүй засаглалыг бий болгох ажлыг бид нар хийж чадна. Тэрнээс биш сард 1 удаа юм уу, эсвэл улиралдаа 1 удаа очоод Авлигатай тэмцэх газраас 1 хэдэн хүн очоод шалгалт нэрээр хэдэн юм хийчхээд ирдэг энэ тогтолцоо бол бүтэхгүй. Бүтэхгүй гэдэг нь өнгөрсөн хугацаанд ч гэсэн батлагдлаа шүү дээ. Тэгэхээр бид нар энэ авлигатай тэмцэх энэ авлигагүй засаглалтай холбоотой асуудал дээр бол бүр онцгойлон анхаарах шаардлагатай байна гэдгийг бас хэлмээр байна. Баярлалаа.

Дам.Цогтбаатар: 1 дүгээр асуулт. Тэгээд 3 асуулт байна. Хөдөлмөрийн яам, Аялал жуулчлалын яам, Хууль зүйн яам гэсэн ийм 3 юу байх шиг байна. 1 дүгээр микрофон өгье.

Ц.Эрдэнэбат: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Бүсчилсэн хөгжлийн татварын ялгаатай бодлогын чиглэлээр хэд хэдэн заалт орсон байгаа. Яг өмнөтгөл хэсэг дээр болохоор бүсүүдийг төрөлжүүлэн хөгжүүлж, бүс бүхэнд ялгаатай татварын бодлого хэрэгжүүлэх шаардлагатай гээд орчихсон байгаа юм. Тэгээд ер нь энэ бүсчилсэн хөгжил энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндсэн 4 тэргүүлэх чиглэл тэрний 1 нь бол бүсчилсэн хөгжил гээд бүр том бүлэг явж байгаа. Энэ дээр бол яг үүнтэй холбоотой агуулга бүхий заалтууд хэд хэдэн газар явж байгаа. Бас өмнөх асуултад нэмээд хариулахад мөн хүний хөгжлийн бодлого гээд энэ дотроо болохоороо хүний эрүүл мэнд, боловсрол гээд энэ чиглэлээр бас мөн эмэгтэйчүүдийн болон бусад асуудлууд маань бас орчихсон байгаа. Тэгээд өөрийн танилцуулъя. Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх Эрдэнэбат байна. Сайд маань сая төрийн айлчлалтай давхацсан учраас ярьж амжсангүй. Хүлцэл өчиж байна. Баярлалаа. 2, 3 дахь асуудлыг эхний 2-ыг нь манай ажлын хэсэг хариулах байх.

Дам.Цогтбаатар: Сая тэр 9.0 хэдэн тэрбум байсан. 8 тэрбум болгоод буулгачихсан байна гээд. Тэр аль яам билээ. Байгаль орчны яам. Хэддүгээр микрофон байна. Байгаль орчны яам. Байгаль орчны яам байна уу. 5 дугаар микрофон өгье.

Ц.Уранчимэг: Байгаль орчин, аялал жуулчлалын яам. Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт суурь түвшинээрээ 2023-2024 оны байдлаар бол 8,2 хувиар ойгоор бүрхэгдсэн талбай ойрх чанар байгаа. 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 9 хувьд хүргэнэ гэсэн зорилт дэвшүүлсэн байгаа.

Дам.Цогтбаатар: Алтангэрэл сайд.

О.Алтангэрэл: Энэ авлигатай тэмцэх талаар ярьж байгаа зүйл үнэн. Яг үнэндээ бол бид нар энэ төр засгийн өндөр албан тушаалтнуудын түвшинд авлига яриад байдаг. Гэтэл сумын өвсний фондоос 5 сая төгрөг дутаачихсан Засаг дарга, батлагдсан төсвөөсөө 3 сая төгрөг илүү хэрэглэчихсэн Соёлын төвийн эрхлэгч, аймгийн төвийн газраа далдуур дамлаад сууж байдаг газрын албаны түшмэлүүд орон нутгийн авлигын том асуудал болчихсон. Авлига бол ерөөсөө зөвхөн Улаанбаатар хотод байгаа мэт бид нар хандаж ирсэн. 4 аймгийн дунд Авлигатай тэмцэх газрын нэг байцаагч байдаг. Тэгээд ажлаа чадлаараа хийхийг хичээвч амждаггүй ийм зүйл байгаа. Өнгөрсөн жилүүдэд гэхэд би жишээлбэл хувиараа 4, 5 удаа энэ авлигын талаар орон нутаг дахь авлигын шинжтэй зүйлүүд дээр гомдол өгч үзэж байсан хүний хувьд энэ байдлыг сайн мэдэж байгаа. Орон нутгийн авлига гэдэг бол орон нутгийн иргэдийн хувьд том асуудал болсон. Тэгэхдээ бид нар одоо энд бас Хууль зүйн байнгын хороо дээр Бат-Эрдэнэ гишүүн энэ асуудлыг хөндөж байгаад баяртай байна. Хууль зүй, дотоод хэргийн сайдын хувьд орон нутаг дахь энэ авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэхэд цагдаагийн байгууллагын хүч хэрэгслийг яаж үр дүнтэй ашиглах юм бэ. Цагдаагийн байгууллагын энэ өмчийн эсрэг чиг үүрэгтэй нэгжүүдийг яаж сургаж мэргэшүүлж ажиллах юм бэ гэдэг дээр тодорхой хэмжээний бодлого гаргаад, Монгол Улсын ерөнхий прокурор, Авлигатай тэмцэх газрын дарга, тэгээд холбогдох хүмүүстэй санал солилцоод явж байгаа зүйлүүд байгаа. Бид нар энэ орон нутгийн авлигад онцгой анхаарал хандуулна. Хандуулахаас ч арга байхгүй. Энд Монгол орон даяар оршин сууж байгаа маш олон хүний хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдөж байгаа энэ асуудлыг сэргээж, орон нутгийн авлигачдад хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлнэ.

Дам.Цогтбаатар: Хариулт хангалттай юу. Та түрүүн тодруулчихсан шүү дээ таны хугацаа дуусчихсан байхгүй юу. Би тийм учраас авах уу. Тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Тэр нөгөө төрийн өндөр албан тушаалтны зарлага, орлогын албан татвар төлөлтийг ил болгох хяналтын тогтолцоог бүрдүүлнэ гээд 4.2.1.2 дээр байгаа байхгүй юу. Энэ дээр төрийн өндөр албан тушаалтан гэдгээс илүүтэйгээр давхар тэр төрийн тодорхой албан тушаалтнуудыг бүгдийг нь оруулж өгмөөр байгаа юм. Одоо тэр сумын Засаг дарга, Иргэдийн хурлын дарга, газрын дарга, хэлтсийн дарга нарыг. Тэгэхгүй бол яг ний нуугүй хэлэхэд хагас сайн өдөр гараад л 5 дахь өдөр төрийн албаны машин унаж дууслаа. Хагас сайн өдөр нь хувьдаа авсан, авлигаар авсан Ланд крузерээ унаад л хөдөө гадаа явж байна шүү дээ. Тэд нарыг хэн ч тоодоггүй, хэн ч хардаггүй, хэн ч анзаардаггүй. Яагаад гэхээр олон нийтийн сүлжээгээр ч шүүмжлүүлдэггүй. Хэн гэдэг хүн байдаг нь ч тодорхойгүй. Царайг нь ч хүмүүс таньдаггүй. Тэгэхээр хаана хэн юу хийгээд явж байгаа нь яг ний нуугүй хэлэхэд тодорхойгүй. Авлигаар олсон мөнгөөрөө олсон мөнгөөрөө энэ хүмүүс бол яг ний нуугүй хэлэхэд жаргаж байна шүү дээ. Тэгэхээр энэ зөвхөн төрийн өндөр албан тушаалтны зарлага орлогын албан татвар төлөлтийг ил болгохтой холбоотой хянах тогтолцоог бүрдүүлэхтэй холбоотой асуудал биш. Энэ төрийн албан тушаалтнуудтай холбоотой асуудлуудыг бол ер нь энд нэгэнт л авлигагүй засаглалыг бий болгох гэж байгаа бол оруулж өгмөөр байна л гэж энэ саналыг нэмэх гэсэн юм.

Дам.Цогтбаатар: Алтангэрэл сайд гүйцээж хариулах уу.

О.Алтангэрэл: Тодруулаад санал л юм шиг байна.

Дам.Цогтбаатар: Тэгвэл ингээд ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй бол саналгүй байгаа.

Тэгэхээр энэ чинь нийт 4 гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргаад, тэр саналуудаар нь санал хураалт явуулна. Ингэхээр Нараа гишүүн, Уянгахишиг гишүүн, Бат-Эрдэнэ гишүүн, Эрдэнэболд гишүүн гэсэн энэ 4 гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргасан байгаа.

Тэгэхээр энэ 4 гишүүндээ өөрсдийнхөө зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлах боломж олгоё. Би тэгээд томъёоллуудыг нь дараа нь уншаад яг тэр томъёоллоороо санал хураалт явуулна. Эмэгтэйгээсээ эхэлчихье. Нара гишүүн.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр би түрүүн хэлсэн. Энэ хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хүрээнд “5ш” ажиллагаанаас орж ирж байгаа хөрөнгө буцаан шилжүүлэх энэ ажиллагаанаас орж ирж байгаа мөнгөн дүнг энд тусгасан байгаа Засгийн газрын тусгай сангуудын санхүүжилт болох энэ ажлыг сан бүрдүүлэх олон нийтийн оролцоогоор зарцуулах тогтолцоог бий болгох ийм санал дэвшүүлж байгаа юм. Энэ саналаа бүр Хүүхдийн эрхийг хамгаалах сан, Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах эрүүл мэндийн даатгалын сан гэсэн ийм 2 төрлийг оруулж ирж байгаа юм.

Яагаад гэвэл одоо яг ийм асуудал дээр манай энэ төсөвт бол ерөөсөө тусгагдаагүй. Тэгээд энэ хаанаас, яам ингээд төсвийн хөрөнгө оруулалтын санхүүгийн эх үүсвэр тодорхой болох ёстой шүү дээ. Тодорхой биш байдлаас болоод бид нар төсөв хүрэлцээгүй, төсөвт суутгагдаагүй гээд явж байгаа. Тэгэхээр жишээлбэл өнгөрсөн хугацаанд өчнөөн олон төрийн хулгай, авлига, хээл хахуультай холбоотой хэргүүд ил тод болсон. Тэр шалгагдаад, цаашидын хугацаанд хэдэн их наяд төгрөг энэ Монгол Улсдаа буцаж ирэхийг хэн ч

мэдэхгүй. Гэхдээ тэр мөнгийг эргүүлээд энэ авлигын мөнгө гэдэг бол тэр чигээрээ төрийн боломжийг ашиглаж, татвар төлөгчдийн мөнгөнөөс хулгайлсан өөрөөр хэлбэл татвар төлөгчдийн мөнгө учраас энийг зөрүүлээд татвар төлөгчдийн үр хүүхдүүдийн төлөө, ирээдүйн сайн сайхны төлөө зарцуулдаг ийм хөрөнгийн эх үүсвэр болгоход манай бас гишүүд бас дэмжиж, саналыг бас дэмжинэ гэдэгт би итгэж байна. Тэгээд тэр дундаа ялангуяа Хүүхдийн эрүүл мэндийн даатгалын сан гэдэг бүр ингээд тусгай категоричилж өгмөөр байгаа байхгүй юу. Тэгэхгүй бол нэг ийм нэгдсэн сан дотор ингээд яг хүүхэд рүү хэд нь чиглээд байгаа юм. Яагаад байгаа нь мэдэгдэхгүй өнгөрчихдөг. Тийм болохоор би яг ийм Хүүхдийн эрүүл мэндийн даатгалын санг бий болгох, хүүхэд хамгааллын хүүхдийн эрхийг хамгаалах ийм сан гэдэг юугаар. Хүүхдийн сан биш. Ингэж ийм сан болгоё. Тэгээд энэ хураасан орлогын дийлэнх хувийг хүүхэд хөгжил, хүүхэд хөгжил биш, хүүхдийн эрүүл мэнд, хүүхдийн эрхийг хамгаалах сан руу хөрөнгө орлогын шилжүүлдэг байхаар ийм төслийг бас юу яаж өгөөч ээ гэж бодож байгаа юм. Яах вэ миний илэрхийлэл буруу байгаа байх л даа. Гэхдээ миний санааг бол ойлгож байгаа байх гэж бодож байна.

Тэгээд ер нь бол түрүүн уучлаарай. Одоо бас жоохон реакцалчихлаа. Гэхдээ яг үнэнийг хэлэхэд яг энэ асуудал над дээр маш их ирдэг. Өдөр болгон хүүхдийн эрүүл мэндтэй холбоотой, өдөр болгон өнөө маргаашгүй амь нас нь дээсэн дөрөөн дээр байгаа асуудлууд над дээр төвлөрч ирдэг. Тийм учраас миний зүрх сэтгэл маш их шаналдаг. Өглөө болгон та бүхэн босохдоо дор хаяж 3, 4 хүүхдийн эрүүл мэндийн асуудал энэ эцэг эхчүүдийнх нь орлого, санхүү хүрэлцэхгүй амьдралын боломж хүрэлцэхгүй энэ хэдэн 100 сая төгрөгийн эмчилгээний зардал хүрэлцэхгүй яах вэ гээд ингээд гасалж байгаа иргэдийн бодит юмыг хүлээж авах бол үнэхээр хэцүү байдаг. Гэтэл манай Монголын төрд мөнгө

байгаад байна. Бүхэл бүтэн 18 тэрбум төгрөгийг 3 жилийн хугацаанд ингээд өчнөөн олон хүүхдүүд үхэж үрэгдээд, амь нас нь дээсэн дөрөөн дээр байж байхад бид нар энийг зүгээр хадгалаад сууж байна гэдэг бол дэндүү харамсалтай. Тэгээд ингээд төрийн юм гэхээрээ нэг их олон шат дараалаад хүнд суртал үүсдэг. Гэтэл цаана нь хүүхдийн амь нас цаг хугацаагаар хэмжигдэж байдаг. Цаг минутаар хэмжигдэж байдаг. Тийм учраас яг энэ саналыг бол би бас ойлгосон болов уу манайхан. Дэмжээд өгөөсэй гэж бодож байна. Ер нь бол дэмжих байх гэж итгэж байна. Тэгэхгүй бол ингээд Эрүүл мэндийн даатгалын сан гэхээр хүүхдийн юм дандаа орхигдчихдог. Дандаа томчуудын асуудал хэлэлцэгдээд байдаг. Тэгэхээр энэ дээр бас гишүүдийгээ бас дэмжиж өгөөрэй. Энэ саналыг. Энэ хууль бусаар олсон орлогыг буцаан төсөвт авч байгаа энэ мөнгө мөнгийг Хүүхдийн эрүүл мэндийн даатгалын сан, Хүүхдийн эрхийг хамгаалах санд төвлөрүүлдэг байя гэсэн ийм зарчмын зөрөөтэй саналыг оруулж байна.

Дам.Цогтбаатар: Харин би одоо яг тэр боломжийг өгөх гэж байна. Энэ зарчмын зөрүүтэй саналтай, Нара гишүүний гаргаж байгаа саналтай холбогдуулж асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү. Сайнзориг гишүүнээр тасаллаа. Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Ер нь бол Улсын Их Хурал дээр Байнгын хороодыг мэргэжлийн салбараар нь байгуулж өгдөг. Тэгээд бид бол Хууль зүйн байнгын хороо дээр сууж байна. Яг энэ эрүүл мэндтэй холбоотой асуудал бол өөр Байнгын хорооны чиг үүрэг. Хэрвээ бид нарыг ингээд Байнгын хороо болгон өөрийнхөө чиг үүрэг, эрхэлсэн асуудлаас халиад өөр Байнгын хорооны асуудлыг шийдээд байх юм бол утгаа алдана. Тухайлбал одоо жишээ нь Нийгэм хамгааллын бодлогын байнгын хороон дээр хууль зүйн асуудлыг авч

хэлэлцэнгүүтээ Эрүүгийн хууль ямар байхыг шийдээд эхлэх юм бол энд Хууль зүйн байнгын хороо гэж байх утга байхгүй болчих байхгүй юу. Бид нар бүр бүх Байнгын хороогоор явж манай салбарыг юу болгочих нь вэ гэж болгоомжилж айдаг тийм ажил хэргийн буруу зохион байгуулалт руу орно. Тэгэхээр үнэхээр ийм сан байх шаардлагатай гэж үзэж байгаа бол энийг Нийгмийн бодлогын байнгын хороон дээрээ та Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд тэнд нь саналаа гаргаад, тэнд нь мэргэжлийн Байнгын хороогоор нь саналыг нь хураалгуулаад шийдсэн нь зөв байх.

Зүгээр Хүүхдийн эрхийг хамгаалах сан гэж тусдаа байх уу, үгүй юү гэдэг бол харин манай Хууль зүйн байнгын хорооны асуудал байж магадгүй. Хохирол барагдуулах сан болон өөр бусад сангуудтай зэрэгцээд ийм сан үүсгэх боломж манайд байна уу, үгүй юү гэдгийг эрхэлсэн сайд нь бас судлаад хэлнэ биз. Тэр асуудал дээр бол байх байх. Гэхдээ яг энэ сан байгуулахаар нөгөө Сангийн яам чинь бас нэг бөөн асуудал босгож ирдэг. Тэгэхээр Сангийн яамны бас эрхлэх асуудал учраас Эдийн засгийн байнгын хороо байна уу, тэр хэсэг дээр бас энэ тухайгаа ярилцахаас өөр аргагүй болох байх гэж харж байна.

Нара гишүүний ярьж байгаа энэ асуудал дээр ажлын хэсэг дээр бас юу яригдсан бэ гэхээр одоо энэ авлигатай тэмцэх, авлигын гэмт хэргээс учирсан хохирлыг барагдуулахтай холбоотойгоор ингээд мөнгө олоод ирэхээр энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж байгаа бол хууль сахиулах байгууллагуудын чадавхыг сайжруулахад зориулж ашиглана гээд тавьчихсан байгаа нь ажлын хэсэг дээр бас ямар маргаан гаргасан бэ гэхээр энэ өөрөө ингээд зохистой биш байна. Өмнө нь ингээд татварын байцаагч нар татвар хураачхаад хураасан татвараасаа өөрсдийгөө шагнадаг тийм зарчим ажиллаад, энэ өөрөө шударга биш байна нэг талаасаа. 2-т нь хийх

ёстой ажлынхаа хийснийхээ төлөө дахиад шагнал авдаг тогтолцоо бүрдүүлээд байсан.

Харин манайх яг үүнтэй адилхан гэмт хэрэгтэй тэмцдэг байгууллага тэмцсэн гэмт хэргийнх нь хохирлыг буцаагаад тэр байгууллагад өгдөг болчих юм бол энэ байгууллагын ажлаа хийх хууль зүйн сэдэл зорилго тэс өөр зорилго руу шилжинэ. Тэгээд энийг өөрчлөх ёстой юм байна гэдэг санал гарч байгаа юм.

Тэгэхээр ер нь гэмт хэргээс учирсан хохирлыг барагдуулахад хохирогчийн эрхийг хангахад зориулж нэг хэсгийг нь гаргах байх. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд зориулж нэг хэсгийг нь гаргах байх. Нэг хэсэг нь улсын төсөв рүү ороод, тэр төсөв дээрээ харин Нара гишүүний хэлж байгаа шиг бусад Байнгын хороо, яамнууд нь асуудлаа тавьж байгаа бол Улсын Их Хурал, Засгийн газар төсөв хэлэлцдэг тэр зарчмаараа хуваарилах нь зөв байх. Нэг ийм зарчмуудыг бид нар бодохгүй бол мөдхөн.../минут дуусав/

Дам.Цогтбаатар: Нара гишүүний микрофоныг өгье. Харуулъя.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр энэ асуудал болохоор нөгөө зөвхөн сангийн тухай асуудал биш. Би хувьдаа энэ төслийн 4 дүгээр бүлгийн 4.2.1.4-д заасан авлигаас олсон орлогыг хураан авч, тухайн орлогыг хэргийн одоо хохирлыг барагдуулах хууль сахиулах байгууллагын чадавхыг нэмэгдүүлэх болон нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ гээд заачихсан байгаа учраас энэ манай Байнгын хорооны асуудал гэж би хувьдаа харж байгаа байхгүй юу. Тийм биз дээ. Би буруу бодсон байна уу. Тэгэхээр яг эндээс үүсэж байгаа энэ орлогыг нийгмийн тулгамдсан асуудалд одоо зарцуулах хүрээнд ийм санг байгуулаад, бий болгоод энэ сан руу төвлөрүүлдэг байя гэсэн санаа юм байгаа юм шүү.

Тэгэхээр би бол бас яг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын, Нийгмийн бодлогын байнгын хорооны асуудал мөн боловч нөгөө талаараа бас манай Байнгын хорооны асуудал мөн гэж би хувьдаа бодоод байгаа юм. Тэгэхдээ надаа бас юу байж магадгүй л дээ учир дутагдалтай одоохондоо бас бүрэн мэдээгүй юм бас байж байж магадгүй. Зааж зөвлөөд өгөөрэй.

Дам.Цогтбаатар: Сайнзориг гишүүнд микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би бараг Тэмүүжин гишүүн бид 2-ын асуух гэж байсан, хэлэх гэж байсан зүйл давхацчихлаа. Тэгэхдээ яах вэ, зүгээр гишүүддээ хэлэхэд нөгөө бас л бусад Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний зааг хязгаарыг нь бид хэд бас хүндэтгэх нь зөв байх. Яах вэ зүгээр уялдаатай зүйлүүд их байдаг. Тэгээд тэр тус асуудлуудаа тус тусын Байнгын хороон дээр ярих нь дараа нь бас Хууль зүйн байнгын хороо бидний урдуур орж юм шийдсэнгүй ч гэдэг юм уу ийм хэл амнаас хэдүүлээ бас нэгэнт л одоо Байнгын хорооныхоо хувьд бол нэгдмэл шүү дээ. Үүнээсээ бас зайлсхийх бололцоо байх байх.

2 дугаарт яах вэ, энэ төсөв янз бүрийн ийм зүйлүүд дээр бол энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр яригдаж байгаа. Ер нь зүгээр шууд ийм сан байгуулна ч гэдэг юм уу энэ бол бас их төвөгтэй байдаг. Ер нь Засгийн газрын бас тодорхой хэмжээний тооцоо судалгаатай, тэр Төсвийн хууль тогтоомжтойгоо уялдуулж орж ирэхгүй бол гишүүн бүр л энэ татварын хууль тогтоомж төсвийн хууль тогтоомжоор оролдоод байвал бас их хэцүү байгаа.

Тэгээд дээрээс нь энэ Улсын Их Хурлын хууль, Улсын Их Хурлын хяналтын хууль гээд гишүүдэд маш өргөн боломж олгочихсон юм байна лээ. 7, 8 төрлөөр бас хяналт тавих гэдэг юм уу, мэдээлэл сонсох, асуулга тавих гэх зэрэг, хяналтын сонсгол хийх ч гэдэг юм уу олон

боломжууд байна. Энэ хүрээгээ бид нар зөв ашиглаад зарим зүйлүүд дээр ингээд явах нь зөв байх. Яах вэ, Нара гишүүний хөндөж байгаа зүйл бол угаасаа угаасаа Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын хэсэг дээр бас яригдаж байгаа. Тэмүүжин гишүүн бас хэлчихлээ. Тэгэхээр бид хэд бол бас энэ орж ирж байгаа зүйлийг бас яг зөв зүйлд нь зарцуулах ёстой. Түүнээс биш яг нэг байгууллагын алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдэхэд зориулна гэдэг энэ зүйлийг бол тухайлан заах бол маш буруу зүйл гэдэг зүйл дээр бол бас ажлын хэсгийн гишүүд бол зарчмын хувьд нэг байгаа. Тийм учраас яг Нара гишүүний хувьд энэ саналаа хураалгах шаардлага байгаа юу, үгүй юу та бас бодоорой л гэж зүйлийг би бас хэлье дээ. Би нэг их асуух больчихлоо. Тэгээд одоо.../минут дуусав/

Дам.Цогтбаатар: Нара гишүүнд микрофоныг нь өгчихье.

М.Нарантуяа-Нара: Жишээлбэл түрүүн байгаль орчны асуудал бас яригдсан. Энэ дээр хүүхдийн асуудал бас ярьж болох байх. Гэхдээ хүүхэд гэхээс илүүтэйгээр энд төвлөрсөн, энд орж ирж байгаа энэ буцаан хураагдаж байгаа энэ мөнгөн дүнг тийшээ зарцуулъя гэсэн. Өөрөөр хэлбэл 4.2.1-ийн 4.4-ийн хүрээнд санал оруулж байгаа байхгүй юу. Тэгээд энэ нөгөө Засгийн газрын салбар бүрийн мөрийн хөтөлбөрт санал тусгуулах талаар л яриад байгаа байхгүй юу. Одоо чинь бид нар тэрийг хэлэлцээд байгаа биз дээ.

Дам.Цогтбаатар: Энэ дээр би нэг өөрийнхөө байр суурийг хэлчихье гэж бодож байна. Энэ дээр нэг ийм асуудал байгаа юм Нара гишүүн ээ. Энэ яах вэ нэгэнт та бүрэн эрхийнхээ хүрээнд зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа болохоор санал хураалт энд явуулна. Тэгэхдээ бас гишүүдийн хэлж байгаа ер нь бол манай бүх гишүүдэд хамааралтай Хууль зүйн байнгын хороо дээр, мэдээж Хууль зүйн байнгын хорооныхоо хүрээнд

энэ асуудлуудаа яриад явж байх ёстой. Зүгээр энийг би таны энэ гаргаж байгаа асуудал бол манай Байнгын хорооны хүрээнд бас орж болно. Яагаад гэвэл яг Авлигатай тэмцэх хуулийн хэрэгжилтийн маш тодорхой асуудлыг ярьж байна шүү дээ. Хууль хяналтын байгууллага одоо энэ хуульдаа захирагдаж явна. Тэр хуулийг хэрэгжүүлэх явцдаа хэрхэн хэрэгжүүлэх вэ, мөнгө, санхүүг хэрхэн хуваарилах вэ гэдэг асуудлыг ярьж байна. Энэ нөгөө Байнгын хороодтой бас холбоотой л асуудал. Зүгээр энэ дээр миний хувьд бол гэхдээ нэг ийм асуудал байгаа юм. Одоо жишээлбэл энэ чинь улсын төсөвт ороод ирчхээд байна шүү дээ. Түүнээс энэ мөнгийг эзэнгүй хаячхаагүй. Улсын төсөвт нэгэнт ороод ирсэн бол төсөв хуваарилж байхад яаралтай зайлиггүй, шаардлагатай маш олон асуудал гарна. Түүнээс та сая энд 1 Байнгын хороонд сууж байгаа гишүүддээ тулгаж байгаа, санаандгүй та тэгж бодоогүй байх. Гэхдээ тулгаж байгаа асуудал чинь энийг дэмжихгүй бол авлигачдыг дэмжээд байгаа ч юм шиг ийм болох гээд байна шүү дээ. Үгүй. Авлигачдаас мөнгийг нь авах ёстой. Тэр дээр бол асуудал байхгүй байна шүү дээ. Нэгэнт төсөвт ороод ирнэ гэдэг бол төрийн өмчит ороод ирчихсэн байж байгаа байхгүй юу. Хаана хуваарилахаа тухайн үед Сангийн яам нь шийдэх болохоос биш, одоо яг энэнд хийж байна гэх юм бол таны санал чинь жишээлбэл ийм болж байгаа байхгүй юу. Төсөвт энэ юунд оруулчих юм бол энэ 4 жилдээ хөтөлбөр маягаар л явах нь байна шүү дээ. Гэтэл та бол уг нь хэрэв тэгэх юм бол энэ чинь байнга хуулийн журмаар энэ хөтөлбөрийн цаана ч гэсэн тэгвэл үйлчлэл явах ёстой мөн чанартай юм яриад байгаа байхгүй юу. Тэгтэл энэ чинь угаасаа тодорхой хугацааны л юм байна шүү дээ. Тэгэхээр эсвэл танд бүрэн эрх нь байж байгаа юм чинь тусдаа хууль санаачлаад та оруулж болно. Түүнээс яг энэ дотор гэвэл ийм хуулиар зохицуулах хэмжээний асуудлыг та хөтөлбөрт улс төрийн шинж чанартай маш богино хугацааны юм руу оруулах

гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чинь өөрөө цаад таны хүсээж байгаа зорилго авцалдаалгаатай хэр нийцэх бол гэдэг ийм яах аргагүй асуудлын зөрчил бол өөрөө үүсгээж байна л даа. Тэгээд энийгээ бол та дараа нь хуулиа санаачлаад ер нь ингээж орж ирсэн мөнгийг ийшээ зарцуулж байя гэвэл энэ тогтмол хууль болчихно шүү дээ. Тэгвэл байнга хэрэгжээд явна. Тэгэхгүй бол энэ чинь түр хугацааны юманд та оруулах гээд байгаа байхгүй юу. Ийм л байдал ажиглагдаж байна. Ингээд би томьёоллыг танилцуулаад өгье. Тэгээд санал хураая.

Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.4-д өөрчлөлт оруулах:

“авлигаас олсон орлогыг хураан авч, тухайн орлогыг Хүүхэд хамгаалах сан, Хүүхдийн Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэн зарцуулах” гэсэн ийм томьёоллоор дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 37,5 хувиар энэ санал дэмжигдсэнгүй. Ганбат гишүүн дэмжсэн байна. Ганбат гишүүнийг дэмжсэнд тооцоод оруулаарай. Тэгэхээр хувь хэмжээ нь арай өөр болж байгаа байх. Тэрийг бас манай Байнгын хорооныхон тэмдэглээд аваарай. Тийм, танд тэр эрх чинь бол байж байгааг би танд сануулж хэлсэн тээ.

Одоо 2 дахь саналыг Уянгахишиг гишүүний саналыг би танилцуулаад явчихъя. Уянгахишиг гишүүний микрофоныг өгье. Та эхлээд өөрөө тайлбараа хэлчих үү.

Г.Уянгахишиг: Түрүүн нөгөө гаргасан зарчмын зөрүүтэй саналаа арай өөрчилж оруулж ирж байгаа. Өөрөөр хэлэх юм бол эхлээд бол 3 дугаар заалтыг тодорхой хэсгийг өөрчлөх санал байсан бол одоо өөрчилж оруулж байгаа санал маань 3 дугаар хэсгийг бүхэлд нь хасах гэсэн санал оруулж байгаа. Тэгэхээр үүний шалтгаан нь болохоороо энэ тогтоолын маань нэр нь өөрөө “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл

ажиллагааны хөтөлбөр батлах тухай” гээд ерөнхий тогтоол байгаа юм. Тэгэхээр энэ бүсчилсэн хөгжлийн хөтөлбөртэй үзэл баримтлалд оруулах өөрчлөлттэй холбоотой асуудлыг тусдаа тогтоолоор яах вэ, одоо өнөөдөр хэлэлцэж болно. Гэхдээ тусдаа тогтоолоор явах ёстой гэж хараад байгаа юм. Зарчмын хувьд. Яагаад гэхээр яг энэ 3 дугаар заалт маань энэ хөтөлбөр дээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр туссан маш олон зүйл заалтууд өөрөө бас цаашаагаа өөр өөрчлөлтүүдийг хөтөлбөрүүд дээр болон төслүүд дээр бодлогын бичиг баримтууд дээр өөрчлөлтүүдийг авч явна. Гэтэл яг одоо энэ үйл ажил гааны хөтөлбөр батлах тухай тогтоол дээрээ тухайлан нэг хөтөлбөрийнхөө өөрчлөлтүүдийг тусгаад явчихаар цаашидаа хэрэглэхэд ч тэр буцаагаад яг энэ тогтоолынхоо бүтцийн хувьд ч гэсэн зөв биш харагдаад байна л даа. Тэгэхээр энэ дээр бас Хууль зүйн яамнаас санал сонсмоор байгаа юм.

Тэгэхээр энэ 3 дугаар зүйлийг байхгүй, ерөөсөө батлах ёсгүй гээгүй шүү. Харин тусдаа тогтоолоор баталж явах ёстой юм болов уу. Тийм учир бас энэ том хөтөлбөр батлах тухай тогтоолоосоо хасаад, энэ хөтөлбөр батлах тухай тогтоол маань цаашидаа яг л бүх юмны толгой хэсэг болж явна шүү дээ. Тэгэнгүүт нөгөө бүсчилсэн хөгжлийнхөө хөтөлбөртэй холбоотой өөрчлөлт юм тусгах гэхээр дахиад энэ тогтоолоо чирч авчраад байдаг болчих вий дээ. Тэгэхээр ийм саналтай байгаа учраас зарчмын зөрүүтэй санал нь дугаарт 3 дугаар зүйлийг бүхэлд нь хасах санал оруулж байгаа.

Дам.Цогтбаатар: Энэ саналтай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Би нэг юм асуумаар байна.

Би өөрийн чинь хэлж байгааг ойлгож байна. Тэгэхдээ Алтангэрэл сайд бас энэ дээр нэг тодруулаад хэлэх нь зөв байх. Би юунаас болгоомжилж байна

гэхээр одоо энэ бол жинхэнэ нөгөө шууд явц дунд наадуул чинь бол олон цаг бодчихоод ороод ирчихсэн байна шүү дээ. Би бол жишээлбэл бодож амжихгүй байна. Одоо энд ингээд тас гээд хасчихаар өөрийг чинь харин протоколд үлдэх нэг чухал юм. Хассан ч гэсэн энд байгаа юмыг хасаж байгаа биш өшөө цаана олон байгаа юмыг эндээ оруулаад эд нар чинь энийг хаслаа гээд үлдэж байна гэж өөрөө хэлээд байна шүү дээ. Миний айж байгаа, болгоомжилж байгаа эрсдэл юу вэ гэхээр ингээд тодорхой заачихсан юмыг нь бүр хасчихлаар нөгөө амьдрал дээрээ хэрэгжихээр эд нар чинь бүүр орхигдоод явчих вий гэдэг надад бол болгоомжлол гарч байна. Уг нь өөрөө өргөтгөх гэсэн боловч өргөтгөсөн биш бүр ингээд хасаад наадах чинь дурдагдалгүй өнгөрчихөөр бүр эзэнгүйтэйд үлдэх вий гэдэг нэг тийм эрсдэл надад харагдаж байна л.

Тэгэхээр Алтангэрэл сайд энэ дээр байр сууриа хэлэх үү. Бас миний энэ юунд та хариулчих Уянгахишиг гишүүн ээ.

Г.Уянгахишиг: Тэгэхээр энэ дээр одоо хөтөлбөр маань өөрөө арай батлагдаагүй байгаа. Тэгэнгүүт хөтөлбөр батлахтай холбоотойгоор дотор нь бас нэлээн олон юмнууд өөрчлөгдөж болно. Одоо ялангуяа ажлын хэсэг ажиллаж байна. Бусад Байнгын хороод бас хэлэлцэж байна. Тэгэнгүүт хөтөлбөр маань нөгөө том зургаараа хөтөлбөр батлагдсаны дараа тэр хөтөлбөрт нийцүүлээд тухайн хөгжлийн үзэл баримтлал ч юм уу, тухайн хөтөлбөрүүдэд дагах бодлогын бичиг баримтуудад өөрчлөлт орох боломж нь байгаа. Тэрнээс яг энэ хөтөлбөр батлахтайгаа давхиулаад яг нэг хөтөлбөрийн тухай заалтыг энэ тогтоол дотор оруулж ирнэ гэдэг л буруу санагдаад байгаа юм. Тэрнээс биш нэгэнт хөтөлбөр батлагдсаны дараа бүгд өөрчлөгдөөд, өөрчлөлтүүдээ энэ Үндсэн тогтоолоо үндэслээд өөрчлөх боломжууд нь байгаа шүү дээ. Тэгэхээр тэр тогтоолууд тухайн үедээ

батлагдаад явахгүй бол бид нар ингээд задгайд ч гэсэн нөгөө үйл ажиллагааны хөтөлбөрийнхөө тухай ярьж байна. Одоо тэр нэг төсөв хөтөлбөрийн тухай ч яригдана. Тэгэнгүүт энэ болгон яригдаад, явагдаад үүнийхээ хавсралтаар явдаг. Гэтэл үндсэн тогтоол дотроо яг нөгөө бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрийн маань өөрчлөлтүүд нь тусгагдаад явахаар нэг ийм буцаж орсон юмнууд болоод явчих вий л гэдэг санал байгаад байгаа юм.

Нөгөө талаасаа энэ хөтөлбөр батлах тухай тогтоолоо бид нар бас Их Хурлаараа, чуулганаараа хэлэлцүүлээд явна. Тэгэнгүүт нөгөө хөтөлбөртэйгөө холбоотойгоор яг энэ тогтоолынхоо бас 3 дугаар зүйл чинь чирэгдээд энэ нөгөө тогтоолын хэсэг болоод бас ингээд явна шүү дээ. Тэгэхээр энийг тусдаа тогтоолоор явчихвал яасан юм бэ л гэдэг саналтай байгаад байгаа байхгүй юу.

Дам.Цогтбаатар: Алтангэрэл сайд энэ дээр хариулъя. Та хөтөлбөрөө авч орж ирээд эрх зүйн хувьд яг нээрээ та хамгаалахгүй бол би бол санал хураалгана шүү дээ энэ дээр.

О.Алтангэрэл: Агуулгын хувьд бол санаа зовниж хэлж байгаа санааг Уянгахишиг гишүүнтэй адилхан байгаа юм. Тэгэхдээ техникийн хувьд бол яг Цогтбаатар даргын хэлсэн шиг байдал үүснэ. Бид нарын яг батлуулъя гэж бодож байгаа, оруулъя, цаашаа хэрэгжүүлъя гэж бодож байгаа зүйлүүд маань тусгагдахгүй орхигдчих вий гэсэн асуудал байна. Тэгээд энэ дурдагдсан асуудлууд бол бас тус бүрдээ нэлээд их хэлэлцүүлэг болсон. Ажлын хэсэг, тэгээд бүр эхэндээ бол наадах чинь намуудаас гарсан ажлын хэсэг, дараа нь Засаг дээр гээд маш их олон шүүлтүүрийг давж гарсан учраас утга агуулгын хувьд Уянгахишиг гишүүний зовнилыг ойлгож байгаа ч гэсэн үр дагаврын хувьд бол бас яг хэрэгжих ёстой зүйлүүд орхигдохгүй үлдчих вий гэсэн санаа зовнил байна.

Дам.Цогтбаатар: Тэгвэл ингэе. Нэгэнт гишүүн санал гаргасан байгаа болохоор санал хураалт. Уянгахыг гишүүн ээ, нэмээд тайлбар өгүүлье. Уянгахыг гишүүний микрофон.

Г.Уянгахыг: Саяын яг хэлж байгаа нөгөө юм гээгдчих вий гэдэг дээр бас санаа зовоод байгаа учраас яг нэг юмыг ийшийгээ чихээд яах юм бэ л гэдэг санаа байхгүй юу. Өөрөөр хэлэх юм бол хөтөлбөр бол тэр чигээрээ угаасаа хавсралтаараа явна. Хөтөлбөрөө дагаад бусад бичиг баримт нь явна. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор чиг үүргийн албан тушаалтнууд болон газруудад өгсөн үүрэг даалгаврууд нь явж байна. Тэгээд энэ тогтоол батлагдсанаараа хүчин төгөлдөр явна гэдэг заалт нь байж байна. Тэгэнгүүт Хууль зүйн сайдын хэлж байгаа ч тэр, Байнгын хорооны даргын хэлж байгаа ч тэр энэ хөтөлбөрийг баталсны дараа өөрчлөгдөх ёстой юмнууд бүгд энэ тогтоол дотор тусгах ёстой юм бол юм хаягдах вий гэдэг чинь жинхэнэ тэнд л байгаад байгаа байхгүй юу.

Гэтэл өнөөдөр 3 дугаар зүйл дээр зөвхөн бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрийн тухай л байгаа. Өөр юм байхгүй. Тэгэхээр ингэж тусгайлан нэг юмыг оруулж ирснээрээ бусад орох ёстой юмнуудаа хаячих вий гэдэг санаа чинь өөрөө энэ дотор агуулагдаад байгаа байхгүй юу. Тийм учраас тэрнээс зайлсхийхийн тулд тогтоол яг том буюу хөтөлбөрөө батлах хэмжээндээ яваад, харин энэ тусгайлсан юмнуудаа тусдаа тэр хөтөлбөрөө дагуулаад тусдаа тогтоолуудаараа батлаад явбал энэ харин асуудал хаягдахгүй байх магадлал нь өндөр болно л гэж хэлэх гээд байгаа юм.

Дам.Цогтбаатар: Тэгээд одоо санал хураалтаа явуулъя. Хууль зүйн яамнаас хэн хариулах вэ. Хэддүгээр микрофон. 8 дугаар микрофон.

Н.Мягмар: Уянгахыг гишүүний асуулт дээр сайдын хэлснийг тодотгоод би бас хэлье. Өөрөөр хэлэх юм бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа бол ажлын хэсэг дээр энэ бүсчилсэн хөгжилтэй холбоотой асуудлыг энэ хөтөлбөрт туссан. Энэ агуулгаараа бол тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон асуудлаа бол хөтөлбөрийн хавсралтаар баталсан зорилт арга хэмжээнүүдээ бол тусчихсан учраас үүнтэй холбоотойгоороо Улсын Их Хурлаар баталсан тогтоолуудад зөрчил үүсгэхгүйн тулд яг энэ бүсчилсэн хөгжилтэй холбоотой батлагдсан Улсын Их Хурлын тогтоолууддаа өөрчлөлт оруулах ийм 3 дахь заалтыг бол тогтоолын төсөлд оруулж ирсэн байгаа юм. Тийм учраас энэ төсөл хэрвээ цаашид хавсралтуудын юмнууд маань хэвээрээ батлагдаад ингээд явах юм бол 3 дахь заалтыг хасчих юм бол хүчин төгөлдөр Улсын Их Хурлын тогтоолууд хоорондоо зөрчилдөх хууль зүйн техникийн асуудал үүснэ. Тийм учраас энэ заалтыг бол хасахгүйгээр явж байгаад, хэрэвзээ ардах хавсралтад байгаа бүсчилсэн хөгжилтэй холбоотой зорилт, арга хэмжээнүүд дээр өөрчлөгдсөн ийм тогтоолууд гарч ирэх юм бол угаасаа энэ зарчмын зөрүүтэй санал гаргахдаа 3 дахь заалт дээр холбогдох хэсгийг нь өөрчлөх энэ санал нь давхар гарч явахгүй бол энэ маань хууль зүйн техникийн хувьд бол зөрчил үүсчихнэ. Тийм учраас нэгэн зэрэг Улсын Их Хурлын хүчин чадалтай актууд маань хоорондоо зөрчилдөх ийм энэ нөхцөл байдал руу орчих учраас Уянгахыг гишүүний гаргаж байгаа энэ саналыг бас Хууль зүйн байнгын хорооны гишүүд маань бас анхааралдаа авч үзээсэй гэж ингэж хүсэж байна.

Дам.Цогтбаатар: Уянгахыг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахыг: Энэ дээр нэг тодруулаад асуучих уу. Одоо тодорхой нэг Их Хурлын тогтоолоор хөтөлбөр

жишээлбэл батлагдчихлаа тээ. Тэгэнгүүт тэр хөтөлбөртэйгөө уялдаад өөр бусад Улсын Их Хурлын тогтоолуудаар батлагдсан бичиг баримтууд өөрчлөгдөж болно шүү дээ. Тэр тохиолдолд заавал тэр тогтоол дотроо тусгаж явах ёстой юу. Эсвэл нөгөө адилхан энэ тогтоолоо дагаад өөрчлөлтөө ороод явж болох уу гэдэг асуулт гарч ирж байгаа гэсэн үг. Өөрөөр хэлэх юм бол зөрчилдөнө гээд байна шүү дээ. Тэгэхээр нэгэнтээ энэ тогтоолоор хөтөлбөр батлагдаад явахад энэ хөтөлбөртэй зөрчигдөж байгаанууд ч угаасаа дагалдаад өөрчлөлт ороод явах ёстой биз дээ. Тэгэхээр энийг тусдаа тогтоолоор энэ хөтөлбөр баталсантай холбоотойгоор энэ нөгөө бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалынхаа баталсан тогтоолдоо өөрчлөлт оруулаад хавсралтад нь өөрчлөлт оруулж батлах тухай гээд л явж болно биз дээ ер нь бол зарчмын хувьд. Уг нь тэгж явдаг гэж би бол ойлгоод байгаа юм.

Тэгэхээр энийг заавал ийшийгээ оруулаад яваад байх нь ямар байгаа юм бэ гэдэг л санал байгаад байгаа шүү дээ. Тэрнээс биш энд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг ерөөсөө өөрчлөхгүй ээ. Тэрийг баталсан тогтоол ерөөсөө хөдөлж болохгүй ээ гэдэг юм ерөөсөө яриагүй. Тэр хөтөлбөрөө тусдаа баталдаг тогтоолоороо баталчхаад, үзэл баримтлалаа тусдаа тогтоолоороо батлаад ингээд бүх юм чинь өөр өөрийнхөө юугаар явбал яадаг юм бэ. Тэгэхэд дараа нь ашиглахад ч гэсэн уг нь арай л хялбар баймаар л санагдаад байгаа юм.

Дам.Цогтбаатар: Одоо ингээ санал хураалт руугаа. Би сая өөрт чинь татаад авах боломж өглөө. Та санал хураалт руугаа оръё гэж байх шиг байна. Би бол тэгж ойлголоо. Одоо цаашаа хэлэлцүүлэг байхгүй. Угаасаа би нэмж харин боломжууд өгөөд байна шүү дээ.

Ингээд Уянгахыг гишүүний оруулж байгаа зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Тогтоолын төслийн 3 дугаар зүйлийг бүхэлд нь хасах гэсэн ийм томъёоллоор энийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 12,5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Дараагийн зарчмын зөрүүтэй санал. Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье. Одоо хэдүүлээ ингээд нэмээд бүр сая хэлэлцүүлэг шиг болоо. Одоо ингэж явахгүй шүү. Яг дэгийнхээ л дагуу явъя.

С.Эрдэнэболд: Баярлалаа. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүнгийн хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилт, түвшин хүснэгтлээд та бүхэнд тараачихсан байж байгаа. 12 шалгуур үзүүлэлт байгаа. Энийг хэлэхээсээ өмнө бид нар ингээд хурдтай хөгжлийн төлөөх зориг гээд хамтарсан Засгийн газрын хөтөлбөрийг томъёолчихсон байгаа. Эдийн засаг, хөгжлийн яам руу л хандаж хэлэх гээд байгаа шүү. Тэгээд хурдтай хөгжил гэдгээ бид нар бол ер нь бол улс төрийн шийдэмгий байдал, хамтарсан Засгийн газрын давуу талыг ашиглаж том төсөл хөтөлбөрүүдийг хөдөлгөх эд нар гэж ойлгож байгаа. Гэхдээ энэ хурд гэдэг үгийн хажуу талд нь чанар буюу иргэдийн амьжиргаа орлого өссөн том дүнгээрээ бол Монгол Улсын өрсөлдөх чадвар ахисан байна гэж ойлгож байгаа. Зорилтыг нь. Тэгэнгүүт Засгийн газрын яг энэ шалгуур үзүүлэлт дээр нь нийтдээ 12 зүйл байгаа юм. Тухайлбал Хүний хөгжлийн индексийг 10 байраар урагшлуулна. 96-аас 86 хүртэл.

Ядуурлын түвшинийг 2 дахин бууруулна. 1 хүнд оногдох ДНБ-ийг 5,8 мянган долларыг нь 10400 руу оруулна гээд нийтдээ 12 шалгуур байна. 12 шалгуурыг гишүүд маань бас харж байгаа байх. Эдийн засгийн өсөлт, инфляци, зээлжих зэрэглэл, эдийн засгийн

эрх чөлөөний байдлын индекс, бизнесийн орчны ерөнхий үнэлгээ, дэлхийн инновацын индекс, засаглалын үзүүлэлтийн дундаж, дэлхийн сайн орон индекс, авлигын төсөөллийн индекс гээд. Тэгээд энэ 12 дээр 1 зүйлийг нэммээр байгаа юм. Юу гэхээр сүүлийн 11 жил Өрсөлдөх чадварын үндэсний хүрээлэнгээс өрсөлдөх чадварын судалгаа гаргаж байгаад сүүлийн 3, 4 жилийн хугацаанд талант индекс буюу ур чадварын индекс гэдэг зүйлийг Монголд нэвтрүүлж байгаа. Энэ бол дэлхийн хэмжээгээр Цогтбаатар дарга мэдэж байгаа байх. Одоо ур чадварын индексийг нэвтрүүлж байгаа. Үүний зорилго нь юу вэ гэхээр бид нар ингээд л нэг ийм хуурай цаасан дээр баахан индексүүд шалгаад байдаг. Гэхдээ яг бодит байдал дээр иргэдийн амьдралд буюу нөгөө улс орны иргэдэд маань энэ нь хэр зэрэг очиж чадавч болж байгаа юм бэ гэдгийг энэ индекс судалдаг. Тэгэхээр одоо бид нар ингээд маш их дипломтой төгсөгчид гарч байгаа хэрнээсээ Солонгос руу хар ажил хийх гэж яваад байдаг. Эдийн засгийн өсөлт цаасан дээр мөртөөсөө хүртээмжтэй эдийн засгийнх нь бодит чадавч байхгүй байгаад байдаг.

Тийм учраас миний энэ зарчмын чанартай санал гаргаж байгаа үндэслэл бол 1 дүгээрт энэ 12 төрлийн үзүүлэлт дээрээ талант индекс гэж нэрлэгддэг ур чадварын үзүүлэлтийг нэмж тусгаач ээ. Дэлхий нийтийн чиг хандлага ийшээ байгаа учраас энэ чадавчыг нэмээч ээ гэдэг ийм зүйл байгаад байгаа юм. Тэгэх юм бол бид нар нөгөө хэмжиж чадвал удирдаж чадна, тодорхойлж чадна гэдэг шиг хэмжүүрийнхээ тоог дахиад нэгээр нэмчихье гэдэг. Энэ бол зарчмын зөрүүтэй саналын маань үндэслэл байгаа юм.

2-т нь ер нь хэлэхэд бол бид нар ингээд манай ДНБ 1 хүнд оногдох ДНБ маань хэд байж байгаад өнөөдөр 2024 оны 8 сарын 20-нд хэд болсныг мэдэж байгаа. 4 жилийн дотор бид нар 2 дахин нэмэгдүүлэх тухай ярьж байна.

Ядуурлыг жилд 10 функтээр 10 хувь гэдэг чинь ойролцоогоор 2.7, 2.8 хувиар бид нар бууруулах тухай ярьж байгаа шүү дээ.

Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яам ч гэсэн энэ нь зүгээр асуулт биш зүгээр санал. Яг энэ хэмжих нэгжээ тодорхой болгомоор байна. Тухайлбал Алтангэрэл сайдаас би асууж байсан Их хурлын чуулган дээр. Транспаренси интернэйшнлийн индексийг та яаж буулгах гээд байгаа юм бэ гэсэн. Энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр бол одоо 180 орноос 121-д орж байгааг 91 рүү урагшлуулна гэсэн байгаа. 30 байраар. Тэгэхээр жилд 10 байрыг урагшлуулна гэсэн үг. Гэтэл энэ индексийг бууруулахад хэчнээн процент буюу хувь нь Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагаатай холбоотой, хэд нь түрүүн Бат-Эрдэнэ гишүүний яриад байгаа анхан, дунд шатын авлигатай холбоотой, хэд нь төрийн өмчит үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын авлигатай холбоотой юм бэ гэдгийг нарийвчлан ингэж статистикийг нь гаргаж байгаад, тэгээд энэ дээрээ бол бид нар зорилтуудаа тавимаар байгаа юм.

Төгсгөлд нь хэлэхэд Засгийн газрын мөрийн хөтөлбөрөө гаргачихдаг. Баахан зорилтууд тавьчихдаг. Тэгээд энийг нь хэрэгжүүлэх гээд баахан төсөв оруулж ирдэг. Тэгэхдээ төсөв нь ихэвчлэн нөгөө нэг энэ механизмаа боловсронгуй болгохоос илүү дэд бүтцийн чанартай төслүүд ороод ирдэг. Энэ 2-ын хоорондох уялдаа буюу нөгөө яаж энэ хөрөнгө оруулалт чинь энэ зорилго руугаа ажил хэрэг болж хүрэх гээд байгаа юм бэ гэдэг нь ингээд тодорхойгүй үлдчихээд байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол Засгийн нэгдсэн уялдаатай бодлого л хэрэгтэй болчихоод байгаа юм л даа. Тэгэхээр энийг тодорхой болгохын үүднээс тэр талант индекс буюу ур чадварын индексийг 13 дахь шалгуур болгож нэмье гэсэн саналыг гаргаж байгаа юм.

Дам.Цогтбаатар: Энэ саналтай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Ганбат гишүүн кнопоо дараарай. Ганбат гишүүнээр тасалъя. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би Эрдэнэболд гишүүний зүгээр саналыг бол ер нь зүгээр яах вэ ойлгож байна. Тэгэхдээ би бас нэгэнт энэ асуудал хөндөгдөж байгаа учраас уг нь энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг бас энэ олон улсын байгууллагуудын шалгуур үзүүлэлтээр бас дүгнэх асуудал бол эрсдэлтэй. Өөрөөр хэлэх юм бол энэ бас тодорхой цаг хугацаанд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг дүгнэх цаг хугацаатай давхцахгүй үеүд гарна.

2 дугаарт энэ тайлагналтын формат, нөгөө энэ хэрэгжсэн үү, хэрэгжээгүй юу гэдгийг Улсын Их Хурал хяналт тавих гэхээсээ илүүтэй жишээ нь одоо авлигатай тэмцэх Трансперенси Интернэйшнл-ийн доо энд байгаа зөвлөхүүд гэдэг юм юм уу тайлан илгээх тэр хүмүүсийн дүгнэлтээр явдаг ч гэдэг юм уу ийм олон зүйлүүд, эрсдэлүүд байдаг. Тэгэхдээ бид нар ийшээ тэмүүлж бас олон улсын байгууллагуудын үзэж байгаа тэр хандлага шалгуураараа өөрсдийгөө бас дүгнэх тэр чиглэл рүү явж байгаа нь зөв байгаа юм. Тэгэхдээ маш олон зүгээр ийм зүйлүүдийг оруулснаар асуудлыг шийдэх гэдэг юм уу яг бодитой хөрсөн дээрээ дүгнэлт өгөх тэр эргэлзээ бол хэцүү. Тэгэхээр цаашидаа бид нар энэ Засгийн газрын үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг дүгнэх өөрсдийн индекстэй болох, энэ датагаа цуглуулах, бид нар үнэндээ хэлэхэд яг суурь датанууд маань байхгүй байгаа учраас бас энэ өөрсдийн үндэсний энэ индексүүдээ гаргах энэ асуудал учир дутагдалтай байгаа нь үнэн. Тэгэхээр энийгээ ер нь зүгээр тооцож бодох ёстой шүү.

2 дугаарт ер нь энэ олон улсын байгууллагуудад бас өнгөрсөн цаг хугацаанд явж ирсэн юман дээр манайх

тайлагналтын асуудлаа хийж чаддаггүй байхгүй юу. Ерөөсөө тайлагнадаггүй юм. Тэгээд эндэх нөгөө үндэсний зөвлөхүүд гэдэг юм уу тэнд мэдээ илгээдэг хүмүүсийн ерөнхийдөө олж сонссон мэдээллийн хүрээнд дүгнэчихдэг. Жишээ нь, магадгүй авлигын индекс урагшлах бүрэн боломжтой байсан бид хэд тайлагнаагүй. Тайлагналтын хэсгүүд дээрээ алдсан зүйлүүд байгаа. Хугацаа хоцорчихсон. Мэдээж шийдэх ёстой хэд хэдэн асуудал байдаг. Тэгээд яг энэ авлигын индексийн хамгийн жишээ нь хэцүү хэсэг нь бол ерөөсөө л Эдийн засаг, хөгжлийн яамны асуудал байдаг. Ерөөсөө явж явж яг Эдийн засаг, хөгжлийн яамны гаргах, хариуцах ийм шалгуур үзүүлэлтүүдтэй болоод бас жишээ нь энэ урагшилдаггүй ийм зүйлүүд байж байгаа юм. Тэгэхээр энийг бас яг нэмэх шаардлага байгаа юу. Гишүүд маань бас бодолцоосой. Ер нь хэдүүлээ учир, ач холбогдлыг нь би ойлгож байна. Тэгэхдээ энэ ч гэсэн бас энэ 12 шалгуураар үзүүлэлтийг дүгнэнэ гэхэд бас эргэлзээтэй байгаа учраас та хэд маань бас бодолцоорой. Одоо яг энэ Засгийн газрынх нь орж ирснээр ингээд дэмжээд явуулчихвал яасан юм бэ л гэсэн ийм саналтай байгаа. Баярлалаа.

Дам.Цогтбаатар: Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье. Тайлбар хийе.

С.Эрдэнэболд: Товчдоо бол энд 12 төрлийн индекс маань Сайнзориг гишүүн ээ, ингээд тусдаа тусдаа нэгжүүд байгаа шүү дээ. Энийг сүүлийн 11 жил Монгол Улс competitiveness index буюу өрсөлдөх чадвар гэдэг утгаар нь илүү бизнес талаас нь ойлгоод байсан байх. Хүний хөгжлийн индекс бүгдийг нь нийлүүлээд тухайн улс орны өрсөлдөх чадварын индекс гарч байгаа. Би санал нэгдэж байгаа зүйлүүд зөндөө байна. Гэхдээ одоо яг сүүлийн үед яг үнэнээ хэлэхэд хэрэгтэй, хэрэггүй олон төрлийн индекс гэхээс илүүтэйгээр хүмүүсийнхээ амьжиргааг сайжруулсан, эдийн засгийн өсөлтөө томъёолол нь inclusive economics

буюу хүртээмжтэй эдийн засаг руу чиглүүлэхэд зориулалттай ийм индексүүд хэрэгтэй болчихоод байгаа. Тэр дээр бол энэ Talent index гарч байгаа шүү л гэдгийг хэлж байгаа юм. Жишээлбэл бид нар нэг хэсэг Аз жаргалтай Улаанбаатар хот гээд зорилго тавьчихсан шүү дээ. Тэгэнгүүт тэрийг чинь нөгөө happiness index буюу аз жаргалын индексээр гарахад мөш хэцүү байхгүй юу. Тэгээд би тийм хийсвэр зүйл яриагүй маш бодитой, сүүлийн үед олон улсад жишиг болж байгаа зүйлийг л энэ индекс дээрээ оруулчихъя гэдэг саналыг хэлж байгаа юм.

Дам.Цогтбаатар: Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Манай Эрдэнэболд гишүүний яриад байгаа зөв зүйтэй гэж бодож байна. Ер нь дэмжиж байна. Гэхдээ Засгийн газраас энэ 12 шалгаруулалтаар дүгнэе, гаргая гэж ийм юм оруулж ирж байна. Энийгээ бараг сар болгон, жил болгон гаргаад тайлагнаж байх хэрэгтэй. Тэгэхгүй бол 4 жил нь болоогүй байна гээд л яваад байдаг. Ингээд болсонгүй гээд тэгээд дарагдаад өнгөрдөг. Өмнөх 8 жил, алдагдсан 8 жил гэж яриад байгаа юм л даа. Цаашидаа ч алдагдсан 12 жил болох юм шиг байна. Нэг их олон төрийн албан хаагчтай, данхайсан төртэй, нэг их олон сайд нартай, нэг их олон яамтай. Лав л манай энэ Ардчилсан намын бодлого бол биш. Бид нар цомхон чадварлаг төрийг л хүсдэг. Ард түмэн ч тэгж хүсэж байгаа. Үүний эсрэг л яваад байгаа л даа. Тэгээд одоо энэ олон улсын гаднын байгууллагын дүгнэлтээр дэлхийн бас улс орны нэг болохоор тэрэнд нь хамрагдаад ингээд явах нь зөв байх. Тэгээд эцсийн эцэст аягүй л бол энэ олон улсын байгууллагуудын буруу болох нь л дээ. Тэр гаргаж байгаа дүгнэлтээр тэд нар буруу дүгнэдэг юм шиг. Энд яадаг вэ гэхээр одоо хар л даа. Өнөөдөр Улаанбаатар ямар байна. Тэр авлига хороолол өнөөдөр нүдэн дээр сүндэрлээд л байж байна шүү дээ. Бид энд бизнес эрхэлж байгаа

хүмүүсийг буруутгамааргүй байна. Эхнээсээ л тэр чинь зөвшөөрөл аваад л эхэлж байгаа шүү дээ. Нүдэн дээр л явагдаад байдаг. Тэрийг чинь ард түмэн харж л байна. Энэ Богд уулын хар. Үгүй ээ, энэ 1 сая 500 мянган хүн энэ Улаанбаатар хотод байна. Энэ эрүүл агаараар амьсгалмаар л байна шүү дээ. Хагас, бүтэн сайнд. Тэгээд гараад аялах гэхээр бүх амуудыг хаачихсан. Бүгд эзэнтэй. Үгүй ээ, энэ чинь дэлхий дээрх хамгийн анхны дархан цаазтай газар шүү дээ. Одоо хаана байна тэр нь. Үгүй ээ, тэгээд энэ мэтчилэн юмнаасаа л эхлэх хэрэгтэй шүү дээ. Энийг чинь хараад л сууж байна. Тэгээд Засгийн газар нь өөрөө өөрсдөө баахан үнэлгээ, дүгнэлт гаргаад ингээд явчихдаг. Энэ одоо ард түмнийг төлөөлөөд сууж байгаа Улсын Их Хурлын оройлол нь хаана байгаа юм. Энэ Улсын Их Хурал өөрөө ийм шалгуурыг нь гаргаж өгөх ёстой шүү дээ. Тийм болохоор гишүүд энэ дээр баахан санал, санаачилга гаргаад яриад байдаг. Тэгээд ийм байна. Энэ дээрээ анхаарч ажиллах ёстой.

Тэрний нэг илэрхийлэл нь гэхэд өнөөдөр Хууль зүйн байнгын хорооны хурал. Ганцхан Алтангэрэл сайдаас өөр хүн алга байна шүү дээ энэ дотор. Нэг их л олон яамтай, их л олон сайдтай. Үгүй ээ, 9 сайд байхад л болоо шүү дээ уг нь бол. 9 яам байхад л болоо шүү дээ. Үгүй ээ, энэ талаар одоо Засгийн газрын мөрийн хөтөлбөрт алга байна. Би тэр аюулгүй байдлын талаар цухас дурдлаа. Хэчнээн олон хүн нас барж байна вэ энэ сүүлийн үед. Энэ зам тээврийн асуудал, энэ үер усны асуудал. Ийм л байна шүү дээ.

Дам.Цогтбаатар: Ойлголоо. Би нэмээд уг хэлчихье гэж бодож байна. Миний хувьд энэ ур чадварын үзүүлэлт буюу энэ бол нэмчихэд гэм хоргүй зүйл байх. Яагаад гэвэл тэртээ тэргүй л бид өөрсдийн индекс энээ тэрээ боловсруулж байхаар дэлхийн аль хэдийн боловсруулчихсан юмыг аваад, хэрэгжүүлээд өөрийнхөө ажлыг дүгнэж

байхад нэг нэмэлт шалгуур байхад илүү л сайн л байх. Тэгээд бид нар өөрсдөө дэлхийд бэлэн болгочихсон шалгуурыг ахиад л өөрсдөө шинээр зохиож байхаар, тэр гаднынханд бэлэн аваад хийчихэд энэ дээр бол нэг их том өөрчлөлт гарахгүй, харин ажлаа дүгнэж байх нэг нэмэлт юу л гарч ирэх байх гэж бодож байна. Зүгээр харин энэ *global competitiveness talent index* гэж байдаг. Тэрийг л өөрөө хэлээд байх шиг байна тийм үү. Тэгвэл энийгээ дараа нь тэр найруулга эд нар дээрээ бас тал талдаа бодоцгооно биз. Ганбат гишүүн 1 минутаа нэмж авъя гэсэн. 1 минутыг нь өгье.

Д.Ганбат: Тэгээд энийг бол дэмжиж байна. Сая манай Цогтбаатар дарга ч гэсэн бас их зөв зүйтэй зүйл яриад байх шиг байна. Гэхдээ хэн нэгнийг зөв зүйтэй, буруу зүйл ярьж байна энэ тэр гээд би дүгнэдэг, барьдаг хүн биш л дээ. Тэгэх ч эрх байхгүй. Тэгэхээр энэ бас нэг юм алдагдаад байна. Тухайлбал Нара гишүүн санал гаргаж байна. Бүрэн эрхийнхээ хүрээнд л санал гаргаж байгаа шүү дээ. Тэр дэмжих, дэмжихгүйгээ тэр кнопоор нь л илэрхийлнэ биз. Өөрөө хүсвэл тэр сургаал энэ тэрийг нь өгч болох байх. Тэгээд өнөөдөр юу вэ бас Улсын Их Хурлын Тамгын газар нь 1 Байнгын хороонд чиглэл өгч байдаг. Тэрийг хэлэлц гээд. Үгүй ээ, сонгогчид нь л олон түмэн л тэр хүнд санал, хүсэлтээ гаргах ёстой шүү дээ. Ийм буруу юм яваад байна. Тэгээд энэ хуулийг сахиулах, ёс журам, дүрэм журмыг сахиулах чинь бид нарын л ажил шүү дээ.

Дам.Цогтбаатар: Би тэгвэл энэ зарчмын зөрүүтэй саналыг уншаад танилцуулчихъя. Эрдэнэболд гишүүний гаргаж байгаа.

Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтад олон улсын ур чадварын үзүүлэлт гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд. Энэ томъёоллоор дэмжье гэж санал хураалт явуулъя. 56,3 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн зарчмын зөрүүтэй санал. Бат-Эрдэнэ гишүүний гаргасан санал байгаа. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье. Өөрийнхөө саналыг танилцуулах уу.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Авлигагүй засаглал өнгөрсөн 2 жил гаруй хугацаанд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар ажиллаж байсан. Авлигатай тэмцэх газартай зөвшилцсөний үндсэн дээр Авлигатай тэмцэх газраас комиссарыг яаман дээр авч ажиллуулж байсан л даа. Ингээд ирэхээр яах вэ маш олон зүйл цэгцэрдэг юм байна лээ нэг талдаа. Нөгөө талдаа бид нар хөдөө орон нутагт ажиллаад явж байхад бол олон асуудлууд хөндөгдөж байсан. Авлигатай тэмцэх газар ч бид нар энийг олон удаа ярьж байсан. Тэгээд бид нар авлигагүй байя л гээд л яриад байдаг, яриад байдаг. Яг ний нуугүй хэлэхэд бодит үйлдэл бид нар юу хэлж байгаа вэ гэдгээ их сайн бодох ёстой юм шиг. Одоо тэгээд саяын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр үр дүнгийн хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт зорилтот түвшин дээр ч гэсэн авлигын үзүүлэлтийг 30 байраар ахиулна гээд 2028 он хүртэл зоочихсон байх жишээтэй байгаа. Тэгээд бид нар ил тод байдлын тухай их хөнддөг. Авлигаас ангид байх тухай их хөнддөг. Урьдчилан сэргийлэх ажлууд дээр тодорхой хэмжээний мөнгө төсвийг тавьж ажилладаг. Төрийн өндөр албан тушаалтнуудтай холбоотой асуудлуудыг л их хөнддөг. Гэтэл яг ний нуугүй хэлэхэд авлига бол дунд болон доод шатдаа асар их хэмжээтэй байх. Энэ чинь өөрөө маш өндөр хэмжээний нөлөөлөл үзүүлж байгаа гэж харж байгаа энэ авлигын асуудал дээр. Тэгэхээр Авлигатай тэмцэх газрыг бол 21 аймагт байгуулах нь бол зөв. Тийм учраас энэ засаглалтай авлигагүй засаглал дээр бол оруулж байгаа санал бол 21 аймагт Авлигатай тэмцэх газрыг байгуулж өгөөч. Энийг 2024-2028 онд бид нар заавал хийх ёстой. Ингээж байж бид нар

авлигаас ангид байх тухай, ингэж байж бид нар энэ салбарыг бид нар орон нутагт байгаа авлигачдын гар хөлийг таслах тухай, ингэж байж бид нар магадгүй парламентын гишүүнээр сонгогдчихоод тухайн тойргоосоо сонгогдсон гэдэг нэртэй, тухайн тойрогтоо өөрийн гар хөлүүдийг тавьж магадгүй жижиг дунд, боловсролын зээлийн сан, төрийн хэмжээнд явж байгаа томоохон зээлүүдээс авдаггүй мөртөө тэнд шимэгчилж амьдарч байгаа гар хөлөөрөө дамжуулж авлигын загалмайлсан эцэг болж байгаа зарим парламентын гишүүдтэй холбоотой асуудлуудыг ч бид нар шийдэж чадна. Энэ бол дээд, доод түвшинд шийдэх ёстой асуудлуудын нэг гэж харж байгаа. Тэгэхээр бол энийг та бүхэн дэмжиж өгөөч ээ гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

Дам.Цогтбаатар: Энэ юутай томъёолол нь би уншиж танилцуулъя. Ер нь агуулга нь бол Авлигатай тэмцэх газрын салбарыг 21 аймагт байгуулъя л гэж байгаа юм. Үүнтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Ингээд Алтангэрэл гишүүнээр тасаллаа. Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Ер нь ганц Авлигатай тэмцэх газар биш. Энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр Ардын намын мөрийн хөтөлбөрт ч орсон байсан. Манай намын мөрийн хөтөлбөрт ч орсон байсан одоо Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дотор орчихсон байж байгаа энэ улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх мөрдөх алба байгуулна гээд. Хэрвээ энэ Мөрдөх алба байгуулагдвал зөвхөн авлигын гэмт хэрэг биш л дээ. Хүн худалдаалах, мөнгө угаах, цахим гэмт хэргүүд байна. Мөн одоо энэ хар тамхи, галт зэвсэг гэх мэтчилэн энэ төрлийн гэмт хэргүүд ганцхан 1 аймгийн нутаг дэвсгэр дээр гардаг биш. Бас 1 улсын хил хязгаараар хумигддаг биш энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцдэг байгууллага байгуулагдах мэргэжилтнүүд нь

чадавхжих тухай юм яригдана. Тэгэхээр энэ нь өөрөө одоо энэ чиглэлийн гэмт хэрэг чинь ганцхан Улаанбаатарт бас гарахгүй. Тэгэхээр ганцхан Авлигатай тэмцэх газар биш энэ Мөрдөх албаны өөрийнх нь нэгж газруудыг орон нутагт байгуулах, тэнд нь үр дүнтэй ажиллуулах, дахиад нэг шинэ бүтэц үүсэх бай. Тэрүүгээр хамт шийдэгдэх байх л даа. Нөгөө бүтцийнхээ хувьд бол. Одоо бол бид нар зөвхөн ганц Авлигатай тэмцэх газар дээр одоо энэ мөрийн хөтөлбөр дотор орон нутаг дахь нэгжүүдийг дэлгэнэ, томсгоно гэдэг байдлаар бичигдэхээр энэ 2 концевц өөрөө ингээд хамтрах уу эсвэл зөрөх үү гэдэг ийм маргаан гарч магадгүй. Би бол тэгж харж байгаа. Энэ нөгөө мөрийн хөтөлбөр дотор байгаа бусад зүйлтэй уялдаа нь яаж яваа вэ гэдгээ анзаарсан уу, харсан уу гэж л асууж байгаа.

Дам.Цогтбаатар: Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Тэмүүжин гишүүнтэй гишүүний хэлдэг зөв л дөө. Энэ гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаа 4.2.1.8 дээр ус дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний чадавхыг дээшлүүлж энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх мөрдөх албыг байгуулан мэргэшүүлж, гадаад хамтын ажиллагааг сайжруулна гэсэн хэсгийг бол харсан. Тэгэхдээ энэ өөрөө улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх гэдэг утга агуулга давхар яваад байгаа юм. Тэгээд авлига бол дангаараа заавал зохион байгуулалттай гэмт хэрэгт ордоггүй. Орохгүй байх. Ганцаараа хийгээд явж байгаа хүмүүс ч байгаа. Тэгэхээр энэ дээр бол яг энэ 4.2.1.8 гэдэг дээр байгуулах саналыг л оруулж байгаа гэсэн үг.

Дам.Цогтбаатар: Алтангэрэл гишүүний микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Түрүүн хэлсэн Бат-Эрдэнэ гишүүний тавьж байгаа саналыг бол яг нөхцөл байдлыг бол бүрэн хүлээн

зөвшөөрч байгаа. Орон нутгийн иргэдэд хамгийн хүнд асуудал бол энэ орон нутгийн авлигын асуудал байгаа. Тэгэхдээ бид бол энэ асуудлынхаа мөн чанарыг олж харах ёстой. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Засгийн газар бол гэмт хэрэгтэй тэмцэх үүрэгтэй. Харамсалтай нь яг авлига, албан тушаалын гэмт хэрэг дээр Засгийн газар энэ үүргээ биелүүлж чадахгүй байна гэж бид нар харж байгаа. Өөрөөр хэлэх юм бол Авлигатай тэмцэх газар өөрөө бүтцийн хувьд мөрдөн шалгах, соён гэгээрүүлэх энэ зүйлийн хувьд бол нэлээн мэргэшиж, энэ чиглэлийнхээ үйл ажиллагааг нэлээн сайн явуулж байгаа нь үнэн.

Гэхдээ орон нутгийн түвшинд 21 аймагт бүр сумуудын түвшинд авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэхэд хүчин чадал нь хүрэхгүй байна гэдэг нь бас үнэн. Үүний шийдлийг Засгийн газар бидний зүгээс юу гэж харж байгаа вэ гэхээр орон нутаг дахь авлига, албан тушаалтай холбоотой энэ хэргийн харьяаллаа цагдаагийн байгууллагаар шалгуулаач гэдэг л асуудал тавьж байгаа юм орон нутагт. Өнөөдөр иргэн хүнд хамгийн ойрхон нэгж бол цагдаагийн байгууллага байдаг. Өнөөдөр аймгийн Цагдаагийн газар зарим сум дахь цагдаагийн хэлтэс бол авлига, албан тушаалтай холбоотой, албан тушаалтнуудтай холбоотой зүйл яриад очихоор шалгах эрх мэдэл байдаггүй. Ингээд аймгуудын дунд байгаа байцаагчид ханддаг. Ингээд замхардаг байдал байгаад байгаа. Энэ байдал нь олон жил үргэлжилсний улмаас цагдаагийн байгууллагын яг энэ авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх энэ мэргэшил, ур чадварын байдал, хүчин чадал, боловсон хүчний хувьд нэлээн сулраад байгаа юм. Тэгэхээр бид нар энэ дээр арга зүйн хувьд, илрүүлэх арга зүйн хувьд мэргэжлийн арга зүйн хувьд Авлигатай тэмцэх газраар газрын тэр чиг үүргийг удирдлага болгоод, арга зүйн хувьд туслалцаа аваад, яг зохион байгуулалт үйл ажиллагааныхаа

бүтцээр цагдаагийн байгууллага энэ төрлийн гэмт хэрэгтэй 21 аймагтай тэмцье л гэж байгаа. Ерөөсөө концепц нь энэ. Монголын цагдаа Улаанбаатар хотод энэ албан тушаалтнуудтай холбоотой тэр томоохон хэргүүд дээр Авлигатай тэмцэх газар өөрийнхөө эрх хэмжээний хүрээнд яваг. Орон нутагт нь цагдаагийн байгууллагаа энэ чиглэлээр бэхжүүлбэ. Одоо ганцхан залилан, өмчийн эсрэг хэдхэн гэмт хэрэг шалгаж байгаа орон нутаг дахь энэ эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх нэгжээ энэ чиглэлээр чадавхжуулъя. Дээрээс нь Цагдаагийн байгууллага дээр байгаа энэ Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх нэгжийг яг энэ чиглэл рүү нь бас Авлигатай тэмцэх газартай уялдаа холбоотойгоор улам мэргэшуулъя. Гаднаас бол сургалтад хамруулъя, ур чадварыг нь дээшлүүлбэ гэж байгаа. Энэ чиглэлээр өнөөдөр ЭХХШТХ-аар харьяаллыг прокурорын байгууллага тогтоож болж байгаа. Мааш олон төрлийн нийгэмд анхаарал татсан хэргүүд дээр Цагдаагийн байгууллага, Авлигатай тэмцэх газар хамтарсан ажлын хэсэг гарч шалгаж байгаа. Тэгэхдээ орон нутгийн түвшинд бол яг энэ прокуророос хамааралтайгаар биш Эрүүгийн процессын хуульдаа өөрчлөлт оруулах замаар энэ асуудлыг шийдье гэсэн саналтай байгаа шүү.

Дам.Цогтбаатар: Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье. 1 минут.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Алтангэрэл сайдын хэлдэг үнэн л дээ. Гэхдээ өнгөрсөн үе үеийн Засгийн газруудын үед яг л энийг л яриад л яваад л ирсэн байхгүй юу. Тэгээд хийхгүй л байна л даа. Нөгөө талдаа цагдаагийн байгууллага дээр очсон гомдлыг шууд Авлигатай тэмцэх газар луу шилжүүлж байгаа юм. Энд хийдэл явж байгаа юм. Манай харьяаллын бус, бид нар мэдэхгүй байна, чиг үүргийн дагуу бус. Ингэхээр дунд нь хэн завшаад байна гэхээр авлигачид завшаад байгаа байхгүй юу. Авлигачид зави завшаад байна. Гэмт

хэргээс улбаатай учирсан хохирлын хэмжээ түрүүн хэлсэн зөвхөн 2021-2024 оны хоорондох энэ 2 жил гаруй хугацаанд буцаан барагдуулсан нь шүү зөвхөн 2,7 их наяд. 2,7 их наяд. Тэгэхээр бид нар энэ авлигатай тэмцье, авлигагүй засаглалыг бий болгоё л гэж байгаа бол энийг дэмжиж өгөөч гэж хүсэж байгаа юм.

Дам.Цогтбаатар: Би энэ дээр өөрийнхөө саналыг хэлчихмээр байна. Яг ингээж хурлын үеэр яг ингээд гаргаж байгаа. Тэгээд үүний санхүүгийн эх үүсвэрийг үнэндээ тооцохгүйгээр энийг гаргах маш хэцүү шүү. Яагаад гэвэл бүхэл бүтэн 1 байгууллагын 21 аймагт би Авлигатай тэмцэх газрын угаасаа ресдикиц буюу хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах орон зай чинь тэр 21 аймагт чинь үйл ажиллагаа нь явж байгаа. Байхгүй байгаа биш. Одоо жишээлбэл та энийг ингээд хийхгүй байна гээд байгаа чинь та яг сайд байж байгаад одоо ороод ирчихсэн. Энэ чинь яг өөрийнхөө Засгийн газрыг та чинь юу ч хийхгүй байгаад байсан юм шиг яриад эхэлж байна шүү дээ. Энэ төрийн ажил чинь залгамж чанартай бөгөөд энэ ажиллагаанууд чинь тасралтгүй л явж байсан байлгүй дээ. Авлигатай тэнцээгүй байж байснаа гэнэт Алтангэрэл сайд орж ирээд тэмцэх гээд байгаа юм шиг яриа яригдаж байгаа бол энэ чинь тийм биш шүү дээ. Ил тод бүгдээрээ яриад л хэн ч хариуцлагаа хүлээгээд л, хэнтэй нь ч хариуцлага тооцоод л явж байсан шүү дээ. Тэгэхээр энэ дээр бол би энэ 21 аймаг дээр шууд гэнэт энэ сангийн чинь төсөв, энэ хөтөлбөрөө боловсруулж орж ирэх гэж бүгдээрээ хоорондоо маш их уялдчихсан юм бариад ороод ирж байхад, энэ 21 аймагт 1 зөвхөн байгууллагын юуг ингээд нэмнэ гэдэг чинь бол төсвийн гарах үр дагаврынхаа хувьд бол маш хүнд байж магадгүй л гэж бодож байна л даа. Бат-Эрдэнэ гишүүн ээ. Тэгэхээр энэ бол тийм амар асуудал биш л юм шиг надад санагдаж байна. Тэгэхдээ нэгэнт гишүүн саналаа гаргаж байгаа юм чинь үүгээр санал хураах нь зөв байх гэж би бодож байна.

Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралт доор дурдсан агуулгатай 4.2.1.8 дахь дэд заалт нэмэх:

“4.2.1.8.Авлигатай тэмцэх газрын салбарыг 21 аймагт байгуулах” гэсэн томъёоллоор дэмжье гэж санал хураалт явуулъя аа. 18,8 хувиар санал дэмжигдсэнгүй.

Ингээд “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг танилцуулна.

11.53 цаг.

Ингээд дараагийн 2 дугаар асуудалдаа оръё.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024 оны 8 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн. Одоо бол 2 дахь хэлэлцүүлэг явж байна. Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд бид бол хэлэлцүүлснийхээ дараа хүргүүлнэ.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг эхлэе.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Хууль зүй, дотоод хэргийн сайд Алтангэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Эрдэнэбулган, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч Базаргүр. Хүний

эрхийн Үндэсний Комиссоос. Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Сүнжид, Хүний эрхийн Үндэсний Комиссын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Ёндонжамц. Улсын дээд шүүхээс. Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга Заяадэлгэр, Шүүхийн сургалт судалгаа мэдээллийн хүрээлэнгийн захирал Эрдэнэчимэг, Улсын дээд шүүхийн ерөнхий нягтлан бодогч Эрдэнэцэцэг. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Энхбилэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Эрдэнэтулга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Наранбилэг. Шүүхийн сахилгын хорооноос. Шүүхийн сахилгын хорооны дарга Давхарбаяр, Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны дарга Мөнхзориг. Авлигатай тэмцэх газар. Авлигатай тэмцэх газрын Дэд дарга Азжаргал, Авлигатай тэмцэх газрын Ерөнхий нягтлан бодогч Цэрмаа. Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга Гансэлэм, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссоос. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн дарга Төгөлдөр, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Ажлын албаны дарга Очсүрэн, Цагдаагийн ерөнхий газраас. Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Батзориг, Хил хамгаалах газраас. Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Лхагвасүрэн, Хил хамгаалах ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, хурандаа Чойжилсүрэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд хорих ял эдлүүлэх албаны дарга хурандаа Намсаманд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газрын дарга, хурандаа Нямгомбо. Улсын бүртгэлийн ерөнхий газар. Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Дэлгэрсайхан. Хууль зүйн

туслалцааны төв. Хууль зүйн туслалцааны төвийн захирал Уянга гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг оролцож байна. Энийг нэмээд унших уу.

Ахиад нэмээд бас ажлын хэсгийн гишүүд байж байна. Сангийн сайд Жавхлан, Монгол Улсын ерөнхий аудитор Загджав, Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч Самбууням, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Сонор, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Энхболд, Аудитын менежер Мөнхцацрал, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер Энхтуяа, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн Ариунболор, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч Отгонжаргал, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн мэргэжилтэн Гэлэгжунай, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн Төгөлдөр, Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн Энхжин гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг оролцож байна. Ингээд ажлын хэсгийг танилцуулж дууслаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайдын микрофоныг өгье. Хэддүгээр микрофон байна. Мөн мөн Жавхлан сайдын микрофоныг өгье. №

Б.Жавхлан: Бүгдээрээ сайн байцгаана уу. 2 Байнгын хороо дээрээс зэрэг дуудагдаад давхацчихлаа шүү.

Уучлаарай. Тэгээд ийшээ эхлээд ороод ирлээ.

Байнгын хороон дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай болон дагалдах хууль тогтоомжийн төслүүдийг 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж байна.

“Хурдтай хөгжлийн төлөөх зориг” хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн 2024 оны төсвийн тодотголын төслийг боловсрууллаа. Энэхүү тодотголоор улс орны өмнө тулгарч буй сорилт, тулгамдаж буй асуудлуудыг шийдэх эдийн засгийн өсөлтийг 5-6 ба түүнээс дээш хувьд, инфляцыг 1 оронтой тоонд, зээлжих зэрэглэлийг тогтвортой түвшинд хадгалах нөхцөлийг бүрдүүлэх хурдтай, зоригтой, эрс шийдвэрүүдийг гаргаж, шинэ 30 жилийн хөгжлийн гарааг эхлүүлэх, хөгжлийн төслүүдийг бодитой хэрэгжүүлж эхлэх үндсэн суурийг тавьж байна.

Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй, хурдтай шийдвэрлэхэд чиглэсэн дараах багц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр танилцуулж байна. Үүнд:

1 дүгээрт бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд нийслэлийн их, бага тойруу дахь төрийн эрх мэдлийн хэт төвлөрлийг задалж, өөдөө тэмүүлэх Монгол буюу Гөү Монголиа, ган татлагат гүүр, Хөшигийн хөндийн туннел, Хөшигийн хөндийд төр захиргааны нэгдсэн байр, аймгийн төв, сумд болон хилийн боомтуудыг холбох

шинэ сэргэлтийн 5 тойрог авто замын төсөл, Шинэ Хархорум төсөл, Шинэ 100 мод хот, Туулын хурдны зам зэрэг төслүүдийг Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг хангах ТЭЗҮ, зураг төсвийн санхүүжилтийг төсвийн тодотголд тусгалаа.

2 дугаарт гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж буй бүтцийн хөгжил шинэ сэргэлтийн бодлогын дэд бүтэц, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний ашиглалтыг 984 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, төсвийн тодотголд тусгав.

3 дугаарт 30 жил хүлээгдсэн эрчим хүчний салбарын үнэ тарифын реформыг цаг алдалгүй эхлүүлж, зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлж, либералчлах, хувийн хэвшилд тус салбарт хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлж, салбарын санхүү, эдийн засгийн тогтвортой суурийг тавихад дэмжлэг үзүүлэх шилжилтийн үеийн зардлыг тусгалаа.

4 дүгээрт Монгол Улсын Их Хурлын 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай болон холбогдох бусад хууль тогтоолын төслүүд батлагдсан. Дээрх хуулиуд батлагдсанаар зарим чиг үүрэг төсвийн ерөнхийлөн захирагч хооронд шилжсэн. Шинээр төсвийн хөрөнгө ерөнхийлөн захирагч бий болсон, мөн зарим яам, агентлагийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4-д заасны дагуу Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд төсвийн зарцуулалт, зохицуулалт хийлээ.

5 дугаарт эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлэх орлогыг одоо ба ирээдүй иргэдэд тэгш хүртээх хуваарилах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас энэ оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай

хуулийг баталж, Ирээдүй өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн 3 төрөлжсөн сангаас бүрдэх тогтолцоог бий болгосон билээ.

Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2024 оны төсвийн жилд эх үүсвэр төвлөрүүлэх, хуримтлал үүсгэх болон эдгээртэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулах зорилгоор Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Танилцуулга хийсэн Жавхлан сайдад баярлалаа. Одоо Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна. Ажлын хэсгийн 6 дугаар микрофоныг өгье.

Д.Загджав: Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Та бүхэндээ энэ өдрийн мэнд дэвшүүлье.

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон нь төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх нөхцөлийг бүрдүүлж, улс төрийн 3 намаас “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” гэрээг байгуулж, эдийн засгийн суурийг тэлэх эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх зорилт дэвшүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1, 34.1.4-д

заасан төсөвт тодотгол хийх шаардлагыг бий болгосон байна.

Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэж байгаа юм.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2024 оны төсвийн тодотголд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөвт нийт 14,3 тэрбум төгрөгийн өөрчлөлт орсон байна. Анхаарал тавьсанд баярлалаа. Танилцуулж дууслаа.

Дам.Цогтбаатар: Загджав даргад баярлалаа. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Хууль санаачлагчаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух гишүүн байна уу. Нэрсээ өгнө үү. Ганбат гишүүнээр тасаллаа. Заяабал гишүүний микрофоныг өгье.

Б.Заяабал: Байнгын хорооныхоо гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр Монгол Улсын жилийн төсвийг боловсруулахдаа энэ хөтөлбөрт суурилсан боловсруулалтыг хийдэг ийм тогтолцоонд 2011 оноос хойш илжжсэн. Энэ хөтөлбөрийг боловсруулсан,

хөтөлбөрийн дагуу хүрэх үр дүн чанарын болон тоон үзүүлэлтүүд гэж гаргадаг 1 дүгээр хавсралтаар. Энэ дээр дурдагдсан хэд хэдэн зүйлүүд байгаа юм. Энийг яг хэрэгжүүлэх үүднээс 2024 оны төсвийн тодотголууд бас орж ирж байгаа гэж ингэж ойлгож байгаа. Ингээд төсвийн ерөнхийлөн захирагчдаас хэд хэдэн асуултууд асууя. Энэ чинь цагтаа явж байгаа юу.

1 дүгээрт нь Улсын дээд шүүхээс асуумаар байна. Энэ шударга шуурхай шүүхээр үйлчлүүлэх иргэдийн эрхийг хангах гэдэг асуудал, үзүүлэлт 84 хувь байсныг 93 хувь болгоно гэж заасан байна. Энэ шударга шүүхээр хангагдаж байгаа нь одоо 84 хувь байсан гэсэн үг үү. Одоо ингээд шударга шүүхээр 93 хувь нь л хангагдана. 7 хувь нь хангагдахгүй гэсэн үг үү.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс асуумаар байна. Хэрэг маргааныг хуулийн хугацаанд шийдвэрлэнэ гэдэг дээр 79 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэнэ гэж ингэж заасан байна. Үүнтэй холбоотой тодорхой мэдээллүүдийг өгмөөр байна.

Шүүхийн сахилгын хорооноос асуумаар байна. Нийт хэчнээн өргөдөл, гомдол ирдэг болоод ирж байгаа гомдлын 97 хувийг шийднэ гэж ингэж оруулж ирсэн юм бэ.

Улсын ерөнхий прокуророос бас асуумаар байна. Зөрчлийн тухай хууль, Зөрчлийн хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавина гээд өнгөрсөн суурь үзүүлэлт нь 2 сая 698 мянгыг хяналт тавина гэсэн бол энэ онд 2 сая 650 гэж ингэж оруулж ирсэн байна. Энэ ямар учиртай юм бэ.

Авлигатай тэмцэх газраас бас асуумаар байна. Албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой асуудлыг шийдэх үүднээс энэ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулж явж ирсэн. Миний хувьд авлигатай тэмцэхийн тулд

төрийн үйл ажиллагааг цахим болгох ёстой гэж ингэж боддог. Энэ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр дээр нийт хэчнээн байгууллагын үйл ажиллагааг цахим болгох ийм төсөл, хөтөлбөр танай энэ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт чинь бас орсон юм бэ. Явц нь хэр байгаа юм бэ. Ямар, ямар байгууллагууд дээр асуудлууд байна гэдэг ийм асуултыг бас би тавимаар байна.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссоос бас асуумаар байна. 8,3 тэрбум төгрөгийн төсөв тавигдсан байна. Нийтдээ хэчнээн хүн улс төрийн гэмт хэрэгт хэлмэгдсэнээс хэдийг нь цагаатгаад, хэд нь үлдээд ингээд өнөөдөр энэ байгууллага үргэлжлээд яваад байна вэ гэдэг бас ийм асуултыг бас тавимаар байна.

Хууль зүйн сайдаас бас хэд хэдэн асуултууд байна. Нийтдээ 1,4 их наядын төсөвтэй. Хэрэг бүртгэл, хянан шийдвэрлэх ажиллагаанаас ингээд аваад үзэхэд эрэн сурвалжлагдаж байгаа хэрэг илрүүлэлт гэхэд 50 хувьтай байсан байна. Суурь үзүүлэлт нь. Одоо 65 хувь болгоно гэсэн байна. Үндсэндээ 2 гэмт хэргийн 1 илэрдэг гэсэн ийм тоон мэдээллүүд гарч ирж байна.

Гадаадын иргэн харьяалалгүй иргэдтэй холбоотой.../минут дуусав/

Дам.Цогтбаатар: Гүйцээгээд. 1 минут өгье.

Б.Заяабал: Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачидтай холбоотой асуудлууд байдаг. Үүний үйл ажиллагааг 1 дүгээрт визний олгох асуудлыг 7900 байсныг 15 мянга болгоно гээд заачихсан байна. Монгол хэзээ энэ цахим виз олгох ийм тогтолцоо руу орох гэж байгаа вэ.

2 дугаарт нь энэ Монгол Улсад энэ гаднын иргэд хөдөлмөр эрхэлдэг. Одоо Вьетнам авто засвар гээд байдаг. Татварын албыг удирдаж ажиллаж

байхдаа энэ дээр тодорхой шалгалтуудыг явуулж байсан. Мааш их олон ийм визний зөрчилтэй иргэд Монголд хөдөлмөр эрхэлж байгаа. Энэ дээр ямар хяналтууд тавьж байна.

Төрийн архивын үйл ажиллагааг баахан сайжруулна гээд л оруулаад ирчихсэн байна. Энэ архивынхаа үйл ажиллагааг цахим болгох ажил чинь хэр зэрэг явж байгаа юм бэ. Ер нь бүх юм төрийн үйл ажиллагааг цахим болгоё, цомхотгоё гэдэг ийм зүйлүүдийг бид нар олон удаа ярьж байна. Өнөөдрийн энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрүүд дээр ч байна. Бодлого дээр ч нэлээдгүй байгаа. Тэгэхээр энэ одоо цахим болгох ажлууд чинь хэр зэрэг явж байгаа юм бэ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил бол хамгийн чухал ажил. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил. Хэчнээн камеруудын үйл ажиллагааг нэвтрүүлсэн, хэчнээн тэрбум төгрөг зарцуулсан гэдэг билээ. Зөндөө юм ярьдаг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлд бас зөвлөлийн гишүүнээр ажиллаж байсан. Тэгээд зам дагуу баахан формтой хүүхэд цүнх бариад явж байгаа. Нэг гарц дээр нэг баахан зураг тавигдсан байдаг. Баахан камерууд тавьсан гээд тэгдэг. Тэрний үр дүнд энэ гэмт хэрэг чинь хэр зэрэг буурч байгаа юм бэ.

Одоо орчин үеийн залуучууд ялангуяа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээтэй холбоотой асуудлууд нэлээдгүй ихэслээ. Мэдэгдэхгүй шоколад, боов боорцог, юу юунд ч гэнэ вэ энэ хар тамхины юмнууд бас хольцтой юмнууд орж ирдэг гээд байна. Үүнтэй холбоотой соён гэгээрүүлэх ажил хэр зэрэг хийгддэг вэ. Үүнтэй холбоотой ажлын үр дүн хэр зэрэг байна вэ гэдэг эдгээр асуултуудад бас хариулт авъя. Баярлалаа.

Дам.Цогтбаатар: Ажлын хэсгээс хариулъя. Эхлээд Хууль зүйн сайд

хариулах уу. Сангийн сайд хариулж байна. Энэ Сангийн сайд гэнэ. Хууль зүйн сайд хариулж байна.

О.Алтангэрэл: Бүх хүнээс асуусан. Тэгээд хурдан хурдан хариулаад явчихъя. Энэ гадаадын иргэн харьяат угаасаа визээ Монгол Улс цахимаар олгож байгаа. Тэгээд одоо хэрвээ Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх газар дээр очих юм бол зааланд хүн байхгүй. Гаднаас бүгд визээ цахимаар олгодог болчихсон. Цахимаар олгох сайн талтай байна. Бас ажлыг хөнгөвчилж байна. Шударга болгож байна. Авлигыг устгаж байна. Дахиад бид нар бас энэ өөр сөрөг үр дагавруудтай тулгарч эхэлсэн. Гаднаас манай улсыг Америкийн Нэгдсэн Улс мэт бодож ирж харладаг Гани, Того энэ тэр гэж улсын иргэд цахимаар визээ авч орж ирээд шууд алга болоод харлаад байгаа ийм асуудал үүссэн. Бас өндөр хөгжилтэй орнуудад тулгардаг зовлон бидэнд бас тулгарч эхэлсэн. Тэгээд энэ бол цахимжчихсан байгаа шүү.

Төрийн архив цахим болгоно гээд энэ бол байнга үеийн үед тавигдаад явдаг асуудал. Аль 10 гаруй жилийн өмнө л энэ цаасан суурьтай баримтыг цахим болгоно гээд явж байсан юм. Нэлээн олон ажил бас нугалагдаад явсан юм байна лээ. Яг би энэ төрийн архивыг цахим болгохтой холбоотой энэ нөгөө камер тавиад цагдаагийн байгууллага өнгөрсөн хугацаанд бол нэлээн олон асуудал хийсэн юм байна лээ. Жишээлбэл ногоон бүс болгоно гээд Чингэлтэй дүүргийг тэр чигт нь иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн заалтыг аж ахуйн нэгж байгууллагуудаар мөрдүүлэх замаар ногоон бүс болгочихсон. Одоо дахиад Улаанбаатар хотыг тэр чигт нь камержуулсан ногоон бүс болгоно гээд явж байгаа юм байна лээ. Тэгээд үүнтэй холбоотой статистик мэдээллийг би тодруулж эргэж танд хэлье. Цээжээр хэлж бол чадахгүй байна. Тэгэхдээ мааш их үр дүн гарсан. Цаашидаа

Улаанбаатар хотыг тэр чигт нь бас яг энэ иргэд, аж ахуйн нэгжтэйгээ хамтраад ногоон бүс болгоно гэдэг асуудал тавиад явж байгаа.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил байх ёстой. Урьдчилан сэргийлэх ажлыг цагдаагийн байгууллага үйл ажиллагааныхаа тэргүүлэх чиглэл болгоно гэсэн ийм байр суурь баримтлаад явж байгаа.

Мансууруулах бодистой холбоотой соён гэгээрүүлэх ажил бол хийгдэнэ. Ер нь ганцхан мансууруулах бодис гэхгүй энэ согтууруулах бодистой холбоотой ер нь бол архи, согтууруулах ундаас бий болсон сан байдаг. Энэ сангийн үйл ажиллагаа бол одоохондоо зарцуулалтгүй явж байгаа. Энэ сангийн үйл ажиллагааг аль болохоор үр дүнтэй явуулах, гишүүн таны саналаар энэ хүүхэд, залуучуудыг донтолтоос, тэр дундаа мансууруулах бодисын донтолтоос сэргийлэх арга хэмжээ явуулна гэсэн төлөвлөгөө байна. Тэгэхдээ 1 зүйлийг сануулахад бас энэ маш болгоомжтой хандахгүй бол нэн ялангуяа энэ мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх ажиллагаа дээр тактикийг их болгоомжтой хандахгүй бол нийгэмд эргээд энэ төрлийн аюулыг сурталчлах нэг хэрэгсэл болдог шүү гэж олон мэргэжлийн байгууллага анхааруулаад байгаа гэдгийг хэлье.

Хэрэг илрүүлэлтийн хувьтай холбоотой статистик. Түрүүний тэр камержуулалттай холбоотой статистикийг танд эргэж хэлье.

Дам.Цогтбаатар: Өөр ажлын хэсгээс. 9 дүгээр микрофон байх шиг байна.

С.Заяадэлгэр: Байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Улсын Дээд шүүхийн Тамгын

газрын дарга Заяадэлгэр байна. Заяабал гишүүний асуултад хариулъя.

Улсын Дээд шүүхийн иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрхийн хэрэгжилтийн хүрээнд Улсын Дээд шүүхийн зорилтот түвшин одоо суурь түвшин бол 2021, 2022 оны үед шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүйгээс 2 мянгаад хэрэг хуримтлагдсантай холбоотой суурь түвшин 84 хувьтай байсан. Үүнийг 93 хувиар өсгөх зорилт тавин ажилласнаар 2023 оны хугацаандаа шийдвэрлэсэн хэргийн түвшин 97 хувь болж өссөн байгаа. Тэгэхээр иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрхийн хүрээнд хугацаандаа шийдвэрлэсэн хэргийн хуваарь зорилтот түвшинээ төлөвлөж явдаг байгаа. Шүүхийн хувьд.

Дам.Цогтбаатар: Шүүхийн ерөнхий зөвлөл 5 дугаар микрофон. Тэгээд дараа нь Хүний эрхийн комисс 4 дүгээр микрофон.

Л.Энхбилэг: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Заяабал гишүүний асуултад хариулъя. Шүүхийн ерөнхий зөвлөл Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бол 3 саналыг тусгасан байгаа.

1 дүгээр санал бол шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх. Үүнтэйгээ холбогдуулаад бид нар 2024 оны төсөвт бол 14 тэрбум төгрөгийг санхүүжилт авсан. Үүнтэйгээ цахимжилтынхаа ажлыг эхэлж байгаа. Ерөнхийдөө шүүн таслах ажиллагаа өөрөө цахимжих юм бол шүүхэд итгэх иргэдийн итгэл нэмэгдэнэ гэсэн ийм төсөөлөлтэй ажлаа эхлээд явж байна. 2024 оны 4 сарын 25-ны Улсын Их Хурлын 33 дугаар тогтоолоор бид дунд хугацааны хөгжлийн бодлогоо баталсан. Үүндээ бол бас цахимжилттай холбоотой, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, тэр төсөв мөнгөтэй, хариуцах эзэнтэй, төлөвлөгөөтэй ингээд ажиллаж байна.

2 дахь асуудал. Хуулийн хугацаанд хэргийг шийдвэрлэх гэдэг бол суурь түвшин бага байсан нь бол хүний нөөц, ажиллах орчин, төсөв мөнгөтэй холбоотой байсан.

Дам.Цогтбаатар: 4 дүгээр микрофон өгье.

Д.Сүнжид: Хууль зүйн байнгын хорооны дарга, гишүүдэд энэ өдрийн амгаланг айлтгая. Заяабал гишүүн Хүний эрхийн Үндэсний Комиссоос бол тухайлсан асуулт асуугаагүй. Төсвийн тодотгол дээр Хүний эрхийн Үндэсний Комисс 445 сая төгрөг зөвхөн цалин. Тэр нь Засгийн газрын 2018 оны тогтоол дээр орон нутгийн албан хаагчдад нэмэгдэл өгөх гээд 2024 онд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор ийм зардлыг тусгаж оруулсан болно.

Ер нь нийт төсөв бол 5,1 үүнээс яг 50 хувь нь албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэлд зарцуулагддаг ийм байна.

Дам.Цогтбаатар: Ер нь ажлын хэсгээс нээрээ хариулахдаа албан тушаал, нэрээ хэлцгээгээрэй. Тийм бас шинэ парламент байгаа болохоор тал талдаа бие биеийгээ таньж явах үүднээс хэлээд явах нь зөв байх. Цагаатгах комиссын дарга 3 дугаар микрофон байх шиг байна.

Г.Төгөлдөр: Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн дарга Төгөлдөр. Тэгэхээр асуултад хариулъя.

2024 оны оны өнөөдрийн байдлаар 31651 иргэн цагаадсан байгаа. Цагаатгагдсан иргэдийн хэдэн хүн хэлмэгдсэн бэ гэсэн энэ асуултад бол яах вэ, эрдэмтдийн судалгаагаар бол 100 орчим мянга гэдэг боловч өнөөдөр бичиг баримт нь олдож шүүхээр цагаадсан 31651 иргэн, Тагнуулын ерөнхий газар дээр 350 хэрэг дээр ажиллагаа явагдаж байна. Он гарсаар нийт 12 иргэн шинээр

цагаадсан. Төсвийн хувьд 2023 онд 8 тэрбум төгрөгийн төсөв авсан. Үүнээс 7 тэрбум 463 нь нөхөн олговорт олгогдсон байж байгаа. 2025 оны төсөөллөөр бол нөхөн олговорт нийт 350 орчим сая төгрөгийг төлөвлөж байгаа. Энэ нь бол шүүхээс цагаадсан иргэдийг судалгааны үндсэн дээр энэ явагддаг. Хууль.../минут дуусав/

Дам.Цогтбаатар: Микрофон гүйцээж өгье. 3 дугаар микрофон.

Г.Төгөлдөр: Хуулийн хугацаа сунгасантай холбогдуулаад нийт салбар комиссуудтай нийлээд өнөөдөр 960 өргөдлийг хүлээж аваад явагдаж байна. Энэ 960 хүлээн авсан өргөдлөөс шүүхээр цагаатгах эсэх нь бол өнөөдрийн байдлаар тодорхойгүй байгаа. Хариулж дууслаа.

Дам.Цогтбаатар: Хил хамгаалах газрын дарга Лхагвасүрэн. Лхагвасүрэн генерал наашаа урагшаа орох уу. 8 дугаар микрофон.

Х.Лхагвасүрэн: Засгийн газрын дарга, хилийн цэргийн командлагч, хошууч генерал Лхагвасүрэн та бүхний амрыг эрье. Манайхаас тодруулж асуулт асуугаагүй учраас би яг асуултад хариулахаа мэдэхгүй байна. Манайхтай холбогдолтой асуудал гараагүй байгаа.

Дам.Цогтбаатар: Авлигатай тэмцэх газар. Урагшаа суучих. 1 дүгээр микрофон.

Г.Азжаргал: Авлигатай тэмцэх газрын дэд дарга Азжаргал байна. Заяабал гишүүний асуусан асуултад хариулъя. Авлигатай тэмцэх газрын Үндэсний хөтөлбөрийг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр батлуулж, 2023-2030 он хүртэл хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргасан. Үүний 10 том зорилт байгаа. 10 том зорилтын 1 нь бол таны хэлж байгаа цахим шилжилт, ил тод байдлыг хангах ийм үндсэн зорилготой. Авлигатай тэмцэх газраас болон яг

үндэсний хөтөлбөрийг шинэ хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдсан Улсын Их Хурлаас. Засгийн газрын Хэрэг эрхлэх дээр даргалаад ажлын хэсэг байгуулагдаад ингээд явж байгаа.

Дам.Цогтбаатар: Прокурор. 1 дүгээр микрофон өгье.

С.Гансэлэм: Та бүхний өдрийн мэндийг эр хүргэе. Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга Гансалан байна. Заяабал гишүүний асуултад хариулъя. Прокурорын байгууллага Зөрчлийн болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахаас гадна, зөрчлийн статистик тоон мэдээллийг прокурорын байгууллага улсын хэмжээнд хариуцаж ажилладаг. Сая асуултад дурдсан 2,6 гомдлын тоо гээд. Энэ маань сүүлийн 3 жилийн дундчилсан тоо байгаа. Зөрчлийн тоо бол жил болгон нэмэгдээд, сүүлийн жилийн байдлаар аваад үзэх юм бол 3,2 сая орчим ийм зөрчилд хяналт тавиад ажиллаж байгаа. Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн системийг улсын хэмжээнд ашиглалтад оруулах талаар Хууль зүй яам, Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтраад энэ төслийн хэмжээнд хэрэгжээд ер нь энэ ондоо ашиглалтад орно гэсэн ийм төлөвлөгөөтэй ажиллаж байна. Улсын хэмжээнд 65 чиг үүргийн 13 мянга орчим эрх бүхий албан тушаалтнуудын зөрчлийн.../минут дуусав/

Дам.Цогтбаатар: Дахиад нэмж тодруулж, гүйцээд хариулчих уу. Болчихсон уу. Болчихсон байна. Заяабал гишүүн ээ, та нэмж асуух эрхээ түрүүн нэгтгээд авчихсан шүү дээ. Бүгдийг нь өгчихсөн байхгүй юу. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье. Гишүүд ээ, хаанаас асууж байгаагаа хэлээрэй. Энэ чинь ийм олон байгууллага сууж байгаа болохоор хаанаас асууж байгаагаа хэлээрэй.

Ц.Сандаг-Очир: Сангийн яамнаас асууя. Төсвийн тодотгол хийж байгаа. Тэгээд манай энэ Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын зарим байгууллагуудын урсгал зардал нэмэгдэхээр орж ирсэн байна. Тэгээд цалингийн нэмэгдэл юмнууд бол жишээ нь 1 сарын 1-ээс хийгдсэн юм шүү дээ. Жишээ нь Хүний эрхийн Үндэсний Комиссын орон нутгийн албан хаагчдын 20 хувийн нэмэгдэл нэмэгдээгүй. Өнөөдрийг хүртэл одоо 8 сар болж байхад цалингийн нэмэгдлээ авч чадаагүй яваа гэсэн үг үү. Яагаад ингээд зарим байгууллагуудын нэмэгдлийг дутуу тооцож ингэж яваад байдаг юм. Дийлэнх болох байгууллагууд нь бол ямар нэг урсгал зардал нэмэгдээгүй байна шүү дээ. Тэгээд төсвийн жилийн дундуур ингээд нэг тодотгол хийх нэрийн доор хагас дутуу бодсон юмнуудаа ингээд тодотголоор далимдуулж оруулж ирдэг энэ байдлаа хэзээ одоо таслан зогсох юм.

Шүүхийн ерөнхий зөвлөл дээр бас урсгал зардлын асуудал байна. Хүний эрхийн Үндэсний Комисс дээр урсгал зардлын асуудал байна. Тэгээд бусад байгууллагууд нь бол харьцангуй гайгүй байна шүү дээ. Энэ яасан юм. Яагаад дутуу бодсоноос ингэж төсвийн тодотгол заавал урсгал санхүүжилтийг нэмж оруулж ирж байгаа юм уу гэдгийг асууя. 1-д.

2-т энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын орон нутгийн албан хаагчдын энэ ер нь ямар албан хаагчид байдаг юм. Орон нутагт, аймагт. Би лав манай алслагдсан 3 дүүрэгт Хүний эрхийн Үндэсний Комиссын орон нутгийн албан хаагч гэж байдгийг мэдэхгүй юм байна. Энэ юу хийдэг хүмүүс байдаг юм. Тэгээд ямар цалин хангамж авдаг юм. Төрийн албаны аль ангилалд хамаарагддаг юм. ТЗ байдаг юм уу. ТТ байдаг юм уу. ТҮ байдаг юм уу. Цалин хангамж нь ямар байдаг юм. Ямар шалгуур хангасан юм. Энэ хүмүүс юу хийдэг юм яг. Хүний эрхийн асуудал зөндөө л зөрчил юмнууд гарч байдаг. Орон нутгаас хүний эрхийн

зөрчлийн асуудлаар ярьж байгаа хүнийг би 1 удаа сонсоогүй юм байна. Хүний эрхийн асуудал ярихаар л энэ хэдэн манай Хүний эрхийн Үндэсний Комиссын хэдэн гишүүд Сүнжид даргатай хэд л байцаагддаг юм шүү дээ. Гэтэл орон нутагт цалин нэмэх болохоор ингээд баахан хүмүүсийн цалингийн нэмэгдэл яригдаад байдаг. Тэгээд хэрвээ ажил хийдэггүй юм бол энэ олон байгаа, байхгүй хүмүүсийн асуудлыг цаашидаа ярих шаардлага гарч байна шүү дээ.

3-д. Би Хууль зүйн сайдаас асууя. Би зүгээр энэ төсвийн тодотголтой хамаагүй. Цаашидаа та ажлаа аваад удаагүй байгаа. Танай салбарын манай Байнгын хорооны эрхлэх асуудлын байгууллагуудын албан хаагчдын нийгмийн асуудал. Та 3 чиглэлээр ажиллах байх. Эрх зүйн чиглэлээр нэг ажиллах байх. Барилгын сайд нэг болж ажиллах байх. Энэ салбар чинь орон нутагт барилга байшин, ажиллах орчин нөхцөл бол үнэхээр дутагдалтай байгаа. Нямдорж сайдыг барилгын сайд өчнөөн олон барилга л барьдаг гээд ингээд шүүмжлээд байдаг. Барихаас ч өөр аргагүй шүү дээ.

3-д цалин мөнгөний асуудал. Энэ ажилтнуудын салбарын. Тэгэхээр та одоо ажилтай салбар.../минут дуусав/

Дам.Цогтбаатар: Нэмээд тодруулж асуух боломж олгоё.

Ц.Сандаг-Очир: Тэгэхээр энэ салбарын ажилчдыг тогтвортой ажиллах чиглэлээр өнөөдөр таны эрхэлж байгаа салбарынхны хүний нөөцийн асуудал ямар байна. Орон тоо хэр дутагдалтай, хангалттай байна. Аль аль салбар дээр. Дутагдалтай байгаа салбаруудын гол шалтгаан нөхцөл бол ерөөсөө ажлын ачаалал, ажлын дарамт, цалин мөнгө шүү дээ. Тэгээд харьцангуй өнгөрсөн 4 жил бид нар бас тодорхой хэмжээнд салбарын ажилтнуудын цалинг нэмэгдүүлсэн. Гэхдээ мэдээж бүрэн хангалттай байж чадаагүй.

Цаашидаа энэ салбарын ажилтнуудыг тогтвортой ажиллуулах чиглэлээр цалин мөнгөний асуудал рэх 2025 оны төсөв дээр ТҮ, ТЗ-ийнхэн бол орон нутгийн 20 хувийн нэмэгдэлд хамрагддаг болсон. Харин ТТ-ийнхэн хамрагдахгүй байгаа. Энэ дээр та цаашидаа Сангийн яамтай ярьж ирэх жилийн төсөв одоо боогдож орж ирэхээс өмнө энэ асуудал дээр анхаарал хандуулахгүй бол цаашидаа ер нь төрийн албан хаагчдын цалингийн сүлжээг нэг жишиг рүү оруулж, цалин нэмэх бол бүгдээрээ нэмдэг, нэмэхгүй бол бүгдээрээ нэмдэггүй байх энэ тогтолцоо руу оруулахгүй бол нэг салбар нь нэмэгдээд нөгөөдөх нь хаягддаг ийм асуудал байна.

Дам.Цогтбаатар: Сангийн яам, Хүний эрхийн комисс, тэгээд Хууль зүйн яам гэсэн дэс дараагаар явъя. Сангийн яам 9 дээр микрофон.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Төлөвлөлтийн хувьд бол асуудал байна уу гэж асууж байна. Тийм ээ. Төлөвлөлтийн хувьд бол бид нар бага зэргийн асуудал бол үүссэн. Жишээ болгож хэлэхэд таны хэлж байгаа Хүний эрхийн Үндэсний Комисс бол 20 хүн нь бол орон нутагт ажилладаг болж таарсан. Бид нарт бол бүртгэлээр яадаг вэ гэхлээр Хүний эрхийн Үндэсний Комисс гэдэг 1 л байгууллага байдаг. Тэр нь Улаанбаатар хотод байгаа гэдэг бид нар ойлголттойгоор орон нутгийн нэмэгдэл 20 хувийг тавиагүй байсан чинь 20 хүн нь бодитоор бол орон нутагт ажиллаж байгаа. Энэ нь бол нотлох баримттайгаа бол бид нарт ирүүлсэн учраас энийг бол яах аргагүй тусгахаас өөр аргагүй болсон ийм зүйл байгаа.

Шүүхийн ерөнхий зөвлөл ер нь Шүүхийн тухай хууль бол өөрөө шинэчлэгдээд, тэгээд цалин хөлсөө бас өөрсдөө тогтоох эрх нь бол гараад ирчихсэн байгаа. Үүнийх нь дагуу бол

шүүх өөрөө бас цалин хөлсөө тогтоосон. Үүнийх нь дагуу бол тэр дотоод захиргааны албан хаагчдынх нь цалин хөлсийг тогтоосонтой холбоотойгоор бол цалин дутагдсан ийм зүйл байгаа. Мөн төсөв батлагдсанаас хойш Үндэсний аудитын газар бол яг энэ Байнгын хороонд бол хамаарахгүй. Гэхдээ бас орон тоогоо нэмсэн зүйл гарсан. Тэр бол Их Хурлаар бас шийдвэр гарчихсан ийм зүйл байсан. Яг нөгөө Их Хурлын харьяа байгууллагууд дээр бас нэмээд хэлэхэд бол Төрийн албаны зөвлөл дээр бас яг ийм ижил кэйс гарч ирээд, бас ингээд цалин нэмэх асуудал орж ирж байгаа.

Хууль зүйн яамны хувьд бол ямар асуудал гарсан бэ гэхээр Хууль зүйн яамны төрийн тусгай байгууллагууд дээр бол төрийн үйлчилгээний албан хаагчдын бүртгэл бол манай цалингийн системд бас бүрэн гүйцэд ороогүй байж таарсан. Энд ороод ирэнгүүт нөгөө төрийн үйлчилгээний албан хаагчид нь бас 20 хувь, 40 хувиар нэмэгдлээ авах шаардлагатай болсон. Үүнтэй холбоотойгоор бол цалингийн зардлууд бол нэмэгдэж орсон байгаа. Тэгэхээр 2024 оны төсөв дээр бид нар тооцоо хийхдээ бол эдгээр тооцоонуудыг бол Хууль зүйн яам дээр бол алдсан байна лээ. Бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын хувьд бол илүү юу гэдэг юм төсөв батлагдсаны дараа хойноос нь шийдвэр гарсан зүйлүүд ингээд нөхөж орж ирж байгаа л асуудал болчихоод байгаа юм. Баярлалаа.

Дам.Цогтбаатар: Хүний эрхийн комисс. 4 дүгээр микрофон.

Д.Сүнжид: Хүний эрхийн Үндэсний Комиссоос Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. 2014 оны шийдвэрээр 21 аймагт, аймаг тус бүрд 1 референт ажиллуулах ийм шийдвэр гараад, түүнээс хойш аймаг болгоныг хариуцсан 1 референт ажиллаж байгаа. АА зэрэглэлээр явдаг. Төрийн захиргаатай адилхан шаардлага тавьдаг. Энэ 2019

оны Улсын Их Хурлын тогтоолоор эрх зүйн байдал нь тодорхойлогдож байна. Манай аймагт байгаа 1 референт бол бүх л өргөдөл, гомдлыг хүлээж авч байгаа аймаг дахь. Аймгийн төвдөө байрладаг. Тэгээд сумд болон аймгаас ирж байгаа өргөдөл, гомдлыг хүлээж авдаг. Хууль зүйн туслалцаа зөвлөгөө анхан шатын хүний эрхийн мэдээлэл өгдөг, сургалт хийнэ, сурталчилгаа нөлөөллийн ажил хийнэ, санал, дүн шинжилгээ судалгааны ажилд тусална гээд ийм чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаж байна. Танилцуулж дууслаа.

Дам.Цогтбаатар: Хууль зүйн яам. Алтангэрэл сайдын микрофон.

О.Алтангэрэл: Сандаг-Очир гишүүний хэлсэн яг энэ 3 чиглэлээр бол ерөөсөө ажиллахаас аргагүй. Тэгээд зарим зүйлийг бас яг ийм асуулт тавигдаж, боломж гарсан дээр хэлье гэж бодож байгаа. Тухайлах юм бол Хүний эрхийн Үндэсний Комиссоос Хууль зүйн яам руу, харьяа байгууллагууд руу шаардлага тавиад байдаг. Бүр нэр цохож хэлэх юм бол одоо энэ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага руу. Энэ цагдан хорих байрны чинь нөхцөл болохгүй байна. Дээвэр нь нурах гэж байна. Олноор нь хорьж байна гээд. Үгүй ээ, яг яс юм дээр жил болгон энэ хорих ангиудын бохирын цооног бөглөрчихлөө. Хамаг бохир нь хальчихлаа. Энийг шийдээд өгөөч гэхээр Сангийн яаман дээр шийддэггүй. Хойш нь тавьчихдаг. Тэгээд энэ жил бол би бүр өөрөө гуйсан юм. Сүнжид дарга, Хүний эрхийн комиссынхноос. Та хэд энэ Сангийн яам руу энэ асуудлыг тавиад өгөөч ээ гээд. Ер нь би бас хариуцлагатайгаар цаашаа яг энэ дээр мэдэгдэхэд Жавхлан сайд маань бас байхгүй байна. Ер нь цаашид энэ төсөв хөрөнгө тавиагүйгээс болоод.../минут дуусав/

Дам.Цогтбаатар: Алтангэрэл сайдын микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Цаашидаа энэ төсөв хөрөнгө тавиагүйгээс болоод хууль сахиулах байгууллагын албан хаагчид хүний эрхийн зөрчилтэй холбогддог байдал байж болохгүй гэж үзэж байгаа юм. Тэгээд би энэ төрийн ажлын залгамж чанар гэдгээр энэ түрүүчийн Хууль зүйн байнгын хороо, Хууль зүйн байнгын хорооны гишүүдэд бас талархмаар юм байна лээ. Манай энэ Хууль зүйн туслалцааны төвөөс авхуулаад, манай Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилчдын хоол, унааны мөнгөнөөс авхуулаад нэлээн ахиц гаргасан зүйлүүд байна лээ. Тэгэхдээ асуудал бол дуусахгүй байна. Дахиад зөндөө асуудал байна. Яг энэ байдлаар хүний эрхийг хангах чиглэлээр хууль сахиулах үйл ажиллагаа үр дүнтэй байх чиглэлээр 2025 оны төсөлд бид нар саналаа өгч байгаа. Энэ хэлэлцэж байгаа төсвийн тодотгол дээр ч гэсэн жишээлбэл, Дотоод Хэргийн Их сургуулийн боловсролд зориулсан 600 сая төгрөг ч гэдэг юм уу хасагдчихсан зүйлүүд байгаа. Тэгээд бид бол энийг зохицуулаад, цаашидаа бол харин энэ системийн шинэчлэлийн хүрээнд шаардлагатай байгаа төсөв мөнгөтэй холбоотой асуудал дээр та бүхнийхээ дэмжлэгийг аваад шаардлагаа.../минут дуусав/

Дам.Цогтбаатар: Одоо Даваагийн Цогтбаатар гишүүний микрофон өгье.

Дав.Цогтбаатар: Баярлалаа өдрийн мэнд. Би сая асуух гэж байсан асуултаа Сангийн яамны Санжаадорж даргаас тодруулга авчихлаа. Энэ аудитын дүгнэлттэй холбоотой Сангийн яамтай холбоотой тоонуудын зөрүү байсныг сая явчихсан. Болсон.

Дам.Цогтбаатар: Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Ингээд төсвийн тодотгол явж байна. Үгүй ээ, тэгээд энэ төсвийн тодотголоор 3 их наядын зарлага нэмээд байх шиг байна. Тэгээд

ингээд нэмээд байж болдог юм уу. Уг нь энэ ард түмний татвар төлөгчдийн мөнгөн дээр ариг гамтай хандмаар юм. Тэгээд цахимжаад байна гэж ярьж байгаа. Орон тоогоо багасгая гэж хэлж байна. Энэ юм нь ерөөсөө явдаггүй. Энэ хууль хяналтын манай энэ байгууллагын, манай харьяа байгууллагуудын энэ төсөв нь хэр зэрэг өөрчлөгдсөн юм. Нэмэгдсэн юм уу, хасагдсан юм уу. Ер нь ямар байгаа юм. Энэ мөнгө төгрөгтөө таарсан хэвийн үйл ажиллагаа явуулчих ийм боломж нь байгаа юу. Хэд хэдэн олон камеруудтай болсон. Тэгээд 2, 3 жил болоод л нөгөө камеруудаа сольдог, хольдог. Бусад хөгжилтэй улс оронд явж байхад бол нэг их нүдэн дээр цагдаа гарч ирээд байдаггүй шүү дээ. Ингээд бүгд камержчихсан байдаг. Тэрийг нь хараад сууж байдаг. Шаардлагатай үед бол гараад л ирдэг. Гэтэл тэнд мөнгө зарцуулаад байдаг. Ийм юм байдаггүй ээ.

Харин хэвлэл мэдээллийн байгууллага бараг шоу шиг юм хийж байна шүү дээ. Тэр тэнд явж байна. Энэ энд явж байна. Ийм юм болж байна гээд ийм байдалтай байх юм. Нөгөө талаар шударга ёс үнэтэй. Шүүхийн хараат байдлыг хангах талаар бид нар ажил хийж байгаа. Гэвч энэ талаар зөндөө л ажил хийх ёстой л доо. Сая тэр Сангийн яамны төрийн нарийн хэлэв үү. Шүүхийн төсөв нь тусдаа. Өөрсдөө цалин мөнгийг нь бодоод оруулж ирээд ингэдэг гээд. Дараа жилийн оны эхнээс авхуулаад л нөгөө тойргоор шүүхүүд байгуулагдах ёстой. Шаардлага хангасан 1 ч шүүхийн байр байдаггүй. Энэ талаар анхаарсан, хийсэн ажлууд байгаа гэж бодож байна. Тэр ажлын бэлтгэл хангагдсан уу. Тэрийг нэг тодруулмаар байх юм. Нөгөө талаар бол хэд хэдэн сонсголууд явж байсан. Энэ сонсголуудаар гэмт хэрэгтэй тэмцэх, үүнийг таслан зогсоох, энэ нөхцөл байдал бол нэг их сайнгүй юм байна л гэж харагдсан. Монголын ард түмэн бүгд харагдсан. Түүний дагуу арга хэмжээ нэг их олигтой ч явж чадаагүй.

Тэр хил хамгаалах байгууллагаас би тодруулъя. Үгүй ээ, тэгээд нүүрс чинь тэгээд ямар ч бүртгэлгүй гараад байдаг юм уу. Тэр гарахгүй байх нөхцөл боломж нь бүрдчихсэн үү. Уг нь тэр сервер, тэр компьютер, тэр жин энэ тэр нь одоо бүгд л ажиллаж байх ёстой шүү дээ. Тэгээд тэр талаар тухайн үед хэн ч, юу ч дуугараагүй. Ингээд явчихсан байгаа. Маш их хэмжээний мөнгө урсаад гарсан. Тэр 44 их наяд байхгүй болчихсон гэж яригдаад байдаг. Яг тийм юм байдаг юм уу. Байсан бол одоо энэ өөрчлөгдсөн үү. Энэ техник, тоног төхөөрөмжөө сольсон уу. Энийг бас тодруулах хэрэгтэй байна.

Дам.Цогтбаатар: Сангийн яам эхлээд хариулъя. 9 дүгээр микрофон.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийг бол бид хуульд заасан нөхцөл шаардлагын дагуу тусгаж бол оруулж ирсэн. Ингэхдээ бол зарлагыг 3,1 их наядаар, орлогыг 3 их наядаар нэмэгдүүлээд, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг бол -2 хувь дээр буюу одоогийн батлагдсан түвшинээс бол бууруулахгүй байхаар оруулж ирсэн. Ер нь зардлыг багцаар нь аваад үзэх юм бол нийт 3,1 их наяд төгрөгийн зардлын 85 хувь нь бол бүтээн байгуулалтын хөгжлийн хөгжлийн төслүүдийг хөдөлгөх ийм зардлууд байгаа. Энэ маань өөрөө бол эргээд бас хувийн хэвшилд очоод, эдийн засгаа идэвхжүүлээд, бас энэ нь бол үр ашгаа өгнө гэж бид нар тооцоогоо бол хийж байгаа. Ирэх 2025 онд үүний үр дүн бол тоон үзүүлэлтээр бол макро үзүүлэлтээр бол тодорхой харагдана гэж ойлгож байгаа.

Дараагийн ээлжид. Шүүхийн төсөв болон Хүний эрхийн Үндэсний Комиссын төсөв бол Хууль зүйн байнгын хороогоор хянагдаад Сангийн яаманд орж ирдэг.

Энэ дагуу сүүлийн 3, 4 жил ингээд төсөв бол орж ирж байгаа. Ирэх жилүүдэд Шүүхийн шинэ хууль маань бол батлагдсан. Шүүхийн үйлчилгээг аятай тухтай өргөх зорилгоор төсөв бол 2025 оны төсөвт бол тодорхой хэмжээгээр тусаад орж ирж байгаа. Тэгээд 2025 оны төсвийг бол тэгэхдээ бид Засгийн газрын хуралдаанаар энэ 3 дахь өдөр хэлэлцүүлээд, Засгийн газрын нэгдсэн байр суурь гараад ингээд бол ирэх 9 сарын 1-ээс өмнө буюу сүүлийн ажлын өдөр 9 сарын 30-нд өргөн барихаар ажиллаж байна. Баярлалаа.

Дам.Цогтбаатар: Шүүхийн ерөнхий зөвлөл. 5 дугаар микрофон.

Л.Энхбилэг: Ганбат гишүүний асуултад хариулъя. Хавар бид нар Шүүх байгуулах хуулиа батлуулсан. Шүүхийн тогтолцоо өөрчлөгдсөн. Нийслэлийн дүүргийн шүүхүүд бол дагнасан тойргийн шүүх болсон. Шинээр хялбар ажиллагааны шүүх байгуулагдаж байгаа. Энэ хялбар ажиллагааны шүүх өнөөдөр байрлах байр бол огт байхгүй. Тийм учраас бид нар урсгал зардал дээр санал өгсөн. Энэ шүүхүүд байгуулагдаж байгаатай холбогдуулаад бид нар багаж, тоног төхөөрөмж, тавилгынхаа бас төсвийг тавьсан байгаа. Нийтдээ бид нар бол 9,4 тэрбум гэж санал өгсөн. Одоогийн байдлаар бол 4,8 нь бол зайлиггүй шаардлагатай техник, тоног төхөөрөмж, урсгал буюу хөрөнгө оруулалтын зардал байгаа юм. Энийг шийдэхгүйгээр бол 2025 оны 1 сарын 1-ээс шүүхийн үйл ажиллагааг хэвийн явуулахад бол хүндрэлтэй байна. Одоогийн байгаа нөхцөл байдал маань ч гэсэн маш хүнд. Бид нар Хан-Уулын 21 дүгээр хороонд бол шүүхийн цогцолбор барилга барихаар 2024 онд 5 тэрбум төгрөг тавиулсан. Тэрнийхээ ажлыг хийгээд цахимжилтынхаа ажлыг хийгээд явж байгаа.../минут дуусав/

Дам.Цогтбаатар: Гүйцээгээд хариулъя. 5 дугаар микрофон.

Л.Энхбилэг: Баярлалаа. 2025 ондоо хөрөнгө оруулалт дээрээ бид нар 36,8-ыг бол тавьсан. Яг нийслэлдээ. Нийт бол хөрөнгө оруулалтын зардал 105 тэрбумаар бол тавиулчхаад байгаа. Тэгээд энийг баталж өгнө гэдэгт бол итгэлтэй байгаа. Ерөнхийдөө шүүхийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулахгүй бол хэргийг хуулийн хугацаанд шийдвэрлэхэд хүндрэлтэй байгаа. Би тэгээд Заяабал гишүүнд бас энэ хуулийн хугацаа, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулийн хугацаатай холбоотой мэдээллийг жичид нь өгье. Болсон.

Дам.Цогтбаатар: Өөр хаанахаас байлаа. Хил хамгаалах газар. Гааль бас хариулах нь зөв байх даа. Түрүүний асуултад. 8 дугаар микрофон.

Л.Лхагвасүрэн: Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хошууч генерал Лхагвасүрэн. Ганбат гишүүний асуултад хариулъя. Хил хамгаалах байгууллагын үндсэн үүрэг бол Улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албыг зохион байгуулах, боомтоор зорчигч, ачаа, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх үндсэн үүрэгтэй. Нүүрс нээгдэж байгаа энэ асуудалд болохоор ачааны бүрдүүлэлтийг гаалийн байгууллага хариуцдаг. Тэгэхээр тухайн машин дээр хэдэн тонн ямар ачаа ачсан, татвараа төлсөн эсэхийг нь шалгаад гаалийн байгууллага бол нэвтрүүлдэг. Манай 2-ын хооронд бол тоо зөрсөн асуудал бол бий. Манайх бол зорчигч тээврийн хэрэгслийг Хятадын талтайгаа 7 хоног тутам, сар тутам тулгаж байдаг учраас манай тоо бол эцсийн байдлаар бол үнэн гэдгийг түрүүчийн сонсголууд дээр бол манайх гаргаж өгсөн. Одоо Гаалийн байгууллага, манай 2-ын хооронд бол цахим холболтууд бол хийгдсэн. Өдөр тутамд нэвтэрсэн машин, хүнийхээ тоог бол солилцож байгаа. Ачааны жин, хэмжээ, ямар ачаа гэдгийг Гаалийн байгууллага өөрийнхөө бүртгэл дээр бүртгээд явж байгаа. Өөр юмгүй ээ.

Дам.Цогтбаатар: Тэгэхээр тэр яг тодорхой тоо юмтай холбогдсон юм бол яах аргагүй Гаалиас л асуух асуулт л даа. Гаалиас хүн байна уу. Сангийн яам хариулах юм уу. Сангийн яам бас ч Гааль чинь яг Сангийн яамны харьяанд байдаг ч гэсэн Сангийн яам Гаалийг юу яаж хариулах хэцүү л дээ. Гаалиас хүн байхгүй байгаа юм уу. Тэгэхдээ сая Хил хамгаалах газар бол ер нь тоогоо бид нар нэгтгэдэг, одоо бол уялдаатай болсон. Түүнээс тоо зөрсөн гээд тэгж байна шүү дээ. Тэгээд тэр тоо зөрсөн дээр л гол асуудал гарч байгаа. Тэгэхдээ Сангийн яамны энд байгаа төлөөлөгчид хэлэхэд Ганбат гишүүний хариултыг Гаалийн газраас албан ёсоор бичгээр өг гэж дамжуулаарай. Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Яах вэ, ойлгомжтой. Гарын салаагаар л урсаж байдаг юм байна л даа. Тэр нүүрс энээ тэрээ юм нь. Тэгээд энэ хүмүүсийн цалин пүнлүүг олигтой ч нэмж чаддаггүй ийм байдалтай байдаг юм байна гэсэн дүгнэлтийг бол хийж болохоор байна. Нөгөө талаар манай энэ эргүүлийн цагдаа, хэсгийн цагдаа, энэ олон түмэнтэй шууд харьцдаг энэ цагдаа нарын нөхцөл байдал нь ямар байгаа вэ. Энэ орон тоо хангамж энээ тэрээ юмнуудыг түрүүн асуугаад байх шиг байсан. Хэвийн үйл ажиллагаа явуулах тийм боломж бололцоотой юу. Нөгөө гэмт хэрэгтэй. Харамсалтай нь одоо манай цагдаа нарт бол иргэд тэгж хэлээд байгаа л даа. Тэр жинхэнэ хулгайчдад, жинхэнэ луйварчидтайгаа тэмцэж чадаагүй байж та нар бид нартай юу ярьдаг юм бэ гэж. Үнэн л дээ. Энэ боломж, бололцоо, цалин мөнгө энээ тэрээ юм нь хангалттай байгаа юу.

Дам.Цогтбаатар: Цагдаагаас хүн байна уу. Та микрофонд суучих. 1 дүгээр микрофон.

Б.Батзориг: Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, хурандаа Батзориг илтгэж байна. Ганбат

гишүүний асуултад хариулъя. Цагдаагийн байгууллагын хэмжээнд орон тооны хувьд өнөөдрийн байдлаар 1 мянга гаруй орон тоо дутагдалтай байгаа. Ер нь жилийн дүнгээрээ ингээд дундажлаад үзэхээр байнгын 12 орчим мянгаас 1 мянга орчим орон тоо орж, гарч ийм хөдөлгөөнтэй байдаг. Орон тоо бол дутагдалтай байгаа. Засгийн газрын 153 дугаар тогтоолоор олон улсын жишиг стандартад нийцсэн нэг хүнд оногдох. Жишээлбэл 1 хэлтэст 50 мянган хүнд 1 хэлтэс, 8 мянган хүүхэд тутамд 1 хүүхдийн мэргэжилтэн, 5 мянган хүн тутамд 1 хэсгийн байцаагч гэхчлэн олон улсын жишиг стандартаар тооцохоороо ирээдүйд дунд хугацаанд, урт хугацаанд 6 мянга орчим орон тоо байж байж өнөөгийн одоо байгаа хүн амын тоонд цагдаагийн байгууллагын аюулгүй байдлын үйлчилгээг үзүүлэх боломжтой.../минут дуусав/

Дам.Цогтбаатар: 1 дүгээр микрофон гүйцээгээд өгье.

Б.Батзориг: Цалин мөнгөтэй холбоотой асуудлыг та бүхэн маань бол мэдэх байх. Одоо хуулийн салбарын хэмжээнд бол цалингийн шатлал нь бол хамгийн бага хэмжээнд байдаг. Мөн орон нутгийн хэмжээнд түрүүн ТЗ, ТҮ чиглэлийн алба хаагч нар одоо 20 хувийн нэмэгдэлтэй байдаг бол энэ нэмэгдэл бол цагдаагийн алба хаагч нарт бол олгогдоогүй ийм байдалтай байгаа. Танилцуулж дууслаа.

Дам.Цогтбаатар: Түрүүн Нара гишүүн санал өгсөн. Энэ нь ороогүй байна лээ. Тийм учраас хугацаандаа дэгийн дагуу асуулт асуух саналаа өгсөн байгаа. Нара гишүүний микрофоныг өгье.

М.Нарантуяа-Нара: Хүний эрхийн Үндэсний Комиссоо бас тодруулах зүйлс байна. 1 дүгээрт 2024 оны төсвийг бас нэмэгдүүлсэн байгаа нь нэг талаар маш таатай. Хүний эрхийг хангаж ажиллахын тулд бас тодорхой зардал чирэгдэл хэрэгтэй байдгийг сайн мэдэж

байна. Тэгэхдээ 2024 оны байдлаар 5 тэрбум төгрөг төсөвлөчихсөн. Одоо энэ 5 тэрбум төгрөгийн хэд нь ашиглалтын хүрээтэй, ингээд харж байхад дандаа урьдчилан сэргийлэх ажилд зарцуулагдаж байгаа юм байдаг болов уу гэж би харж байна. Дээрээс нь тодруулмаар байгаа зүйл нь бараа, үйлчилгээ гэж байна. Энэ ямар бараа зайлиггүй хэрэгцээ шаардлагатай вэ. Тэрийг бас танилцуулж өгөөч.

2 дугаарт одоо яг ажил гүйцэтгэлийн үр дүн энэ 8 дугаар сарын байдлаар үр дүнг хэмжих боломж байна уу. Хэдий хэрийн зардал нь урсчихсан, хэдий хэр нь үлдэгдэлтэй байгаа юм бэ.

3 дугаарт хохирогчтой холбоотой үүссэн асуудал. Одоо жишээлбэл өнгөрсөн хугацаанд энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын гаргасан зөвлөх санамж бол заавал биелүүлэх үүрэгтэй байгаа тээ. Цагдаагийн газар, Авлигатай тэмцэх газар гэхэд. Тэгээд энийг хэрэгжүүлээгүйгээс болоод 21 настай хүүхэд бас ингээд үнэхээр эрүүдэн шүүсэн гэсэн энэ цагдаа нарыг тодруулж чадаагүйгээр одоо энэ хүн өөрөө нас барсан байдалтай ингээд байж байгаа. Тэгэхээр дээрээс нь энэ хохирогч бий болсон тохиолдолд хүний эрхийн зөрчлийн улмаас хохирогч үүссэн тохиолдолд хохирогчийн сэтгэл санааны хохирол барагдуулах, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээний терапи гэдэг үйлчилгээнд энд аль нь орж байгаа бол энэ зардлын. Энийг би бас тодруулмаар байна.

Дээрээс нь цагдаагийн газрын энэ Хууль зүйн яам хариулах байх гэж бодож байна. Энэ ингээд дандаа том байдлаар хийчихсэн байгаа. Жишээлбэл тэр аймагт, тэр сумд гээд. Тэгэхээр энд дандаа жижиг баг, тосгонууд орхигдоод байдаг. Жишээлбэл, миний амьдарч байгаа Түнхэл тосгон гэхэд ойролцоогоор 4 мянга орчим, 3 мянга гаруй иргэний хууль, эрх зүйн үйлчилгээ авах ийм яаралтай хэрэгцээ 40км радиуст

амьдарч байгаа хүмүүсийн асуудлыг хэлэлцэхэд цагдаагийн машины хүрэлцээ дутна гээд ийм асуудлууд байгаа. Эд нарыхаа яг шигтгэж оруулж өгсөн юм уу. Тэд нарыхаа яаж оруулах юм бэ. Энэ эсвэл яг төсөвт бичигдсэн байгаагаараа сум, дүүрэг, аймаг гэдгээрээ явчих юм уу? Энэ багуудын хэрэгцээ шаардлага, тоног төхөөрөмжийн асуудлыг яаж шийдэх вэ гэдэг талаар тодруулмаар байна.

Дам.Цогтбаатар: Хүний эрхийн Комисс. 4 дүгээр микрофон.

Д.Сүнжид: Нарантуяа гишүүний асуултад хариулъя. Нийтдээ төсөв нь 2024 оны байдлаар 5,1 тэрбум. Эндээс урсгал зардал, тэр хөрөнгийн зардал, цалин хөлс нь нийлээд 60 хувь. Үлдсэн 40 хувьд нь бусдаар гүйцэтгүүлэх зөвлөх үйлчилгээ, судалгаа шинжилгээ, мэдээлэл сурталчилгаа, нөлөөллийн ажил, томилолтын зардал ордог. Хөрөнгө оруулалт 0. Ийм байдалтай төсвийн багцаа бол байгаа. Бусад тэр бараа, ажил, үйлчилгээ дээр юу вэ гэхээр ер нь нөгөө 21 аймагт сая тайлбарласан 21 аймгийн төвд референт ажилладаг гээд. Тэр хүмүүсийн голчлон эд хогшил авах тухай ийм байгаа. Төсвийн төсөөлөл нь. Одоогийн байдлаар бол яг графикайнхаа дагуу зарцуулалт нь явж байна. Тэгээд судалгаа, сурталчилгаа, дүн шинжилгээ, мэдээллийн нөлөөллийн ажил дээр үлдсэн төсөв бол байхгүй. Бүгдийг нь зарцуулсан. Цалин нь бол графикаараа. Хөрөнгө оруулалт байхгүй учраас тэгээд ийм зарцуулалттай явж байна. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа яах вэ Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулиар 7 чиг үүрэг хүлээдэг юм. Энэ дээр бол ер нь Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, Үндсэн хууль дээр зааснаар хүний эрхийг хангана, хамгаална. Хэрвээ эрх нь зөрчигдөх юм бол сэргээн эдлүүлнэ гэдгийг бүх төрийн байгууллага хүлээнэ. Урьдчилан сэргийлэх бол бүх төрийн байгууллагууд байдаг. Ялангуяа Засгийн газрын харьяаны бүх байгууллагууд хүлээдэг үүрэг юм.

Хүний эрхийн Үндэсний Комиссын хүлээдэг 7 чиг үүргийн хүрээнд санал, зөвлөмж өгнө. Улсын Их Хуралд. Хууль тогтоомжтой холбоотой олон улсын гэрээ конвенцод нэгдэж орох, эсэх дээр өөрийнхөө дүгнэлтийг өгнө. Гомдлоор иргэдээс ирэх юм бол бид нар тэрэнд нь ажиллагаа хийгээд, зохих хариуг нь өгөх үүрэгтэй байгаа. Илтгэлийг жил бүр өргөн барих үүрэг бид нар хүлээдэг. Түүнээс гадна хяналт шалгалтыг зохион байгуулна. Тэгээд хүний эрхийн чиглэлээр бүх төрийн байгууллагуудад санал гаргах үүрэгтэй байгаа. Нийгмийн түншлэлийг бэхжүүлэх үүрэгтэй иргэний нийгмийн байгууллага, төрийн байгууллагуудад. Тэгээд хүний эрхийг хангаж, хамгаалж, хуулиар заасан чиг үүргээ хэрэгжүүлж байна уу гэдэгт нь бол хяналт тавих ийм 7 чиг үүрэг хүрээтэй. Үүнийхээ хүрээнд бол бид нар нөгөө таслан зогсох, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, мэдээлэх, таниулах бүх үйл ажиллагааг зэрэгцүүлээд л хийдэг гэсэн үг.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бол тусдаа. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас илүү тодорхой мэдээлэл өгөх боломжтой. Тэнд чиг үүрэг нь, төсөв нь явдаг. Ийм байна.

Дам.Цогтбаатар: Цагдаагаас асуулт. Тэгэхдээ яах вэ, Хууль зүйн яам хариу гэж байна лээ. Цагдаа нь өөрөө хариулсан нь дээр байлгүй дээ. 1 дүгээр микрофон.

Б.Батзориг: Нарантуяа гишүүний асуултад хариулъя. Түүрүүн бас би саяын мэдээлэл дээр Ганбат гишүүний мэдээлэл дээр бол хариулсан байгаа. Цагдаагийн байгууллагын орон тооны хувьд бол өнөөдрийн байдлаар бол 1 мянга орчим орон тоо дутагдалтай байгаа гэдгийг бол хэлж байгаа. Энэ орон нутагт ажиллаж байгаа цагдаагийн байгууллагын алба хаагчдын ажиллах ажлын техник хэрэгсэл, машин техник, сум бүр цагдаагийн алба хаагчийг бүрэн гүйцэд байлгах чиглэлээр Цагдаагийн ерөнхий газраас, Хууль зүй, дотоод

хэргийн яам болон тухайн орон нутгийн аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга зэрэг эрх бүхий байгууллагуудтай бол байнга санал тавьж, хамтран ажиллаж байгаа. Өнөөдрийн байдлаар бол танд эргээд би мэдээлэл өгье. Шаардлагатай яг орон нутагт нарийн тоо нь хэд байна. Машин техник нь хэд байна гэдгийг эргээд би тан руу бас шаардлагатай мэдээллийг өгч болно.

Дам.Цогтбаатар: Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ингээд хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу. Нэрсээ өгнө үү. Баасанжаргал гишүүнээр тасаллаа. Заяабал гишүүний микрофоныг өгье.

Б.Заяабал: Баярлалаа. Тэгээд би сая энэ зорилтот түвшинүүдийг холбогдох манай ерөнхийлөн захирагчдаас асуусан байгаа. Тэгэхээр энэ зорилтот түвшнийг биелүүлэхийн тулд хамгийн гол нь энэ 2024 оны төсөв дээр та бүхний төсвийн асуудал нь шийдэгдэж чадсан уу гэдгийг би тодорхойлж гол нь мэдэж авахын тулд асуусан гэдгийгээ хэлье.

Ингээд төсвийн тухай нарын оруулж ирсэн энэ зорилтот түвшнийг биелүүлэхэд энэ 2024 оны төсөв тодотголоор орж ирж байгаа дүн болж байна гэсэн ийм хариулт өглөө гэж ингэж ойлгож байна. Ингээд дэмжье. Тэгээд та бүхний энэ зорилтот түвшний чанарын болон тоон үзүүлэлтүүдийн гүйцэтгэл дээр бас Хууль зүйн байнгын хорооны гишүүний хувьд цаашид бас хяналт тавьж ажиллах болно. Энэ дээрээ бас анхаарч ажиллаарай гэдэг ийм зүйлийг хэлье. Баярлалаа.

Дам.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Төсвийн тодотголыг зарчмын хувьд дэмжиж байгаа. Гэхдээ цаашид Хууль зүйн яам эрхлэх асуудлынхаа хүрээнийхээ байгууллагын алба хаагчдын цалингийн

ялгаатай байдлыг цэгцлээрэй нэг тийш нь. Тэгэхгүй бол тэгээд салбарынхан цагдаа нь нэмэгдэж байхад шүүх нь орхигдоод явдаг гэдэг юм уу, шүүхийн шийдвэрүүд нь гээгдээд явдаг гээд ялгаатай байдлууд байгаад байгаа шүү. Салбарын хэмжээнд цалинг нэмэх асуудал яригдвал бүгдийг нь л адилхан. Одоо сая тэр цагдаагийн албаны холбогдох хүн хэлж байна шүү дээ. Орон нутгийн нэмэгдэлд цагдаагийн албан хаагчид хамрагдахгүй байгаа л гэж байна. Тэгээд адилхан ажлаа адилхан л хийгээд л явж байгаа. Орон нутагт. Тэгээд ТЗ, ТҮ нь аваад байдаг. ТТ, цагдаа нь авдаггүй ийм ялгаатай байдал байгаа шүү. Тэгээд энийг цэгцлэх асуудлыг ирэх 2025 оны төсөвт Сангийн яамныхантайгаа уулзаж, ярилцаж нэг тийш нь шийдэх асуудлаа яриарай гэж нэгд хэлье.

2-т Алтангэрэл сайд энэ бүрэн эрхийн хугацаанд ажиллахдаа энэ шүүхийн нэгдсэн барилгын асуудал дээр та газар дээр нь очиж харж үзэж, энэ барилгын асуудлыг цаашид нэг тийш нь шийдэх, дутагдаад байгаа царцсан барилгыг ажилд оруулах тал дээр анхаарахгүй бол энэ үнэхээр хайран хөрөнгө оруулалт 10-аад жил болж байна. Суурийн ажил хийгдсэн. Бид нар бас Хууль зүйн байнгын хорооны шугамаар 2023 онд газар дээр нь ажиллаж байсан. Адилхан эхэлсэн прокурорын барилга нь баригдаад өнөөдөр ашиглалтад орчихсон явж байхад, шүүхийн барилга өнөөдөр ингээд 10 гаруй жил гацсан байдалтай байгаа. Тэгээд өнөөдөр Хан-Уул, Баянзүрх дүүргийн шүүхүүд Чингэлтэй Сүхбаатар дүүргийн шүүхүүд ямар орчин нөхцөлд ажиллаж байна. Шүүгч нар тэнд үнэхээр тэгээд хэрэг маргааныг чинь дийлэнх олонх нь тэр эвлэрүүлэн зуучлах үйлчилгээ, түүний одоо орчин нөхцөл үнэхээр яриад ч хэрэг алга. Ийм орчин нөхцөлд үнэхээр мэргэжилдээ үнэнч хэдэн шүүгч нар л ажиллаж байдаг юм байна лээ шүү дээ. Бид нар Шүүгч нар гэхээр баахан авлигын эзэд гээд ингээд

хараад байдаг хандлагатай болчихсон нийтээрээ. Гэтэл тэнд ажилдаа дарагдсан 1 шүүгчид дунджаар 200 хэрэг ноогдох ёстой бол өнөөдөр 800 хэрэг дээр ажиллаад, хэрэг уншаад сууж байна шүү дээ 1 шүүгч. Тийм учраас цаашидаа энэ шүүгч нарынхаа ажиллах орчин нөхцөл асуудал дээр онцгой анхаарал хандуулж, нэг ахиц шат дээшлүүлэх тал дээр нь та бас идэвхтэй ажиллана биз дээ. Энэ Сангийн яамтайгаа холбогдож. Тэгэхгүй бол бид нар ингээд шүүхийн салбар ярихаар л өндөр цалинтай гээд бас бодчихсон. Шүүгч нарыг. Одоо дунджаар 2.8, 3.4 сая төгрөгийн л цалинтай юм байна лээ шүү дээ шүүгч нар чинь. Энэ чинь манай уурхайчдын, зүгээр наад захын уурхайчны авдаг л цалин байхгүй юу. Хамгийн бага цалин. Тухайн үедээ өндөр байсан байх. Өнөөдөр бол өндөртөө орохгүй шүү дээ энэ цалин мөнгө. Тэгэхээр энэ хандлагыг өөрчилж, шүүгч нарын цалин ярихаар захиргааны албан хаагч нар нь бас орхигдоод явчихдаг юм байна лээ шүү. Захиргааны албан хаагчдын гэх мэтчилэн салбарын асуудал дотор нарийн ажил руугаа орох асуудлууд дээр дараа нь та бол Сангийн яамтай 2025 оны төсөв дээрээ маш их суух шаардлага гарна шүү. Тэгж байж энэ салбарынхны боловсон хүчний асуудал, нийгмийн асуудал дээр ахиц өөрчлөлт гарна л гэж би хувьдаа бодож байна.

Тийм учраас таныг одоо бас Барилгын сайдын ч ажлыг хийгээрэй. Нийгмийн хамгааллын сайдын ч ажлыг хийгээрэй. Хууль, эрх зүйн сайдынхаа ч ажлыг хийгээрэй гэж хэлээд байгаа нь энэ юм байгаа юм. Өөр хэлэх юм алга. Баярлалаа.

Дам.Цогтбаатар: Баасанжаргал гишүүнд микрофон өгье.

Х.Баасанжаргал: Хэд хэдэн саналын шинжтэй, гэхдээ бас нэгэнт хуулийн байгууллагын удирдлагууд маань байгаа учраас хэдүүлээ дараагийн 4 жилд бас анхаарах юмнуудаа бас

ярилцаад явчихвал зүгээр байх гэж бодож байна. Тэгээд 1 дүгээрт нөгөө процессын хууль тогтоомжийн шинэчлэлийн асуудал Засгийн газрын хөтөлбөртэй орж ирж байгаа. Тэгэхээр тэр дундаа энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн биелэлтийн байдал дээр бүгдээрээ бас анхаарахгүй ол шүүхийн нэр хүнд чинь яг энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэлийнхээ биелэлттэйгээ уялдаад байна гэдгийг та бүхэн маань бас маш сайн мэдэж байгаа. Тэгэхээр энэ дээр бодлогын ямар дэмжлэг байвал зохилтой вэ гэдэг дээр бас маш үр бүтээлтэй ийм саналаа бас гаргаасай гэж хүсэж байна.

2 дугаарт энэ шүүхийн цахим шилжилт гэж нэлээн идэвхтэй ярьж байгаа. Гэхдээ үүнд бас нөгөө хуульч, өмгөөлөгчдийнхөө оролцоог оруулаад ямар байвал илүү тохиромжтой вэ, арай илүү ээлтэй вэ гэдэг дээрээ бас жаахан хамтын шийдэл гаргаасай гэж бодож байна. Тэгэхгүй бол ер нь бол манай шүүхийнхэн өөрсдөө баахан юмнууд шийдчихээд л, тэгээд л дараа нь л танилцуулдаг шүү дээ. Тэгэхээр энэ байдал дээрээсээ бас нэг жоохон анхаараад хуульч, өмгөөлөгчдийнхөө оролцоог оролцуулаасай гэж бодож байна.

3 дугаарт энэ цагаатгах ажлын комисстэй холбоотой бас нэг санал байна. Энэ тэгэхдээ нэлээн зарчмын шинжтэй. Цаашид бас нэлээн яригдах байх гэж бодож байна. Хувь хүмүүсийн цагаатгалын асуудал мэдээж шийдэгдэж байгаа. Түүнээс гад ер нь бид нар дахиад энэ цагаатгалын асуудлыг энэ сүм хийдийн асуудал, тухайн үедээ эд хөрөнгөөрөө хохирсон, нураагдсан энэ сүм хийдийн хохирлын асуудлыг ер нь харах, судлах ийм зүйлийг бас нэг та бүхэн бодоосой. Тэгээд энэ тал дээр бас та бүхнээс холбогдох мэдээллийг авч хамтарч ажиллах ийм хүсэлтэй байгаа.

4 дүгээрт энэ Хил хамгаалах ерөнхий газар сая сонгуулийн үеэр хамгийн их гарсан зөрчил энэ түр хасав

гэдэг дээр маш их зөрчил гарсан. Хамгийн их гарсан зөрчил. Тэгэхээр яг энэ нөгөө хил хамгаалах тухайн үедээ ямар нөхцөл байдлаас болоод ингэж буруу мэдээлэл өгсөн юм уу. Эсвэл хүмүүс худлаа сошиалаар яваад байв уу. Энэ нэг үл ойлголцол яг энэ сонгуультай холбоотой үлдчихсэн байгаа. Тэгэхээр энэ асуудал дээр Хил хамгаалах газар анхаараад, удахгүй орон нутгийн сонгууль болно. Дахиад ийм асуудал үүсэх вий гэдэг ийм болгоомжлол байна.

5 дугаарт энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын орон нутгийн алба хаагчдыг би энэ удаа ёстой өмөөрөөд үг хэлчихмээр байна. 1 аймагт 1 хүн бол хаанаа ч хүрдэггүй. Тэгээд бид нар ялангуяа хүний эрхийн салбар дээр ажилладаг хүмүүс бол энэ орон нутагт ажиллаж байгаа алба хаагч нартай маш их хамтарч ажилладаг. Эд нараас маш их мэдээлэл авдаг. Маш их судалгаа авдаг. Тэгэхээр энэ орон нутгийн алба хаагчдын нийгмийн асуудал дээр бид нар бас хойрго битгий хандаасай. Энэ хүмүүсийн бас нөхцөл байдлыг маш сайн ойлгож, дэмжиж, болж өгвөл орон нутгийн алба хаагчдын орон тоог бол нэмэх ийм саналтай байна.

6-д эрт үеийн өмгөөллөөр хангах эрх дээр бас ахиц дэвшил гаргамаар байна. Эрт үеийн өмгөөлөгчөөр хангах эрхийн асуудал дээр. Нөгөө цагдаа мэдүүлэг авах гээд байдаг. Алив нэг таньдаг өмгөөлөгчөө дуудаад мэдүүлэг авсан болоод, өмгөөлөгчөөр хангасан болоод явдаг. Энэ хэлбэрийн асуудлаа бас хэдүүлээ бас арай өөр түвшинд гаргахгүй бол болохгүй байна гэсэн үг.

7. Би яг Сандаг-Очир гишүүнтэй санал 1 байна. Энэ шүүхийн үйлчилгээний нөхцөл байдал, хүйтэн, давчуу, хэргийн материалтай танилцах ямар ч боломж байхгүй. Үйлчлүүлэгчтэй хууль зүйн туслалцаа үзүүлэх ямар ч боломж байхгүй. Энэ нөхцөл байдал дээр бид нар анхаарахгүй бол худлаа л нөгөө хүний эрхийн асуудал чухал, хайртай гээд л

худлаа яриад байдаг хэр нь мөнгийг нь баталж өгдөггүй ийм л 4 жилийг битгий өнгөрөөгөөсэй гэж бодож байна. Тэгэхээр манай гишүүд ч гэсэндээ бас энэ дээр манай хуулийн байгууллагынхан аль аль талдаа хамтарч ажиллаасай гэж хүсэж байна.

Тэгээд хамгийн сүүлийн нэг санал. Гэрч, хохирогч хамгааллын асуудал дээр ерөөсөө ахиц дэвшил гарахгүй бол ерөөсөө энэ хамгааллын асуудал, ялангуяа энэ хохирогчийн хохирол барагдуулалтын асуудал маш муу. Энэ түвшин дээр ерөөсөө бодлогын томоохон шийдэл гаргах, тогтолцооны хувьд томоохон өөрчлөлт хийх ийм шаардлагатай юм байна. Тэгэхээр энэ дээр Хууль зүйн сайдыг анхаараасай гэж хүсэж байна.

Хамгийн сүүлд нь энэ цагдаа ч гэсэн адилхан хүн. Энэ хүний ард дахиад нийгмийн асуудал, ар гэрийн асуудал гэж байгаа. Сая бол бүр орон нутгийн нэмэгдэл өгдөггүй гэдэг чинь одоо юу гэсэн үг юм бэ. Тэгэхээр энэ.../минут дуусав/

Дам.Цогтбаатар: Нэмж хэлэх үү. Баасанжаргал гишүүний микрофоныг гүйцээгээд өгье. 1 минут шүү.

Х.Баасанжаргал: Тэгэхээр сая Хүний эрхийн Үндэсний Комиссын орон нутгийн алба хаагчдын орон нутгийн нэмэгдлийг нэмж орж байгаа шиг цагдаагийн алба хаагчдын орон нутгийн нэмэгдлийг ч гэсэн нэмж оруулах, дараагийн тэр 2025 оны төсөв дээр. Дээрээс нь нөхөж олгох гэдэг ийм төсөв орж ирээсэй гэж хүсэж байна. Тэгээд бүгдээрээ тал талдаа Засгийн газар, парламент, Их Хурлын гишүүд, Байнгын хороод, хуулийн байгууллагын салбарын ажилтнууд маш сайн хамтарч ажиллаж, хүний эрхийн асуудал дээрээ ахиц дэвшил гаргаасай гэж ингэж хүсэж байна. Баярлалаа.

Дам.Цогтбаатар: Баярлалаа. Ингээд гишүүд хэлэлцэж байгаа асуудлаар хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлж дууслаа. Одоо зарчмын зөрүүтэй санал гишүүдээс байгаа юу. Надад бол зарчмын зөрүүтэй 1 саналын асуудал байна. Энэ дээр бол Шүүхийн ерөнхий зөвлөлөөс энэ 2024 оны төсвийн зардлыг 4 тэрбум 811 сая төгрөгөөр нэмэгдүүлэх энэ хүсэлтийг оруулж ирсэн байгаа. Манай байнгын хороогоор. Тэгээд энэ дээр би зүгээр нэг товчхон тай тайлбар хийчихмээр байна.

Энэ зайлиггүй хийх ёстой ийм өөрчлөлт байгаа юм. Юу гэвэл нөгөө 4 байгууллагын төсвийг манай Хууль зүйн байнгын хороо дээр зангидаад, тэгээд бид нар Сангийн яаманд өгдөг юм. Энэ удаад тэгэхээр манай Хууль зүйн байнгын хороо чинь нөгөө 6 дугаар сард төсвийн асуудал эд нар хэлэлцэж байхад сонгуультай байсан болохоор хурал байхгүй. Тэгээд сая одоо ингээд хуралдаж байгаа байгаа болохоор бид нар дээр энэ санал төсвийн тодотгол дээр бол орж ирээд, манайхаар дамжаад холбогдох байгууллагууд руугаа явдаг. Тэгэхээр яг одоо энэ дээрээ бид нар энэ төсвийн асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс орж ирж байгаа энэ төсвийн асуудлыг ярьж тодотгож өгөхгүй бол болохгүй байгаа юм. Юу гэвэл түрүүний парламентын үеэр, Засгийн газрын үеэр Ерөнхий сайдын зүгээс шүүхийн чиглэлээр бас дутагдалтай юмнууд маш их байна шүү гэдэг дээр бол нэлээн шүүмжлэлтэй хандаж байсан. Тийм учраас Хууль зүйн байнгын хороонд энэ шүүмжлэлтэй хандаж байгаа нөхцөл байдлыг бид нар засахын тулд нэлээн хэдэн хуулиудад өөрчлөлтүүд оруулж өгсөн байгаа. Тэгээд энэ шүүхийн бүтэц дээр ч гэсэн, шүүх хуралдааныг явуулахдаа бүгдийг нь ил тод болгох тал дээр ч гэсэн бид нар анхаарч нэлээн олон юмнууд хийж өгсөн байгаа. Цахимжуулах тал дээр нь анхаарсан. Тэгээд сая Шүүхийн ерөнхий зөвлөлөөс оруулж ирсэн санал нэлээн өргөн юм орж ирэхэд нь бид нар зайлиггүй яг нэгэнт

хууль батлаад өгчихсөн. Тэр хуулийг хэрэгжүүлэхэд зайлиггүй шаардлагатай байгаа энэ нэмэлтүүдийг нь л хасаж байгаад үлдээж өгсөн байгаа. Тэгэхээр цахимжих асуудал, сая гишүүдийн яриад байгаа байрны асуудал. Үнэхээр байраа түрээслэх гээд байрны түрээслэх мөнгөгүй. Тэгсэн мөртөө энэ шүүхийн асуудлаа бид нар ил тод, шударга, шуурхай, иргэдэд хүрсэн байдалтай байх ёстой гээд байдаг. Үнэн хэрэг дээрээ хурал хийх гэхээр байргүй байгаа юм чинь хурлууд давхцаад, хурал нь хийгдэхгүй хойшилогдох зөндөө ийм тохиолдлууд гарч байгаа. Тэгэхээр энэ яг орж ирсэн асуудал бол нэгэнт Их Хурал батлаад өгчихсөн хуулиа хэрэгжүүлэх төсвийг нь баталж өгөхгүй бол үнэхээр болохгүй байгаа юм. Тийм учраас энэ дараах томъёололтойгоор оруулж ирж байгаа юм.

Энэ нөгөө Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны төсвийн зардлыг 4 тэрбум 811 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, нөгөө талаас хасах нь Төслийн 2 дугаар хавсралтын 11.2.3.1-д тусгагдсан зэвсэгт хүчний тоног төхөөрөмж. Улсын хэмжээнд хэрэгжих хугацаа 2024-2028 он. 2024 оны төсөвт өртөг 40 тэрбум 576 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний 2024 оны санхүүжих дүнгээс 4 тэрбум 811 сая төгрөгөөр зардлыг бууруулах гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал оруулж ирж байгаа юм.

Тэгээд энэ саналыг дэмжиж өгөхийг Байнгын хорооны гишүүдээсээ хүсэж байна. Үүнтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу. Зэвсэгт хүчнээс биз дээ. Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Алтангэрэл гишүүнээр тасаллаа.

Ц.Сандаг-Очир: Цогтбаатар дарга аа, саяынхаа 2 саналыг ахиад дэлгэрүүлж хэлээч. Юун дээр юуг нэмээд Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсөв нэмэгдүүлэх төсөв чинь яг юун дээр юм. Тэгээд тэр зэвсэгт хүчнээс хариулахгүй юм уу. Тэр 4.0 хэдэн тэрбумыг чинь авах

гэж байна шүү дээ. Тэгээд энэ жилийн батлагдсан төсвөөс чинь тендерээ зарласан юм уу, зарлаагүй юм уу. Тоног төхөөрөмж энэ чинь бас л чухал шаардлагатай байна гээд л төсөвт суулгаж байсан шиг санах юм. Тэгээд энэ худалдан авалт юмнууд чинь хийгдээгүй юм уу. Хийгдчихсэн байвал гэрээ юм байгуулагдсан юм байгаа юм уу. Гэрээ байгуулагдсан байвал төсөвт өртгийг нь бууруулж болохгүй шүү дээ. Тэгээд энэ дээрээ тайлбараа хэлэхгүй юм уу. Холбогдох хүн нь байгаа юм уу.

Дам.Цогтбаатар: Энэ дандаа нөгөө байрны түрээс зайлшгүй шаардлагатай. Одоо энийг хийж өгөхгүй бол нөгөө байрны чинь асуудал байхгүй. Энд зөндөө бид нар шүүмжилж яриад, шударга ёс яриад, бүгдээрээ л дор дороо ярьж байгаа. Сая Сандаг-Очир гишүүн та өөрөө ч ярьж байсан. Энэ мөнгийг төсөвлөж өгөхгүй бол энэ бид нарын баталсан хуулиуд чинь зүгээр л хэрэгжихгүй явахаар байгаа юм. Энэ дээр бол миний ойлгож байгаагаар би бас холбогдох хүмүүстэйгээ ярьж, зөвлөж хийж байгаа. Энэ дээр ямар нэгэн гэрээ контрактууд бол хийгдээгүй байгаа байх. Гэхдээ Батлан хамгаалах яамны хүн байгаа бол энэ дээр хариулж болно. Байхгүй байна. Алтангэрэл гишүүний микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Би нөгөө танин мэдэхүйн шинжтэй байж магадгүй шүү дээ. Танаас асуух гээд. Би сая нөгөө зарчмын зөрүүтэй санал байна уу гэхэд нь надад гаргах зарчмын зөрүүтэй санал байна л даа. Тэгээд тэр хэсэг нь ингээд алгасаад та шууд юугаа ярьчих шиг боллоо. Тэгээд дээрээс нь нөгөө бас шинэ гишүүн учраас танин мэдэхүйн шинжтэй юм асууж байж магадгүй. Би нөгөө өөрөө Сангийн яам руу явуулаад хасагдсаныгаа нэмүүлэх тийм зарчмын зөрүүтэй санал гаргах гээд байгаа хүн байгаа юм. Тэгэхээр тэр хэсэг нь өөр газраас яг таны саяын хэлдэг шиг тэндээс тэрийг аваад гэдэг гаргалгаагаа хэлэх ёстой юу. Тэгээд танин мэдэхүйн

шинжтэй л асуулт асуучихлаа. Уучлаарай.

Дам.Цогтбаатар: Тэгэхээр энэ зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя 64.7 хувиар санал дэмжигдлээ. Гишүүддээ баярлалаа.

Ингээд санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын төсвийн 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Заяабал болж байна уу. Заяабал Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Ингээд өнөөдөр хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууссан учир Хууль зүйн байнгын хорооны өнөөдрийн хуралдаан дууслаа. Гишүүддээ талархал илэрхийлье.

13.10 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ